МОНГОЛ УЛСЫН ШИНЖЛЭХ УХААН, ТЕХНОЛОГИЙН ИХ СУРГУУЛЬ
MONGOLIAN UNIVERSITY OF SCIENCE AND TECHNOLOGY

# ШУТИС-ийн оюутны клубүүдийн 2019-2020 оны хичээлийн жилийн намрын улирлын тайлан

Улаанбаатар
2019

**Тайлан эмхтгэн хэвлүүлсэн: ОСҮА-ны ахлах мэргэжилтэн,**
**доктор (Ph.D) Д.Цогзолмаа**
**Клубүүдийн нэгдсэн зөвлөлийн ахлагч: ГХС-ийн ТТО-III курсийн оюутан Э.Отгонбаяр**
**Хэвлэлийн хуудас: 210*297**
**ШУТИС Хэвлэлийн газар хэвлэв.**

Өмнөх үг

ШУТИС-ийн оюутны мэргэжлийн болон сайн дурын клубүүдийн үйл ажиллагааг их сургуулийн хувьд бодлогоор дэмжин хөгжүүлэх нь үр дүнтэй байна.

Клубийн гишүүн оюутнууд хүсэл, сонирхолоороо нэгдэн нэг баг хамт олон болж, хамтдаа хөгжиж, их сургуулийн оюутанд тулгамдаж буй асуудлуудыг шийдвэрлэхэд бодит хувь нэмэр оруулж байгаа нь клубүүдийн тайланд тусгагдсан үйл ажиллагаанаас харагдаж байна.

Клубүүд нь үйл ажиллагаагаа улирал бүр тайлагнан дүгнүүлж багш, удирдлагуудын санал, шүүмжийг сонсон үйл ажиллагаандаа хяналт тавьж сайжруулан ажилладаг.

2019-2020 оны намрын улиралд клубүүдийн тайлан хэлэлцэх хуралд оролцсон 33 клубийн тайланг эмхэтгэн 2 дахь удаагаа хэвлүүлэн нийтийн хүртээл болгож байна.

2019-2020 оны хичээлийн жилд ШУТИС-ийн түүхт 60 жилийн ой тохиож тус ойн арга хэмжээний томоохон нэг үйл ажиллагаа болох “Хөгжлөөр түүчээлсэн 60 жил” нэгдсэн арга хэмжээн дээр шилдэг клуб, шилдэг гишүүдээ тодорхойлон урамшуулснаас ШУТИС-ийн түүх 60 жилийн шилдэг клубээр ҮТДС-ийн график дизайн мэргэжлийн “WIZZ” клуб шалгарсан.

2019-2020 оны хийчээлийн жилийн хувьд оны шилдэг мэргэжлийн клубээр МХТС-ийн Электроник мэргэжлийн “Sys&CoTech” клуб, Сайн дурын шилдэг клубээр “AIESEC” клуб, Шилдэг клубийн ахлагчаар “Inspiration” клубийн ахлагч Ж.Мөнхчимэг, “Багшийн туслах оюутан” клубийн ахлагч Б.Бат-Ирээдүй нар шалгарсан.

Оюутны шилдэг бүтээлч клубийг дэмжин урамшуулах саналыг ШУТИС-ийн Сургалт, оюутны асуудал эрхэлсэн дэд захирал, Академич, ШУ-ны доктор (Sc.D) Х.Энхжаргал оюутнууддаа дэвшүүлсэн нь тэдний хамтын үйл ажиллагаа, цаашдын их амжилтыг дэмжсэн томоохон дэмжлэг болсон. Энэхүү Академич Х.Энхжаргалын нэрэмжит анхны шагналаар ҮТС-ийн Үйлдвэр дизайн мэргэжлийн “FINDE” клуб шалгарч шагналыг гардан авсан.

2019-2020 оны Клубийн шилдэг зөвлөх багшаар Хятад хэлний клубийн зөвлөх багш Ц.Эрдэнэзаяа шалгарч ШУТИС-ийн захирлын гарын үсэгтэй батламж, үнэ бүхий зүйлээр  шагнуулсан.

2019-2020 оны хичээлийн жилийн хаврын улирлаас эхлэн ШУТИС-ийн Клубүүдийн нэгдсэн зөвлөлийн даргаар шилдэг ахлагчаар шалгарсан “Багшийн туслах оюутан” клубийн ахлагч Б.Бат-Ирээдүй ажиллахаар тодроод байна.

Ийнхүү амжилт бүтээл арвин 2019-2020 оны хичээлийн жилийн намрын улирлын клубүүдийн тайлангийн эмхтгэлийг та бүхэндээ толилуулж байна.

2018-2019 онд Клубүүдийн нэгдсэн зөвлөлийн ахлагчаар ажилласан ГХС-ийн ТМО-III курсийн оюутан Э.Отгонбаярын тайлан

ШУТИС-ийн оюутны сайн дурын болон мэргэжлийн клуб нь оюутны санал санаачлагад тулгуурлан үүсгэн байгуулагддаг бөгөөд ОСҮА-аас удирдлагаар ханган хамтран ажилладаг. ШУТИС-ийн оюутан бүрийг хөгжүүлэх, төлөвшүүлэх, баг хамтын ажиллагаа хийгээд харилцан суралцах буюу оюутан оюутандаа нөлөөлөхөд клуб, клубийн систем ихээхэн үр нөлөөтэй юм.

Клубийн системийг ерөнхийлөн авч үзвэл



Клубийн системийг хөгжүүлэх үйл явц[1]:




Одоогийн байдлаар ШУТИС-д нийт 56 клуб бүртгэлтэй байгаагаас 30 орчим клуб үйл ажиллагаагаа эрчимтэй явуулж 1408 оюутнуудыг хамруулан ажиллаж байна. Үүнээс мэргэжлийн клубүүд 777 гишүүн буюу 55.2 хувийг, сайн дурын клубүүд 567 гишүүн буюу 40.2 хувийг , харин урлагийн клубүүдийн хувьд 68 гишүүн буюу 4.6 хувийг эзэлж байна. Мөн графикаас ажиглахад II дамжааны оюутнууд клубд илүү идэвхтэй хамрагдаж байгаа бол төгсөх дамжааны оюутнуудын хувьд хамгийн бага оролцоотой байгаа нь харагдаж байна. Бүх клубийн хувьд гишүүд гэдэг амин сүнс нь байдаг бөгөөд ихэнх клубүүдийн хувьд шинээр орж ирж буй I дамжааны оюутнуудад чиглэн үйл ажиллагаа явуулахыг зорьдог.

[1] Д.Цогзолмаа., (2019) “Их сургуулийн оюутны нийгмийн үйлчилгээний өнөөгийн байдал, цаашдын чиг хандлага” нэг сэдэвт бүтээл. 88 т




**Клубүүдийн ахлагчдын мэдээлэл**

| № | Клубийн нэр | Үйл ажиллагааны чиглэл | Ахлагчийн нэр | Утас |
|---|---|---|---|---|
| 1. | Whizz | График дизайн | Г.Идэр | 88649554 |
| 2. | IB biotechnology | Биотехнологи | Ө.Пүрэвжаргал | 99605465 |
| 3. | IDEA | Философи | Дэчмаа | 90585743 |
| 4. | Inspiration | Хувцас загвар | Ж.Мөнхчимэг | 94793342 |
| 5. | Цахилгаан хангамж | | Ц.Билгүүн | 88440787 |
| 6. | Цахилгаан шит | Цахилгааны инженерийн мэргэжлээр суралцдаг оюутнуудыг мэргэжлийн чадварыг дээшлүүлэх | Д.Ууганбаяр | 91166176 |
| 7. | Эрчим | | Э.Шижир | 89980256 |
| 8. | MUSTCAD | AutoCAD, REVET, Solidworks | Л.Билгүүн | 99700249 |
| 9. | СЭХ | Сэргээгдэх эрчим хүч | Н. Гэрэлчулуун | 99024310 |
| 10. | Цахиур | Програмчлал ба алгоритм тоцоолон бодох | Б.Төрмөнх | 88643428 |
| 11. | Эрдмийн индер | | О. Марал-Эрдэнэ | 90728670 |
| 12. | D-Art | Загвар дизайн | Э.Отгонзаяа | 80043478<br>86681148 |
| 13. | Sys&CoTech | | Б.Нямхүү | 95986464 |
| 14. | Хөгжлийн ирээдүй | Хувь хүний хөгжил | Б.Давааням | 95541998 |
| 15. | Vertect | Барилга архитетур | Төлөөлөл: Хулан | 95011197 |

| | | | | |
|---|---|---|---|---|
| 16. | NCN /New century nutrition/ | Хоол зүй | М.Төгөлдөрбаяр | 96075108 |
| 17. | Арга билэг | Хүнсний чанар аюулгүй байдал | Б.Нарнаа | 91400461 |
| 18. | Аравт | Барилга бүтэц,эрдэм шинжилгээ | А.Тамир | 95411442 |
| 19. | Green car | Бага оврын цахилгаан автомашин, Олон улсын тэмцээнд оролцох | Х.Сүхбат | 91251291 |
| 20. | Finde | Үйлдвэрлэлийн дизайн | Б.Идэрмөнх | 91025511 |
| 21. | Flair | | О.Номгон/дэд/ | 88222042 |
| 22. | Зохион бүтээгч залуус | Хичээлийн хоцрогдол арилгах, машин механизм зохион бүтээж, бүтээлч сэтгэлгээгээ хөгжүүлэх | А.Лхагвацэнд | 95226303 |
| 23. | Энергетик | Дулааны инженерийн мэргэжлээр сурдаг оюутнуудад мэдлэг мэдээлэл олгох | Б.Лхагвасүрэн | 95330313 |
| 24. | Залуу экологич | “Хүрээлэн байгаа орчин болон экологийн салбар ШУ” чиглэлээр суралцаж буй оюутан залуусын мэргэжлийн чадварыг дээшлүүлэх | Э. Түвшин-Ундрал | 99457826 |
| 25. | Архитектур урлан | | З.Бат-Эрдэнэ | 99949883, 85504666 |
| 26. | MSS 'Mining support and solution' | | Г.Баянмөнх- | 90101181, 89441121 |
| 27. | Ган гүүр КТК | | Ж.Амарсанаа- | 96689065, 95538973 |
| 28. | Opportunity | | Б.Болдсайхан | 85849190 |
| 29. | Supervizor enjineer | | Д.Нямцэцэг- | 99987556, 86960424,99059290 |
| 30. | C.C.S- Computer&communication security club | | О.Төгөлдөр | 86967485 |
| 31. | МОЛОР архитектор | | Б.Ганцоож | 80220111, 88077103 |
| 32. | Hi Tech клуб | | | |
| 33. | Звёздочка | | С.Пүрэв-Эрдэнэ | 98184426 |

| | | | | |
|---|---|---|---|---|
| 34. | | | | |
| 35. | Martins | Илтгэх урлаг, мэтгэлцээн, хувь хүний хөгжил | Э.Энхүслэн | 80093983 |
| 36. | Empowerment | Илтгэх урлаг, мэтгэлцээн | Г.Пүрэвсамбуу | 99206296 |
| 37. | AIESEC | Залуусын манлайллыг хөгжүүлэх, соёл солилцооны сайн дурын хөтөлбөр явуулах | З.Гантогтох | 88312198 |
| 38. | Тэмүүлэл | Спорт явган яалал | Бат-Эрдэнэ | 98885556 |
| 39. | Аянга | Спорт явган яалал | Н.Мөнхцоож | 99664674 |
| 40. | Хитонин | Япон хэл | А.Болор-Эрдэнэ | 80085331 |
| 41. | Герман хэл | Хэл | Э.Элбэгмөрөн | 88722282 |
| 42. | Хятад хэл | Хэл | Э.Минжмаа | 88310145 |
| 43. | English speaking club | Англи хэл | | 94254946 |
| 44. | | | | |
| 45. | Соёмбо | Хэв журам сахиулах | Б.Баяраа | 94870811 |
| 46. | Яруу найрагийн клуб | | М.Бямбацогт | 99344194 |
| 47. | Залуучуудын улаан загалмай | | Ц.Намуундаръяа | |
| 48. | БТОК | Багшийн туслах оюутан клуб | Б.Бат-Ирээдүй | 95755845<br>86247347 |
| 49. | Мэргэн шагайн харваа | | С.Бат-Эрдэнэ | 85455655 |
| 50. | MUST Comedy | | | 85332048 |
| 51. | Солонгос хэл | | | |
| 52. | Морин хуур | | Э.Мэнд-Амар | 89145498 |
| 53. | Хос уянга | Цэнгээнт бүжиг | Б.Лхагвабат | 89304300 |
| 54. | Хөтлөгч | | П.Болдсайхан | 85849190 |
| 55. | Дуулаач | | Т.Тулгабат | 88724858<br>85920914 |
| 56. | Чөлөөт бүжиг | Чөлөөт бүжиг | Б.Анх-Эрдэнэ | 99352057 |
| 57. | Анарваан | Ардын бүжиг | Б.Сумьяа | 99515404 |

Клуб тус бүр өөр өөрсдийн гэсэн онцлогтой байдаг бөгөөд үүнээсээ хамаарч гишүүн элсүүлж авах болон ажлын төлөвлөгөө нь хавар, намрын улиралдаа өөр өөр байдаг. Аливаа нэг клубийн ахлагчийн чадвараас тухайн клубийн үйл ажиллагаа ихээхэн хамааралтай төдийгүй өөрийн хичээл номны хажуугаар гишүүдээ идэвхжүүлэх, өдөр тутамын клубийн дотоод үйл ажиллагаагаа зохион байгуулах, төлөвлөгөө, төсөв, тайлан бичих, КНЗ-өөс болон ШУТИС-ээс зохион байгуулж буй үйл ажиллагаанд гишүүдээ оролцуулах, сайн үйлсийн аян гээд л чамгүй ачааг нуруун дээрээ үүрч явдаг.

Ахлагч бүрийн энэхүү нөр их хичээл зүтгэлийн үндсэн дээр ШУТИС-ийн клубүүдийн нэгдсэн зөвлөл бүрэлдэн тогтнож байдаг билээ. Клубүүдийн

нэгдсэн зөвлөлийн хувьд нэг хүн даргаар томилогдохоос илүүтэйгээр клубээрээ нэгдэж клубүүдийн нэгдсэн зөвлөлийн удирдах зөвлөлөөр ажиллах болсон энэхүү үйл ажиллагаа 2017 оноос хэрэгжиж эхэлсэн бөгөөд одоогийн байдлаар Хятад хэлний клуб хоёр дахь удирдах зөвлөлөөр 2018-2019 оны хаврын улирлаас эхлүүлэн 2 улирал буюу 1 жилийн хугацаанд ажиллалаа. Ингээд 2019 -2020 оны намрын улирлын КНЗ-ээс клубүүдийн дунд зохион байгуулсан нэгдсэн үйл ажиллагаануудыг танилцуулъя.

1. **Танд тусалъя аян /Чиглүүлэгч оюутан/**

Энэхүү үйл ажиллагааны хувьд шинээр оюутан болж орж ирж буй I дамжааны оюутнуудад клубүүд сайн дураараа тусламж үзүүлэх, заавар зөвлөгөө өгөх зорилготой. Шинээр оюутан болоход олон олон асуудал, эргэлзээ, өрөө байршил, төлбөр гээд л наад захын асууж лавламаар зүйлс цөөнгүй байдаг тэр бүгдэд тус дэм болж 8 клубийн 49 оюутан 2019.08.20-23 ны өдрүүдэд нийт 1000 гаруй оюутнуудад мэдээлэл өгсөн.

**08.20** нд Арга билэг клуб –I байр,Залууэкологич клуб - II байр

**08.21**нд Mind matters клуб – I байр, Эрдмийн индэр клуб – II байр

**08.22** нд ЗУЗ клуб – I байр, Хөгжлийн ирээдүй клуб–II байр

**08.23 нд** IB клуб- I байр, БТОК клуб- II байранд тус тус ажилласан




2. **Хичээлийн шинэ жилийн нээлтийн арга хэмжээ**

“Хөдөлмөрийн гавьяаны улаан тугийн одон”-т Шинжлэх ухаан, технологийн их сургуулийн 2019-2020 оны шинэ хичээлийн жилийн нээлт 8 дугаар сарын 28-ны өдөр ШУТИС-ийн задгай талбайд болсон . Энэ хичээлийн жилд Шинжлэх




ухаан, технологийн их сургуулийн сургалтын хөтөлбөрийг шинэ 2000 гаруй оюутан залуус сонгон суралцсан бөгөөд эдгээр оюутнуудад зориулж ШУТИС-ийн нийт клубүүдийг төлөөлөн 8 клуб нээлтийн үйл ажиллагаанд оролцож, клубүүдээ сурталчилсан.












3. **Клубүүдийн нээлттэй өдөрлөг**

Клубүүдийн нээлттэй өдөрлөгт оролцож шинээр гишүүн элсүүлж авсан клубүүдийн тоог сүүлийн 4 улирлаар харуулбал ихэнх клуб намрын улиралд илүүтэйгээр шинэ гишүүд элсүүлэн авах хандлага харагдаж байна. Энэ нь тухайн клубүүд улирал бүрд бус жилд нэг удаа гишүүнчлэлийн тоогоо нэмдэг болсон гэсэн үг юм. Ингэснээр бүтэн жилийн хугацааны туршид гишүүдтэйгээ ажиллах төлөвлөгөө боловсруулж гишүүн бүртэй тулж ажиллах, бие биенээсээ суралцах, баг хамтын ажиллагааны чадвараа сайжруулах, илүү ойр дотно баг хамт олон болох гэх мэт маш олон давуу талуудтай юм.




Энэ улирлын Нээлттэй өдөрлөгийн хувьд 2019 оны 09 дугаар сарын 25-27-ны хооронд БУХС, ҮТС, МХТС, МИС, Хичээлийн I,II байруудад зохион байгуулж 19 клуб шинээр 264 гишүүн элсүүлэн авсан.











4. **Хотын соёл- Баруун гарын дүрэм**

ШУТИС-н оюутны соёл, үйлчилгээний алба, Нийслэлийн цагдаагийн газрын Урьдчилан сэргийлэх хэлтэс, Нийслэлийн прокурорын газар, Замын цагдаагийн алба хамтран "Хотын соёл" аяныг жил бүр уламжлан зохион байгуулдаг бөгөөд үүний нэгээхэн хэсэг болох баруун гарын дүрмийг сахиулах аянд 2019.09.16-19-ны хооронд 4 клуб хамтран ажилласан.

**09.16-17 нд** ЗУЗ клуб II-байр,Соёмбо клуб I-байр

**09.18-19 нд** IB клуб – II - байр, Хятад хэл клуб I-байранд тус тус ажиллав.






5. **Клубүүдийн "Ахлагч нарыг чадваржуулах" сургалт**




2019 оны 11 сарын 28 өдөр "Ахлагч нарыг чадваржуулах сургалт"-ийг зохион байгуулсан бөгөөд сургалтад нийт 21 клубийн ахлагч нар оролцсон. Уг сургалтын арга хэмжээг нээж ОСҮА-ны ахлах мэргэжилтэн, доктор (Ph.D) Д.Цогзолмаа үг хэлсэн. Клубийн ахлагч нарыг чадваржуулахад чиглэсэн сургалтыг "Хятад хэлний клуб"-ийн зөвлөх багш, Доктор (Ph.D) Ц.Эрдэнэзаяа "Биеэ засаад гэрээ зас Гэрээ засаад төрөө зас" гэх үндсэн ойлголтын дагуу бидний оюутан насны эхлэлээс энэхүү 4 жилийн хугацаанд бид юуг хэзээ нь сурч авах ёстой байдаг хийгээд өөрт ногдох орон зайг эзэгнэж, хувь хүнээс бие хүний төлөвшил, үргэлжлээд төлөвшсөн хүн бусдыгаа манлайлах буюу нөлөөлөх ур чадварт суралцах гэх мэт багаас нь эхлээд ихрүү нь чиглэсэн маш олон үнэтэй мэдээллийг өгч



клубийн ахлагч нарт зөвлөн тайлбарласан бол ШУТИС-ийн КНЗ-ийн өмнөх тэргүүн Goldman Project LLC- ийн төслийн инженер Б.Мөнх-Эрдэнэ "Их сургуулийн 4 жил гэдэг бүх л зүйлийн бэлтгэл" гэх ерөнхий ойлголтын дагуу Клуб гэдэг зүйл нь оюутанд ямар чухал чадвар, хүмүүжлийг олгодог болон клубд элсэхээс аваад ахлагчын ажлыг эрхлэх хүртэл

ямар давуу талуудыг өөртөө суулгаж болох, клуб гэх хүрээллээс суралцсан чадвар, түүний үр шим их сургуулиа төгссөний дараа  ажлын байранд тавигдах шаардлагыг хангахад ямар их дэм болсон, одоо ажилд нь ямаршуу боломжуудыг олгодог гээд маш их үнэ цэнэтэй зөвлөгөөнүүдийг өглөө.



**Клубүүдийн нэгдсэн арга хэмжээ- шинэ жил**

2019.12.15-ний өдөр MYGO клубд мэргэжлийн болон сайн дурын нийт  20 клубүүдийг хамарсан клубүүдийн нэгдсэн шинэ жил, шилдэг клуб, шилдэг ахлагч нарын шагнал гардуулах ёслолын үйл ажиллагаа амжилттай зохион байгуулсан. 2019-2020 оны хичээлийн жилд идэвх санаачлагатай байж,  үйлс бүтээлээрээ бусдыгаа  манлайлсан шилдэг клуб болон шилдэг ахлагч нарыг дурдвал:

Шилдэг мэргэжлийн клуб:   “**Sys&CoTech” клуб**
Шилдэг мэргэжлийн клубийн ахлагч: **Ж.Мөнхчимэг /Inspiration клуб /**
Шилдэг сайн дурын клуб : “**AIESEC- ШУТИС” клуб**
Шилдэг сайн дурын клубийн ахлагч: **Б.Бат-Ирээдүй /БТОК-ийн ахлагч/**

Шилдэг зөвлөх багшаар Хятад хэл клубийн зөвлөх багш, ГХС-ийн ахлах багш, доктор (Ph.D) Ц.Эрдэнэзаяа нар тодорч ШУТИС-ийн 60 жилийн ойн клубүүдийн түүхийн хуудаснаа өөрсдийн амжилтаа мөнхөллөө.




Түүнчлэн энэхүү үйл ажиллагаанд КНЗ-ийн анхны тэргүүнүүд болох Э.Энхмандах , Б.Мөнх-Эрдэнэ нар хүрэлцэн ирж мэндчилгээ дэвшүүлсэн бол удаах тэргүүн У.Анударь арлын япон орноос бичлэгээр мэндчилгээ хүргэлээ. Мөн урлагийн клубүүдийг төлөөлж Дуулаач, Хос уянга, Анарваан клубүүд нийт клубүүддээ зориулж урлагийн тоглолтоор бэлэг барьж ШУТИС-ийн КНЗ амжилт бүтээлээр дүүрэн 2019 оноо үдэж 2020 оноо угтан авлаа.





ШУТИС-ийн клубийн эрх, үүрэг[2]

ШУТИС-ийн оюутнуудыг хөгжүүлэн төлөвшүүлэх, хамтран ажиллах, харилцан суралцахад чиглэсэн сайн дурын үйл ажиллагааг клубийн системээр оюутанд хүргэх буюу оюутан оюутандаа нөлөөлөх нь ихээхэн үр дүнтэй үйл ажиллагаа юм.

- ШУТИС-ийн оюутны санаачлагаар бий болсон клубүүдийн үйл ажиллагааг ОСҮА хариуцсан удирдлагаар ханган хамтран ажиллана.
- ШУТИС-ийн оюутны сайн дурын болон мэргэжлийн клуб нь оюутны санал санаачлагад тулгуурлан үүсгэн байгуулсан байна. Клуб зөвлөх багштай байж болно.
- Клуб нь өөрийн танилцуулгыг ШУТИС-ийн вебд байрлуулсан байна.
- Клубүүд ажлын тайлангаа улирал бүрийн сүүлийн долоо хоногийн баасан гарагт хэлэлцүүлнэ.
- Тайланг үндэслэн дараа улирлын ажлын төлөвлөгөөнд шаардагдах төсвийг холбогдох нэгжүүд, бүрэлдэхүүн сургуулиас авах боломжтой.
- Клубийн ажлын үр дүнг харгалзан клубийн ахлагч, идэвхтэй гишүүд, оюутан багш нарт кредитийн урамшуулал олгох журмын дагуу урамшуулна.
- Шинээр байгуулагдсан клубийн хагас жилийн ажлын үр дүнг харгалзан

[2] https://www.must.edu.mn/uploads/2016/10/26/klubiin-erh-vvreg.pdf

ОСҮА-наас батламж олгоно.

- Клубийн гишүүнчлэлийг нээлттэй хэлбэрээр авна.

**КЛУБИЙН ЭРХ:**

- Үйл ажиллагааг клуб дангаараа болон бусад клубүүдтэй хамтран зохион байгуулах

- Клуб өөрийн үйл ажиллагааны чиглэлээр их сургуулийн үйл ажиллагаанд идэвхтэй оролцох, санал дэвшүүлэх

- Клуб нь их сургуулийн аль нэг анги эзэмших болон хамтран эзэмших

- Клуб өөрийн үйл ажиллагааны хүрээнд их, дээд сургууль болон улс, олон улсын хэмжээнд тэмцээн уралдаан зохион байгуулах

- Клуб өөрийн үйл ажиллагаанд зөвлөгөө авах мэргэжлийн зөвлөх багш болон бусад байгууллагуудтай хамтран ажиллах

- Клуб төсөл хөтөлбөрт хамрагдах, Эрдэм шинжилгээний хурал, бүтээлийн үзэсгэлэн бусад уралдаан тэмцээнд оролцох

**КЛУБҮҮДИЙН ҮҮРЭГ:**

- Клуб нь гишүүдээ ШУТИС-ийн болон Клубүүдийн нэгдсэн зөвлөлөөс зохион байгуулж буй нэгдсэн арга хэмжээ, олон нийтийг хамарсан үйл ажиллагаанд идэвхтэй оролцуулах

- Тайлангаа цаг хугацаандаа хэлэлцүүлэн дүгнүүлэх

- ШУТИС болон бүрэлдэхүүн сургуулийн хэмжээнд оюутанд чиглэсэн шинэлэг, сайн дурын 1-2 ажлыг санаачлан хэрэгжүүлэх

# ШУТИС-ийн мэргэжлийн клубүүдийн тайлан

## 2019 оны шилдэг мэргэжлийн "Sys&CoTech"клуб 2019-2020 оны хичээлийн жилийн намрын улирлын тайлан

# “Sys&CoTech” клуб

## Товч танилцуулга

**Зорилго:** Бид компьютер, мэдээллийн технологийн чиглэлээр суралцаж буй оюутан залуust мэргэжлээрээ өсөж дэвшихэд өөрсдийн хувь нэмрийг оруулах зорилготой.

**Үйл ажиллагааны чиглэл:** Манай клуб нь олон төрлийн сургалт, тэмцээн, сайн дурын үйлсийг амжилттай зохион байгуулсаар ирсэн. Бид биенээсээ шинэ зүйлс суралцах, судлах, мэдээллээ солилцон илтгэл тавих, төрөл бүрийн аппликейшн, веб сайт хийх зэргээр чөлөөт цагаа үр дүнтэй өнгөрөөдөг.

**Гишүүнчлэл:** Идэвхтэн 27 гишүүн, зөвлөх 70 гаруй гишүүн

## Клубийн зохион байгуулсан дотоод үйл ажиллагаа

1. **Шинэ гишүүний элслэт /6-р долоо хоногоос 13-р долоо хоног/**

Манай клуб семистр бүр шинэ гишүүний элсэлтээ авдаг. Манай клубт элссэнээр олон олон шинэ боломж нээгдэх ба, ур чадвар болон багаар ажиллах чадвар нэмэгддэг. Энэ улирлын шинэ гишүүний элсэлтийг цахим болон хэвлэмэл зар хэлбэрээр түгээсэн. Нийт 29 оюутан анкет өгсөн бөгөөд үүнээс клубийн удирдах зөвлөлийн зүгээс авсан ярилцлага болон бусад шалгуурт тэнцсэн 7-н оюутан элсүүлсэн.







*Шинэ гишүүний элсэлтийн зарШинэ гишүүнээр элсэхийг хүссэн оюутнуудын анкет*




*Sys&CoTech клубийн гишүүнчлэлийн харьцаа*

2. **Social хуудсаар мэдээлэл хүргэх**

Техник технологи асар хурдацтай хөгжиж буй өнөө үед технологийн сүүлийн үеийн шинэлэг мэдээллийг #ҮнэнЗөв, #Цэгцтэй өгдөг #МэдээллийнСуваг дутмаг байна. Ихэнхи мэдээллийн эх сурвалжууд гадаад мэдээллийг мэргэжлийн бус хүмүүс орчуулж хүргэдэг учир мэргэжилийн нэр томъёог буруу илэрхийлсэн байх тохиолдол бий. Иймд бид мэргэжилийн түвшинд үнэн зөв мэдээллийг хүргэхээр зорьж байгаа юм.Та бүхэн бидний сувгийг дагаж #Sys&CoTech club -д нэгдээрэй.




*Sys&CoTech Club-аар мэдээлэл хүргэж байна.*




*Sys&CoTech Club-аар мэдээлэл хүргэж байна.*

## 3.10 жилийн хүрээнд зохион байгуулсан Giveaway

2019 онд манай сургуулийн 10 жилийн ойн баяр болж байгаатай холбогдуулсан манай клубийн зүгээс Giveaway явуулж 2 азтан онлайнаар шалгаруулсан.
1 азтан Hab Innovation Center-т дундын оффест 3 сар суух эрхийн бичиг.
1 азтан ESET NOD32 antivirus – 1 year lincense тус2 бэлэг болгон өгсөн.



Зар

### Клубүүдийн нэгдсэн үйл ажиллагааны оролцоо, идэвх

1. **Оюутны зөвлөл болон клубуудын нэгдсэн өдөрлөг**

Семистр бүрийн эхний долоо хоногт "Оюутны зөвлөл болон клубуудын нэгдсэн өдөрлөг" зохион байгуулагддаг. Энэ удаад манай клуб өөрсдийн үйл ажиллагааны чиглэл, өмнө нь зохион байгуулсан үйл ажиллагаа болон хийсэн бүтээлүүдээ оюутнуудад танилцуулах зорилготой оролцсон. Мэдээллийн технологийн чиглэлээр сурч буй оюутан залуусыг суралцаж буй мэргэжлийн хүрээнд харилцан туршлага солилцож клубийнхээ үйл ажиллагааг танилцуулсан.




*Танилцуулах үйл явцКлубийн нэгдсэн өдөрлөг 2019оны намар*

## 2.Сургалтын тайлан




*Сургалтын зар*

**Мэдээлэл, Холбооны Технологийн Сургуулийн Sys&CoTech клубийн зохион байгуулсан "NS204" кодтой "Компьютерийн сүлжээ-1" хичээлийн сургалтын тайлан**

Манай клуб нь 2009 оноос эхлэн МХТС-ын оюутан залуусын мэдлээгийг дээшлүүлэх , идэвхи оролцог нэмэгдүүлэх зорилготойгоор "NS204 кодтой Компьютерийн сүлжээ-1" хичээлийн сургалтыг 2019 оны намар зохион байгуулсан.

"NS204 кодтой Компьютерийн сүлжээ-1" хичээлийн сургалтанд МХТС-ын суралцаж буй оюутан I – II курсийн нийт 36 оюутан сургалтанд оролцсон.Уг сургалтанд нь 2019 оны 9 сарын 30-аас 11 сарын 29-ны өдрүүдэд МХТС-ийн 213тоот ангид Даваа /08:00-11:20 цаг дор орсон.

Мөн facebook групп үүсгэж оюутнуудтай шууд онлайнаар туслалцаа үзүүлж байсан.

**Хичээл заасан оюутан**

- С.Бямбадалай(B170970065)

**Сургалтаар орсон хичээлүүд**

Энэхүү сургалтын төлөвлөгөө нь тухайн долоо хоногийн лабораторийн ажлыг цуг хийх, зааж өгөх байдлаар явсан. Сургалтыг долоо хоногийн ажлын эхний өдрийн I, II цаг дээр байсан тул ирц бага зэрэг бага байсан тул ирж амжихгүй оюутнуудад зориулан youtube - ээр давхар хичээлийн видео бичлэг хийж оруулдаг байсан.

- 6-р долоо хоногт "Үндсэн ойлголтууд /Компьютерийн сүлжээ гэж юу вэ?/"

- 7-р долоо хоногт “Свитч /Төхөөрөмжийн ерөнхий үйл ажиллагаа, суурь тохиргоонууд/”
- 8-р долоо хоногт”VLAN, VTP /Протоколын тухай ерөнхий онол, юунд ашигладаг талаарх онол/”
- 9-р долоо хоногт “IPv4, IPv6 хаяглалт, хуваалт /IPv4, IPv6 хувиргах /”
- 10-р долоо хоногт “Веб сервер, DNS тохируулга /Хэрэглэгч веб хуудас үзэх зэрэг шаардлагатай тохиргоог хийх/”
- 11-р долоо хоногт “NAT, PAT тохируулга / Хаягийн хөрвүүлэлт /”
- 12-р долоо хоногт “Замчлалын протоколууд / RIP, RIPv2 динамик замчлал, протокол/”
- 13-р долоо хоногт “Свитчийн аюулгүй байдал, port security / MAC халдлага, MAC халдлагаас хэрхэн сэргийлэх/”
- 14-р долоо хоногт “Сорилд бэлдэх /Хичээлийн 30 онооны шалгалтанд бэлдэх/”

**ХИЧЭЭЛД СУУСАН ОЮУТНЫ НЭР БОЛОН ХЭДЭН УДАА СУУСАН ТОО**

| | |
|---|---|
| **1. B190910057 АДЯЖАРГАЛ** | **12** |
| **2. B190910033 БАЯРЖАВХЛАН** | **10** |
| **3. B190910036 МӨРӨН** | **12** |
| **4. B180970036 ДӨЛГӨӨНМӨРӨН** | **16** |
| **5. B190910037 ГЭРЭЛТ ОД** | **18** |
| **6. B180970029 ДӨЛГӨӨНБАЯР** | **10** |
| **7. B190910047 ШИНЭБАТ** | **18** |
| **8. B180970031 СУМЪЯАБАЗАР** | **13** |
| **9. B190910054 АНАНД** | **10** |
| **10. B180970045 БАТХОЛБОО** | **18** |
| **11. B190910039 ЭНХБОЛД** | **12** |
| **12. B180950040 НОМИН-ЭРДЭНЭ** | **12** |
| **13. B190910009 АРИУНСАНАА** | **18** |
| **14. B180910040 НОМИН-ЭРДЭНЭ** | **15** |
| **15. B180910006 МӨНЖХИН** | **10** |
| **16. B180970006 ТЭМҮҮЛЭЛ** | **18** |
| **17. B180920039 ОЧИРБАТ** | **6** |
| **18. B180920035 САМБУУЖАНЦАН** | **13** |
| **19. B180950041 ТӨГӨЛДӨР** | **9** |
| **20. B180920019 СҮХБАТ** | **7** |
| **21. B180920005 НОМИН-ЭРДЭНЭ** | **14** |

***Хүснэгт 1. Сургалтанд хамрагдсан оюутнуудын ирцийн дүгнэлт***




*Хичээлийн сайт*




*Сургалтын зураас*

## Мэдээлэл, Холбооны Технологийн Сургуулийн Sys&CoTech клубийн “Веб систем ба технологи” сургалтын тайлан

2019 оны “Веб систем ба технологи” сургалтаар статик болон динамик веб сайт хэрхэн хийх мөн ямар технологууд ашиглах талаар орсон. Сургалт нь 2019 оны 10-р сарын 1-ны өдрөөс 2019 12-р сарын 10-ны өдөр хүртэл клубийн болон сургуулийнхаа нийт I – IV курсын оюутнуудыг хамруулан сургалтаа орсон.

**Сургалтаар орсон хичээлүүд:**

- HTML,CSS,JAVASCRIPT хэлнүүдийн анхан шатны ойлголт

- Танилцуулга веб хийх
- PHP хэлний анхан шатны ойлголт
- Өгөгдлийн сангийн анхан шатны ойлголт
- Өгөгдлийн сангийн CRUD үйлдэл
- Аюулгүй байдал

| № | Овог/Нэр | Код | Дугаар |
|---|---|---|---|
| 1 | Б. Номин-Эрдэнэ | B180930039 | 88305006 |
| 2 | Б. Хишигдэлгэр | B180920023 | 80093695 |
| 3 | Б. Золбоо | B180930001 | 86070892 |
| 4 | Д. Ууганбаяр | B180930035 | 91166176 |
| 5 | М. Хатанбагана | B180930003 | 99045665 |
| 6 | М. Дөлгөөн | B180930017 | 95258389 |
| 7 | С. Шинэбаяр | B180960007 | 96002450 |
| 8 | М. Номин-Эрдэнэ | B180920005 | 94351314 |
| 9 | Х. Аманбай | B180930012 | 99973502 |
| 10 | Э. Дөлгөөнмөрөн | B180970036 | 96167645 |
| 11 | Б. Өвгөнбүргэд | B180930047 | 91000040 |
| 12 | Б. Нямхүү | B180930025 | 95986464 |
| 13 | Г. Мичидмаа | B180930018 | 89196880 |
| 14 | Ө. Насан-Өлзий | B180930004 | 80185003 |
| 15 | Э. Дөлгөөн | B180930010 | 99958852 |

***Хүснэгт 1. Сургалтын ирц***





*Вэб систем ба технологи Хичээлийн үйл явц хичээлийг зааж буй байдал*

**Мэдээлэл, Холбооны Технологийн Сургуулийн Sys&CoTech клубийн зохион байгуулсан “CS101” кодтой “Програмчлалын үндэс” хичээлийн сургалтын тайлан**

Манай клуб нь 2009 оноос эхлэн МХТС-ын оюутан залуусын мэдлээгийг дээшлүүлэх , идэвхи ороолцог нэмэгдүүлэх зорилготойгоор “CS101 кодтой програмчлалын үндэс” хичээлийн сургалтыг жил бүр зохион байгуулдаг.

“CS101 кодтой програмчлалын үндэс” хичээлийн сургалтанд МХТС-ын суралцаж буй оюутан I – II курсийн нийт 14 оюутан сургалтанд оролцсон.Уг сургалтанд нь 2019 оны 9 сарын 30-аас 11 сарын 29-ны өдрүүдэд МХТС-ийн 311тоот ангид Баасан/ 16:40-18.10 , 324 тоот ангид Лхагва /15:00-16:30 цаг дор орсон.

Хичээл заасан оюутнууд

- Б.Самбуужанцан(B180920035)
- Б.Хишигдэлгэр (B180930023)
- Г. Эрдэнэбат (B170930104)

Сургалтаар орсон хичээлүүд

- 6-р долоо хоногт “Үндсэн ойлголтууд /Си хэлний бичэглэл/”
- 7-р долоо хоногт “Нөхцөлт алгоритм/if,else if ,else, switch/”
- 8-р долоо хоногт”Давталт/while , do while ,for ,break, continue/”
- 9-р долоо хоногт “ Массив /ерөнхий ойлголт/”
- 10-р долоо хоногт “Функц /ерөнхий ойлголт/”
- 11-р долоо хоногт “Заагч/ ерөнхий ойлголт /”
- 12-р долоо хоногт “Тэмдэгт мөр / ерөнхий ойлголт /”
- 13-р долоо хоногт “Бүтэц / ерөнхий ойлголт /”
- 14-р долоо хоногт “Бататгал хичээл /онол /”



*Програмчлалын үндэс хичээлийн сургалт*

ХҮСНЭГТ 1. Сургалтанд хамрагдсан оюутнуудын ирцийн бүртгэл

ХИЧЭЭЛД СУУСАН ОЮУТНЫ НЭР БОЛОН ХЭДЭН УДАА СУУСАН ТОО

1. B190910057 АДЯЖАРГАЛ 12
2. B190910033 БАЯРЖАВХЛАН 9
3. B190910036 МӨРӨН 12
4. B190910037 ГЭРЭЛТ ОД 14
5. B190910047 ШИНЭБАТ 15
6. B190910054 АНАНД 10
7. B190910039 ЭНХБОЛД 12
8. B190910009 АРИУНСАНАА
9. B180910040 НОМИН-ЭРДЭНЭ 18
10. B180910006 МӨНЖХИН 10
11. B180920039 ОЧИРБАТ 6
12. B180950041 ТӨГӨЛДӨР 9
13. B180920019 СҮХБАТ 7
14. B180920005 НОМИН-ЭРДЭНЭ 14



*Програмчлалын үндэс хичээлийн сургалт*

**Шинжлэх ухаан технологийн ажилтны улсын анхдугаар их хурал**

Уг хурал нь Монгол Улсын Ерөнхий Сайд У.Хүрэлсүхийн ивээл дор 2019 оны 9-р сарын 26, 27-ны өдөр зохион байгуулагдсан. Монгол оронд шинжлэх ухаан, технологийн үйл ажиллагаанд төрийн болон хувийн хэвшлийн эрдэм шинжилгээ, судалгааны 65 байгууллага, эдгээрээс 35 төрийн өмчийн, 7 хувийн хэвшлийн эрдэм шинжилгээний байгууллага, 10 төрийн өмчийн, 13 төрийн бус өмчийн их сургуулиуд идэвхитэй оролцож байгаагаас энэхүү хуралд нийтдээ 650 орчим эрдэмтэн судлаачид ирж оролцсон. Хурлын зохион байгуулалтад ШУТИС-ийн МХТС-ийн мэдээллийн технологийн тэнхимийн багш, Sys&CoTech клубийн зөвлөх Б.Батцэцэг багшийн удирдлаган дор 2019 оны 9-р сарын 26, 27-

ны өдөр Sys&CoTech клубийн идэвхтэн гишүүн Б.Хишигдэлгэр хурлын бүртгэл, зохион байгуулалтын ажилд, Б.Мөнххүлэг төрийн ордонд зохиогдсон хүлээн авалтын бүртгэл, зохион байгуулалтын ажилд тус тус оролцсон.





*Зохион байгуулалтын эхний өдөр Зохион байгуулалтын хоёр 2019-9-26дахь өдөр 2019-9-27*





*Төрийн ордны хүлээн авалтХурлын хоёр дахь өдөр*

**Teach&Tech 2k19" арга хэмжээний тайлан**

Манай клуб нь 2019 оны хаврын улиралд Голомт банкны Digital мэргэжилтэн төслийн хүрээнд Internship хөтөлбөрийн үйл ажиллагааг зохион байгуулсан бөгөөд 2019 оны намрын улиралд Голомт банкнаас ерөнхий боловсролын сургуулийн мэдээлэл зүйн багш нар болон сурагчид, эцэг эхчүүдэд зориулан мэдээллийн технологийн салбарын давуу тал болон тулгарч буй асуудлуудыг хэлэлцэх арга хэмжээг зохион байгуулсан. Энэхүү арга хэмжээнд ерөнхий боловсролын сургуулийн багш нар, Их дээд сургуулийн багш нар, Мэргэжлийн сургалт үйлдвэрлэлийн төв, Програмчлалын кодын сургалтын төвүүд болон Их дээд сургуулиудын мэргэжлийн клубууд уригдан оролцсон. Уг арга хэмжээнд 2019 оны 10-р сарын 31-ний өдөр Sys&CoTech клубийн идэвхтэн гишүүн Ц.Нармандах, Ц.Бужмаа, Б.Батсайн нар  клубийн гишүүдийн бүтээлийг танилцуулсан, Б.Хишигдэлгэр болон Б.Мөнххүлэг нар Teach&Tech арга хэмжээний зохион байгуулалтанд тус тус амжилттай оролцсон болно.

| № | Бүтээгчийн нэр | Бүтээлийн нэр | Төрөл |
|---|---|---|---|
| 1. | Ucan | Б.Батсайн, З.Чинзориг | Аппликейшн |

| | | | |
|---|---|---|---|
| 2. | Iduz | Ц.Нармандах | Веб |
| 3. | Cityplace | Ц.Нармандах | Веб |

Бүтээлүүдийн жагсаалт







*Клубийн танилцуулгийн буланТанилцуулсан бүтээлүүд*





*Танилцуулгийн үйл явц*

**Мэдээлэл, Холбооны Технологийн Сургуулийн Sys&CoTech клубийн зохион байгуулсан “DEV HACKATHON STUDENT” тэмцээний тайлан**

Мэдээлэл, Холбооны Технологийн Сургуулийн “Мэдээллийн Технологи”-ийн салбарын дэргэдэх Sys&CoTech клуб нь 2009 оны 11 сард үүсгэн байгуулагдсан бөгөөд өдгөө 10 дахь жилдээ идэвхитэй үйл ажиллагаагаа явуулж байгаа оюутны сайн дурын нэгдэл. Бид компьютер, мэдээллийн технологийн чиглэлээр суралцаж буй оюутан залууст мэргэжлээрээ өсөж дэвшихэд өөрсдийн хувь нэмрийг оруулах зорилготой.

Манай клуб нь 2017 оноос эхлэн МХТС-ын оюутан залуусын чөлөөт цагийг зөв боловсон үр дүнтэй өнгөрүүлэх, мэдлэг боловсрол бүтээлч сэтгэлгээг хөгжүүлэх, идэвх оролцоог нэмэгдүүлэн хөгжилд нөлөөлөхүйц бүтээлүүдийг технологийн шийдлээр бий болгох зорилготойгоор “Hackathon Student” тэмцээнийг жил бүр зохион байгуулдаг.

“Dev Hackathon Student” тэмцээнийг 2019 оны 11 сарын 30, 12 сарын 01-ны өдрүүдэд Hub Innovation Center-ын дундын оффист амжилттай зохион байгуулсан. Энэхүү тэмцээнд мэдээллийн технологи болон бизнесийн чиглэлээр суралцаж буй бүх их дээд сургуулиудын I – IV курсийн нийт 20 баг 92 хүн оролцсон.

2019 оны “Dev Hackathon Student” тэмцээн нь өмнөх онуудад зохион байгуулагдаж байсан жилүүдээс дараах онцлогтойгоор зохион байгуулагдлаа. Үүнд :

1. Бүртгэл мэдээллийг www.eventbrite.com цахим хуудсаар хүлээн авсан.
2. Ерөнхий ивээн тэтгэгч байгууллагаар “Голомт банк” болон “Нийслэлийн Шинжлэх Ухаан, Үйлдвэрлэл, Инновацийн газар”, дэмжигч байгууллагаар “Hub Innovation Center”, “Эхлэл академи”, “Амжилт академи”. Мөн МУИС-ийн The Hackum клуб, Хүмүүнлэгийн Ухааны Их Сургуулийн LEGIT клуб нар хамтарч ажилласан.
3. Програмчлалын технологуудыг нэмэлт онооны журмаар оруулж өгсөн.






*Тэмцээний  нээлтэнд ирсэнГоломтбанкны хамт олон Тэмцээний бүртгэлийн үйл явц*











*Голомт банкны менторуудтай ярилцаж байна*









*Тэмцээнд оролцсон баг*






*Тэмцээний үдийн цайны цагаар*



*Тэмцээнд оролцогчид*

Тэмцээний хүрээнд 1, 2, 3-р байр мөн шилдэг номинациудыг шалгаруулсан. Түүнчлэн тэмцээнд оролцогчдоос хамгийн залуу оролцогчдийг тодруулж




урамшуулсан.

- 1-р байр: Hudson баг
- 2-р байр: Cotech solution баг
- 3-р байр: The Ada баг
- Шилдэг UI/UX дизайн: Hackum баг
- Шилдэг гүйцэтгэл: Nest lab баг



*Багуудын бүтээлээ танилцуулж буй үйл явц*




*Тэмцээний шүүх бүрэлдэхүүн*




*Шилдэг UI/UX дизайн номинац авсан баг“Hackит”*




*Шилдэг гүйцэтгэл номинац авсан баг “Nest Lab”*




*Тэмцээнд оролцсон хамгийн залуу оролцогчид*




*Гутгаар байранд шалгарсан баг “The Ada”*




*Дэд байранд шалгарсан баг "Cotech solution"*




*Тэмцээний тэргүүн байранд шалгарсан баг "Hudson"*



*Тэмцээний зохион байгуулалтын хамт олон*

# Академич Х.Энхжаргалын нэрэмжит анхны шагналаар шагнуулсан клуб.

# “FINDE” клубийн 2019-2020 оны хичээлийн жилийн намрын улирлын тайлан

**Клубийн зорилго, зорилт**

**Зорилго:** Үйлдвэрлэл дизайны мэргэжлээр суралцаж буй оюутнуудын ур чадварыг сайжруулах, оюутнуудыг хөгжүүлэх, баг хамт олон болон төслүүд дээр ажиллах, мэдлэг чадварт тулгуурлан практикт хэрэгжүүлэх, ирээдүйд чадварлаг дизайны багийг бүрдүүлэх зорилготой.

**Зорилт:**

- Хичээлээс гадуур оюутан залуусын сонирхол хүслийн дагуу мэргэших, үзэсгэлэн, уралдаан тэмцээнүүдэд оролцох

- Оюутнуудад тулгарсан асуудлыг баг хамт олноор зөвлөлдөн шийдэх

- Нийгэмд чиглэсэн бүтээлч ажлуудыг зохион байгуулах

- Оюутнуудыг хооронд нь холбох, харилцан биедээ зөвлөгөө өгөх, туршлага солилцох бололцоог бий болгох, хамтран ажиллах боломжоор хангах.

**Танилцуулга**

ШУТИС-ҮТС-ийн үйлдвэрлэл дизайны Finde клуб нь 2018 оны 09 сарын 17-нд албан ёсны нээлт хийж үйл ажиллагаагаа явуулж эхэлсэн. Үйлдвэрлэл дизайны анхны мэргэжлийн клуб бөгөөд мэргэжлээ сурталчлах, таниулах, оюутнуудын ур чадварыг сайжруулан хөгжүүлэхэд чиглэсэн үйл ажиллагаа явуулах зорилгоор нээгдсэн.

2018-2019 оны хичээлийн жилийн намрын улиралд үйлдвэрлэл дизайны 1-3 дугаар курсынхныг хамруулан нийт 80 хүн элсүүлэн авч одоогийн байдлаар 35 хүний бүрэлдэхүүнтэйгээр үйл ажиллагаа явуулж байна.



2019-2020 оны хичээлийн жилд клубийн үйл ажиллагааг хариуцан ажиллаж байгаа Б.Мөнхзул багштай ҮД-ийн 3-р курсын хамт олон



Клубийн үйл ажиллагааг намрын улиралд жил болгоны 3-р дамжааны анги хамт олон удирдан зохион байгуулж явуулна. Хаврын улиралд
шинэ гишүүдийг элсүүлэх үйл ажиллагааг явуулдаг.

**2019-2020 оны намрын улиралд**

1. ***Санаачлан зохион байгуулсан үйл ажиллагааны тоо-11***
2. ***Оролцсон үйл ажиллагааны тоо-4***
3. ***Хамруулсан оюутны тоо-30***
4. ***Сургуульд оруулсан хувь нэмэр- 60 жилийн ойн медалийн хайрцаг- 15 ширхэг 450000 төг***

   ***Бэлэг дурсгалын хүүхэлдэй- 70 ширхэг 56000 төг***

   ***Сургууль болон мэргэжлийн танилцуулга- 105 ЕБС-ын сурагчид***

5. Клубийн 2019-2020 оны хичээлийн жилийн ерөнхий зорилт
   - Оюутнуудыг хичээлийн бусад цагаар мэргэжлийн чиглэлээр чадавхижуулах
   - Оюутан бүрт хариуцлагатай байдлыг бий болгох
   - Мэргэжлийн программуудын зохих ёсны мэдлэг олгох
   - Гар ажиллагаа,компьютерын удирдлагатай тоног төхөөрөмж дээр ажиллаж бүтээгдэхүүн бий болгох
   - Мэргэжлийн онцлогоос хамаарч оновчтой шийдэл шинэ концепцын цуглуулгатай болох
   - Онцлох бүтээлүүдийг оюуны өмчөөр баталгаажуулах
   - Клубийн ашиг орлогоор нэгдсэн сан бүрдүүлэх
   - Өөрсдийн мэргэжлийг бусдад танилцуулж сурталчилж, сургуульдаа танигдсан идэвхтэй үйл ажиллагаатай клуб болох




2019оны 10сарын13Оролцсон гишүүд: 2-6р курсийн 80 оюутан багш нар





Явган аялал 1 Оролцсон гишүүд-15 2019оны 11сарын9



**Цуврал лекц 2** Оролцсон гишүүд-20 2019оны 11сарын 21

FINDE club-н оюутнуудын санаачлага, урилгаар зохион байгуулагдаж байгаа "Шилдэг төгсөгчидтэй хийх уулзалт"ын 2 дахь удаагийн зочноор "Үйлдвэрлэлийн Дизайн" мэргэжлээр 2019 оны хавар онцлох дипломтой төгсөгч Э.Анударь оролцож, тэтгэлэгт хөтөлбөрт хамрагдаж төлбөрөөс чөлөөлөгдөх боломж, дотоод гадаадын CAD/CAM-ын болон бусад уралдаан тэмцээнүүдэд хэрхэн амжилттай оролцох, Япон улсад ажиллах боломж зэрэг туршлагаасаа хуваалцалаа. Эхний уулзалтаар 2018 оны өвөл онцлох дипломтой төгсөгч М.Мөнхзаяа оролцож хос мэргэжлээр суралцах боломж сэдвээр уулзалт хийсэн бөгөөд үр дүнгээр нь одоо 2 оюутан График хөтөлбөрөөр хос мэргэжлээр суралцаж байгаа болно. Энэ уулзалтаас ч мөн үр дүн гарна гэж найдаж байна.



Аялал 2

Оролцсон гишүүд-20 2019оны 11сарын 26




**Лабораторын өрөөгөө шинэчлэх ажил ҮТС-210 тоот өрөө**

Одоо хийгдэж буй ажил




Одоо хийгдэж буй ажил: Үйлдвэрлэлийн
дизайн мэргэжлийг сурталчилан таниулах мөн өөрсдийн хийж гүйцэтгэсэн бүтээлийг сургуулийн орчинд танилцуулах зорилготойгоор Шинэ шилийн сүлд тодоо чимэглэн засаж байна.





ЕБС-н сурагчдад ШУТИС болоод үйлдвэрлэлийн
дизайн мэргэжилийг танилцуулах зорилготойгоор уг боршурыг бэлтгэн гаргалаа.




**Клубүүдийн нэгдсэн үйл ажиллагааны болон сайн дурын үйл ажиллаагааны оролцоо идэвхи**

**БНХАУ-ӨМӨЗО**



2019 оны 7сарын 2

Мэргэжлийн клүбүүдийн үзэсгэлэн 1




2019 оны 9 сарын 30

Чиний боловсрол монголын ирээдүй их сургуулиудын бүтээлийн үзэсгэлэн болоод ерөнхий сайдтай хийсан уулзалт.  Тус арга хэмжннгий үе ээр ерөнхий сайдад өөрсдийн хийж гүйцэтгэсэн бүтээлээ бэлэг болгон өгөв.  Оролцсон гишүүд-30

2019оны 10сарын 31





Мэргэжил танилцуулах лекц-1 Архангай аймгийн хайрхан сум ЕБС
хамрагдсан сурагчидийн тоо 62



Нийслэлийн Сонгино хайрхан дүүргийн ЕБС-н сурагчид. Хамрагдсан сурагчидийн тоо 43




**Үр дүн**



**Лабораторын өрөөгөө шинэчлэх ажил**





Үйлдвэрлэлийн дизайны бүтээгдэхүүн хөгжүүлэлтийн URTUU 212 brand-г үүсгэн байгуулав.




“World wine” бэлгийн сав баглаа боодол



Нэрийн бүтээгдэхүүний хөгжүүлэлт




Шутис-ын шилдэг оюутан : 2019-2020 оны клубийн ахлагч шилдэг оюутан.
тэмдгээр шагнуулав




Академич Х.Энхжаргалын нэрэмжит анхны шагналаар шагнуулсан



# “Залуу экологич” клубийн 2019-2020 оны хичээлийн жилийн намрын улирлын тайлан

## 1. Залуу экологич клубийн танилцуулга

Тус клуб нь 2015 онд Хэрэглээний шинжлэх ухааны сургуулийн үйлдвэр экологийн мэргэжил дээр тулгуурлан байгуулагдаж байсан ба одоогоор дараах чиглэлээр үйл ажиллагаагаа явуулаж байна.

Үйл ажиллагааны чиглэл:

- ✓ Мэргэжлийн багш нараас лекц, зөвлөгөө авах;
- ✓ Үйлдвэр, лабораториудтай очиж танилцах
- ✓ Экологи, байгаль хамгаалал болон түүний салбар ШУ-ны талаарх сүүлийн үеийн ололт амжилтуудын талаар мэдээлэллэх олон талын сургалт, судалгаа, олон нийтийн ажил зохион байгуулах
- ✓ Тэмцээн уралдаан болон ЭШХ-д баг хамт олноороо оролцох, бэлтгэх
- ✓ Байгаль орчинд ээлтэй үйл ажиллагаанд идэвхитэй оролцох

Клубийн зорилго

“Хүрээлэн байгаа орчин болон экологийн салбар ШУ” чиглэлээр суралцаж буй оюутан залуусыг нэгтгэн чадварлаг мэргэжилтэн, боловсон хүчин болоход нь тусалж дэмжих

Бүтэц зохион байгуулалт:

Клубийн ахлагч: Э.Түвшин-Ундрал

Нарийн бичиг:   Ц.Мөнгөнтуул

ЗАЛУУ ЭКОЛОГИЧ клуб нь удирдах зөвлөлийн 10 гишүүн  болон идэвхитэн 31 гишүүдээс бүрдэнэ.

## 2. Клубийн зохион байгуулсан үйл ажиллагаа

Клубийн үйл ажиллагааг 2019 оны 8 сарын 20нд эхний хурлаа хийж нээсэн ба 2019-2020 оны төлөвлөгөөг боловсруулсан.

2.1  Залуу экологич клубийн багш оюутнууд дунд уламжлал болсон "Эко аялал"-ыг Чингэлтэйн зүрх уулруу явган аялал хийн оргил хүртэл чиглүүлэх самбаруудыг өлгөн тохиржуулсан. /2019.10.28/



*Зураг 2. Чиглүүлэх самбаруудаа байршуулаж буй нь*

**2.2** “Тоон ертөнц-2019” улсын олимпиадын бэлтгэл 11.01-11.06 хүртэл гишүүдийн бэлтгэл зөвлөлдөөн блокын 301 тоот



*Зураг 3. Олимпиадын бэлтгэлийн дундуур цайлаж буй нь*



*Зураг 4. Клубийн MAP багийн гишүүд удирагч багшийн хамт*

**2.3** Arc GIS, ENVI программын сургалтанд клубийн 8 гишүүнээ “ArcGIS” сургалтын төвийн захирал Б. Цэцэгмаатай хамтран хамрагдуулсан. /2019.10.31/



*Зураг 5. Сургалтанд хамрагдаж буй 10 сарын 31ны өдөр*

**2.4** Сүхбаатар дүүрэгт байрлах албан бус хогийн цэгүүдийн мониторингийн судалгааг амжилттай гүйцэтгэсэн ба Нийслэлийн тохижилт үйлчилгээний албатай хамтран СБД-д харьяалагдах хороодоор 4багт хуваагдан албан бус 60 гаруй хогийн цэг үүссэн байсныг илрүүлэв. /2019.10.13/




*Зураг 6. Мониторингийн зарим үр дүнгийн зураглалаас*

### 2.5 Залуу экологич клубийн Үйлдвэрийн экологийн инженерийн оюутнууд ШУТИС-ийн 60 жилийн ойд зориулан мод тарих аяныг санаачлан зохион байгуулсан.

Аяны хүрээнд хаврын семестер клубийн гишүүд болон багш нар ҮЭИ-ийн 1-4-р курс, Нано шинжлэх ухаан, инженерчлэлийн 1-р курсын оюутнуудын хамтран нийт 27 гишүүн 5 багш Улаанбаатар хотын агаар, хөрсний хамгийн их бохирдолтой бүс Чингэлтэй дүүргийн 11-р хороо Дэнжийн мянгын 1 цэцэрлэг болон 11 айлын хашаанд 90 мод тарисан бөгөөд энэ намрын семестер моддынхоо арчилгаа ургалтан хяналт тавин дахин зөвлөмжүүдийг айл өрхүүдэд өгөв. Үр дүнгээс дурьдвал нийт тарьсан 90 ширхэг модны 85% буюу 76 ширхэг мод амжилттай ургасан байна.



*Зураг 7. Хаврын семестерт моддоо тарин хувиарлагдаж буй нь*





*Зураг 8. Тарисан модод маань ойролцоогоор 1м-1.3метрийн өндөр бүхий ургасан байна*




**2.6** Өгөх өдөр" Ид шидийн орон хандивын аян /2019.10.28-11.01 хүртэл/

Үндэсний өгөх өдрийн уриа #ЮуБайнаТүүгээрээ 11.01 өдөр Ид шидийн орон2 төсөлд зориулсан хандивын хайрцаг ШУТИС-ын 1-р байрны үүдэнд 10.28 -ны 14цагаас эхлэн 11.01-ны 15цаг хүртэл тавигдсан ба 5 өдрийн хугацаанд Ид шидийн орон-2 төсөлд хандив цуглуулан өглөө. Хичээлийн хэрэглэгдэхүүнүүд, малгай ороолт, хүүхдийн тоглоомнууд болон мөнгөн хандив буюу 66500 төгрөг маань өнөөдөр ×2 дахин үржигдэж ид шидийн орны дансанд 133000 төгрөг болон хандивлагдсан.





*Зураг 9. ШУТИС 1-р байрны үүдэнд 5өдрийн турш хандив цуглуулаж сууж буй нь*




*Зураг 10. Лантуун дохио тбб байгууллагын ид шидийн орон2 төслийн гишүүдэд хандиваа хүлээлгэн өгч буй нь*

**2.7** Баянхошууны хөтөлд байрлах Ачлалт хүүхдүүд тбб-ын ахмадуудын асрамжийн газар клубийн гишүүдийн зүгээс хүнс, ахуйн хэрэглэл, номнууд, хувцаснуудаар хандивын туслалцаа үзүүлэв /2019.12.06/





*Зураг 11. Ачлалт хүүхдүүд тбб-ын ахмадуудын асрамжийн газар хандив өгч буй*

## 3. Клубүүдын нэгдсэн үйл ажиллагаа

**3.1**“Залуу экологич клуб” Танд туслая аян

| | Нэрс | Салбар сургууль | мэргэжил | Утас |
|---|---|---|---|---|
| 1 | Э. Түвшин-Ундрал | ХШУС | ҮЭИ III | 99785930 |
| 2 | Нямдарь | ХШУС | ҮЭИ II | 93150317 |
| 3 | З. Сайнцаг | ХШУС | ҮЭИ III | 98800147 |
| 4 | Б. Намуундарь | ХШУС | ҮЭИ III | 99570401 |
| 5 | Номинтуул | ХШУС | ҮЭИ II | 86052385 |
| 6 | Т. Бөртэсэцэн | ХШУС | ҮЭИ III | 88783463 |

Эдгээр 6 оюутан 2019.08.20нд өглөөний 10 цагаас оройн 18 цаг хүртэл чиглүүлэгч оюутны үүргэ биелүүлэж ШУТИС-ийн II-р байрны үүдэнд мэдээлэл олгосон болно. Ажиллах хугацаанд нийт 40орчим шинээр элсэгч , эцэг эхчүүдийг мэдээллээр хангаж үүргээ амжилттай гүйцэтгэсэн.






*Зураг 12. Клубийн гишүүд танд туслая аянд оролцож буй нь*

**3.2** ШУТИС-ийн хичээлийн шинэ жилийн нээлтийн үйл ажиллагаан дээр клубийн нэмэлт элсэлтээр 5 шинэ гишүүн элсэв. /2019.08.28/




*Зураг 13. Шинэ гишүүдийн бүртгэл*

**3.3** Клубийн ахлагч нарын чадавхжуулах сургалт хамрагдав.



*Зураг 14. Клубуудын ахлагч нарын хамт 2019.11.28*

## 4. Үр дүн дүгнэлт

Уг намрын семестер төлөвлөсөн төлөвлөгөөний дагуу хийх ёстой 10 төрлийн ажилуудаа амжилттай гүйцэтгэлээ. Хаврын семестер хийж гүйцэтгэсэн ажилуудынхаа үр дүнг шалгсан явдал маань манай клубийнханд цаашид үйл ажиллагаагаа эрчимтэй явуулах урам зоригийг өгсөн бөгөөд сайн дурын тусламж хандивын үйл ажиллагаанд оюутан залуус маань үнэхээр чин сэтгэлээсээ идэвхи зүтгэлтэй, санаачилгатай оролцож чаддаг. Гэр хорооллолын айл өрхүүдэд агаар хөрсний бохирдолыг бууруулах зорилготойгоор мод тарих аян маань 85%-ийн амжилттайгаар хэрэгжсэн бөгөөд тус аянг илүү олон оюутан залуусыг хамруулан сайн үйлсийн аянгаа дахин өрнүүлэх боломжтойг онцлох хэрэгтэй гэж үзлээ.

# “GREEN CAR” клуб

## 2019-2020 оны хичээлийн жилийн намрын улирлын тайлан

**Агуулга:**

-Танилцуулга

-Зорилго

-Баг бүрэлдэхүүн, үйл ажиллагаа

-Олон нийтийн үйл ажиллагаа

**Бүрэлдэхүүн:**

Удирдсан багш: Д.Бадрах

Ахлагч: Х.Сүхбат

Гишүүд: Б.Бат-Эрдэнэ

С.Мэнджаргал

**Зорилго:**

“INTERNATIONAL STUDENT CAR COMPETITION” тэмцээндМонгол улс болон ШУТИС-ийг төлөөлөн оролцох зорилгоор 2013 онд байгуулагдан клубийнхээ үйл ажиллагааг тасралтгүй явуулж, тэмцээн уралдаан болон бусад арга хэмжээнүүдэд тогтмол амжилттай оролцож байна.

**Олон нийтийн ажил:**

- Оюу толгой компаны тэтгэлэгт хөтөлбөр танилцуулах өдөрлөг
- ШУТИС-ийн 2019-2020 оны хичээлийн шинэ жилийн нээлт
- ШУТИС-МехТС-ийн 2019-2020 оны хичээлийн шинэ жилийн нээлтэнд “INTERNATIONAL STUDENT CAR COMPETITION-2018” олон улсын тэмцээнд Хүрэл медаль хүртсэн бүрэн цахилгаан автомашинаа танилцуулж оролцсон.
- 2019 оны намрын улирлын сургууль орчмын их цэвэрлэгээ

**Одоогоор явуулж буй үйл ажиллагаа:**

Манай клуб 2019-2020 оны хичээлийн жилийн намрын улиралд өөрсдийн зохион бүтээж буй “Go kart” автомашины явах эд ангигэх мэт зүйлсийг хийж суурьлуулсан.

Уг автомашиныг хийх ажлыг 2018-2019 оны хичээлийн жилээс эхлэн хийж хэрэгжүүлж эхэлсэн. Автомашины рамын хийцийн зургийг “Салбарын танилцах дадлага” хичээлээр үзсэн инженерийн зураг төсөл боловсруулдаг Solidworks программ дээр зурж, зургынхаа дагуу хийж гүйцэтгэсэн.

**Үр дүн:**

Одоогийн байдлаар ажлын гүйцэтгэл 60-70 хувьтай явж байна.Ирэх оны хаврын улиралд манай клубийн хийж байгаа автомашин бүрэн ажиллагаанд орж дуусна.



**МОНГОЛ УЛСЫН ШИНЖЛЭХ УХААН ТЕХНОЛОГИЙН ИХ СУРГУУЛЬ**
**ҮЙЛДВЭРЛЭЛИЙН ТЕХНОЛОГИЙН СУРГУУЛЬ**

**КОМПЬЮТЕР ГРАФИК ДИЗАЙН ОЮУТНЫ МЭРГЭЖЛИЙН КЛУБ**
**ҮЙЛДВЭРЛЭЛИЙН ТЕХНОЛОГИЙН СУРГУУЛЬ**

# WHIZZ КЛУБИЙН ТАЙЛАН

## 2019-2020 оны хичээлийн жилийн намрын улирлын тайлан

**АГУУЛГА**


**НЭГДҮГЭЭР БҮЛЭГ – КЛУБИЙН ДОТООД ҮЙЛ АЖИЛЛАГАА**

1. Клубийн танилцуулга
2. Дотоод үйл ажиллагаа
   - 2.1. Идэвхижүүлэлт
     - Ойрын зайн явган аялал
     - Анги чимэглэл
   - 2.2. Мэргэжлийн үйл ажиллагаа
     - Зураач Д.Гунгааг мастер сургалт
     - Бүтээлийн үзэсгэлэн
     - Төгсөгчидын мастер сургалт
     - Stop motion анимаци
   - 2.3. Сурлага
     - Кредитын урамшуулал. Захирлын тушаал

**ХОЁРДУГААР БҮЛЭГ – ГАДААД ҮЙЛ АЖИЛЛАГАА**

1. Олон улсад мэргэжил суртачилах
   - Өвөр Монголын “Үндэсний Үзэсгэлэнгийн танхим”. Урлаг, дизайны хамтарсан үзэсгэлэн.
   - Японы Засгийн газрын “Sakura Science” оюутан солилцоо
2. Мэргэжлийн үйл ажиллагаа
   - TALK TALK ENGLISH 3 хэмжээст дүрүүдийн төсөл
   - ШУТИС-ийн хичээлийн шинэ жилийн нээлтийн үйл ажиллагааны урилга
   - Манлайлал-оролцоо-хөгжлөөр түүчээлсэн 60 жил
   - ШУТИС-ийн багш судлаачдын бүтээлийн 2IP уралдааны үзэсгэлэн дэглэлт
   - ШУТИС-ийн 60 жил концертын видео

**ГУРАВДУГААР БҮЛЭГ- ҮР ДҮН**

Онцлох үйл явц

# НЭГДҮГЭЭР БҮЛЭГ – КЛУБИЙН ДОТООД ҮЙЛ АЖИЛЛАГАА

## 1. Клубийн танилцуулга

"**WHIZZ**" клуб нь 2005 оноос хойш дизайны тэнхимийн эрхлэгч Д.Түмэнболд, ахлах багш Б.Мэндсайхан ба О.Гантулга, А.Цэрэндулам багш нарын удирлага дор оюутны хөгжил төлөвшил, мэргэжлийн ур чадвар, чөлөөт цагийг зөв боловсон өнгөрүүлэхэд анхааран үйл ажиллагаагаа явуулж байгаа мэргэжлийн клуб билээ.

**Клубийн зорилго:**

- Компьютер график дизайн мэргэжлээр суралцаж байгаа оюутануудад тухайн мэргэжилийг сурталчилах, түгээн дэлгэрүүлэх, дизайны хичээлийн онолын мэдлэгээ туршиж бататган, практикт хэрэгжүүлэх зорилготой.

**Клубийн зорилт:**

- Оюутан залуусын суралцах идэвхи, сонирхлыг дээшлүүлэх, гоо зүйн ойлголтыг бусаддаа танин мэдүүлэх, мэргэжилээ сурталчилах зорилгоор мэргэжилийн уралдаан тэмцээн зохион байгуулах.

- Багш, оюутнуудын шинээр гаргасан уран бүтээлийг сурталчилан үзэсгэлэн зохин байгуулах.

- Оюутнууд комьютер график дизайны шинэ хичээл судлаж, бусдад таницуулах.

- Дээд болон доод курсын оюутнуудыг хооронд нь холбож, харилцан биеэндээ зөвлөгөө өгөх, туршлага солилцох бололцоог бий болгох, хамтран ажиллах боломжоор хангах.

- ШУТИС-ийн хэмжээнд болон бусад их дээд сургуулиудын тэргүүлэх оюутны клуб болох.

- Холбогдох гадны болон дотоодын байгууллагуудтай туршлага, мэдээлэл солилцож, мэргэжлээ таниулан хамтран ажиллах.

WHIZZ клуб нь нийт 48 идэвхитэй гишүүний бүрэлдэхүүнтэй үйл ажиллагаа явуулж байна:

3 дугаар курсын 24 оюутан /13 эрэгтэй 11 эмэгтэй /

4 дүгээр курсын 24 оюутан /16 эрэгтэй 8 эмэгтэй /




**Дотоод үйл ажиллагаа. Клубийн гишүүдийн идэвхижүүлэлт.**

**Ойрын зайн явган аялал /Богд уул/**

Клубийн гишүүд дээд болон доод курсын гишүүдийг хооронд нь танилцуулах зорилготойгоор амралтын нэг өдрийг цэвэр агаарт гарч, Богд уул руу ойрын зайн явган аялал хийж, хөгжилтэй тоглоомууд тоглож цагийг зугаатай, үр бүтээлтэй өнгөрөөсөн.

Оролцсон оюутны тоо: 12

2019.09.14



**Анги чимэглэл**

Клубийн гишүүд графикийн урлан болох ШУТИС-ҮТС ийн 214 ангид Шинэ Жилийн уур амьсгал оруулж ангиа чимэглэсэн. Шаарнуудад график зургууд зурж, гар доорх материалаар чимэглэлүүд хийж, WHIZZ клубийн логог ёлка болгон чимэглэсэн.

Оролцсон оюутны тоо: 14

2019.12.07




**Дотоод үйл ажиллагаа. Мэргэжлийн үйл ажиллагаа.**

**2. Зураач Д.Гунгаагийн мастер сургалт**

Төрийн соёрхолт, ардын зураач Д.Гунгаагийн Монгол Арт Галерей-д зохион байгуулагдсан нэг өдрийн хөрөг зургийн мастер сургалтанд хамрагдаж, өөрсдийн зурах чадвараа сайжруулж, таталбарын зургийн талаар лекц сонссон.

Оролцсон оюутны тоо: 72019.09.21



### 3. Бүтээлийн үзэсгэлэн

Клубийн 4-р курсын оюутнууд 3 хэмжээст моделийн төсөл хичээлийн хүрээнд хийсэн 3 хэмжээст дүрийн бүтээлүүдээрээ ШУТИС-ҮТС ийн 2 давхарт үзэсгэлэнгээ гаргаж доод курсийн мэргэжлийн оюутнуудад ханын самбарын ажил, бичвэрийн ажлуудаа танилцууллаа.

Оролцсон оюутны тоо: 13

12-р долоо хоног



### 4.Төгсөгчидын мастер сургалт

Компьютер график дизайн чиглэлээр ҮТС-ийг төгссөн өмнөх жилийн төгсөгчидөөс урьж 3 хэмжээст модел, анимаци хичээлийн хүрээнд хөдөлгөөнт график болон зохиол бичих, кадрын зохиомж гаргах талаархи 2-4 цагийн мастер сургалт клубийн 3 дугаар курсын оюутнуудад явуулсан.

Оролцсон оюутны тоо: 23 12, 13 дугаар долоо хоног



## 5.Stopmotion анимэйшн

Клубийн 3-р курсын оюутнууд 3 хэмжээст анимаци хичээлийн хүрээнд “LITTLE PLANET” богино хэмжээний stopmotion анимаци хийж гүйцэтгэсэн. Гар доорх материалаар орчин, эдэлхүүн, дүрүүдийг хийж гүйцэтгэсэн. Графикийн урлан 214 ангид зураг авалтыг хийж, анимэйшныг 3 долоо хоногийн хугацаанд хийж дуусгасан.

Оролцсон оюутны тоо: 25

12-15 долоо хоног



**Дотоод үйл ажиллагаа. Сурлага.**

**Кредитын урамшуулал. Захирлын тушаал**



ШИНЖЛЭХ УХААН, ТЕХНОЛОГИЙН
ИХ СУРГУУЛИЙН ЗАХИРЛЫН
ТУШААЛ

2019 оны 08 сарын 20 өдөр Дугаар А/172 Улаанбаатар хот

Оюутнуудад кредитийн урамшуулал олгох тухай

ШУТИС-ийн дүрмийн 10.2 дахь заалт, "ШУТИС-ийн оюутнуудад кредитийн урамшуулал олгох журам", бүрэлдэхүүн сургуулиудын саналыг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. ШУТИС-ийн 2018-2019 оны хичээлийн жилийн хаврын улиралд үнэлгээний голч дүн 3.6-аас дээш суралцсан шилдэг суралцагчийг нэгдүгээр хавсралтаар, эрдэм шинжилгээний хурал, олимпиадад амжилт гаргасан оюутныг хоёрдугаар хавсралтаар, мэргэжлийн уралдаан тэмцээнд амжилт гаргасан оюутныг гуравдугаар хавсралтаар, соёл, урлагийн уралдаан тэмцээнд амжилт гаргасан оюутныг дөрөвдүгээр хавсралтаар, клубийн үйл ажиллагаа, олон нийтийн ажилд идэвхтэй оролцсон оюутныг тавдугаар хавсралтаар, оюутны холбооны үйл ажиллагаанд идэвхтэй оролцсон оюутныг зургаадугаар хавсралтаар, спортын уралдаан тэмцээн амжилт гаргасан оюутныг долоодугаар хавсралтанд заасны дагуу нийт 948 оюутанд 1560 кредитийн урамшуулал олгосугай.

2. Хавсралтанд заасан нэр бүхий оюутнуудад олгогдож буй кредитийн урамшууллын хэмжээгээр 2019-2020 оны хичээлийн жилийн намрын улиралд сонгосон кредитийн төлбөрөөс чөлөөлөхийг бүрэлдэхүүн сургуулиудын захирал, ахлах нягтлан бодогч нарт зөвшөөрсүгэй.

ЗАХИРАЛ Б.ОЧИРБАТ

UNIVERSITY OF SCIENCE AND ... MONGOLIAN

2018-2019 оны хичээлийн жилийн хаврын улиралд үнэлгээний голч дүн 3.6-аас дээш суралцаж, урлаг соёл, олон нийтийн арга хэмжээнд амжилт гаргаж оролцсон шилдэг суралцагчидийг кредитын урамшууллаар ШУТИС-ийн захирлын тушаалаар клубийн 19 гишүүн шагнуулсан.



Шилдэг суралцагч

ШУТИС-ийн Захирлын 2019 оны 02-р сарын 20.-ны өдрийн ...тоот тушаалын нэгдүгээр хавсралт

| | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|
| 465 | Ж.Болормаа | ҮТС | ХД-2 | B170190004 | Захирлын нэрэмжит хуудас 1 удаа | 1кр |
| 466 | Б.Идэрмөнх | ҮТС | ҮД-2 | B170210017 | Захирлын нэрэмжит хуудас 1 удаа | 1кр |
| 467 | Б.Содбаяр | ҮТС | Ой Инженер-2 | B171460004 | Захирлын нэрэмжит хуудас 1 удаа | 1кр |
| 468 | Г.Сувдаа | ҮТС | ХД-1 | B180190020 | Захирлын нэрэмжит хуудас 1 удаа | 1кр |
| 469 | У.Мөнх-Эрдэнэ | ҮТС | ИТ-1 | B180220008 | | |
| 470 | Г.Оюунгэрэл | | | | | |
| 471 | С.Номинжаргал | | | | | |
| 472 | Б.Отгонболд | | | | | |
| 473 | Н.Хүрэлхүү | | | | | |
| 474 | Д.Болортуяа | | | | | |
| 475 | Л.Энхжин | | | | | |
| 476 | Г.Баярсүлд | | | | | |
| 477 | Б.Оюунбилэг | | | | | |
| 478 | Г.Номин-Эрдэнэ | | | | | |
| 479 | Э.Балжинням | | | | | |
| 480 | О.Сүнжидмаа | | | | | |
| 481 | Э.Энхжин | | | | | |
| 482 | Б.Тэгөлдөр | | | | | |
| 483 | Е.Энхжишиг | | | | | |
| 484 | Э.Дэлгэрсайхан | | | | | |
| 485 | Д.Чойням | | | | | |
| 486 | Г.Шинэбаяр | | | | | |
| 487 | Б.Хүслэн | | | | | |
| 488 | Б.Эрдэнэжаргал | | | | | |
| 489 | Б.Золцэцэг | | | | | |
| 490 | А.Ананд | | | | | |
| 491 | Х.Халиун | | | | | |
| 492 | Ц.Зулбилэг | | | | | |
| 493 | Ц.Чинбишрэлт | | | | | |

Шилдэг суралцагч

ШУТИС-ийн Захирлын 2019 оны 02-р сарын 20.-ны өдрийн ...тоот тушаалын нэгдүгээр хавсралт

| | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|
| 494 | М.Баасансүрэн | ҮТС | КГД-3 | B160200007 | Захирлын нэрэмжит хуудас 1 удаа | 1кр |
| 495 | Г.Энхмаа | ҮТС | ХЧЭБ-5 | B141180109 | Захирлын нэрэмжит хуудас 2 удаа | 2кр |
| 496 | Э.Отгонзаяа | ҮТС | КГД-3 | B160200051 | Захирлын нэрэмжит хуудас 3 удаа | 4кр |
| 497 | Б.Лхам-Эрдэнэ | ҮТС | КГД-3 | B160200067 | Захирлын нэрэмжит хуудас 2 удаа | 2кр |
| 498 | А.Оюу-Эрдэнэ | ҮТС | ИД-3 | B160220215 | Захирлын нэрэмжит хуудас 2 удаа | 2кр |
| 499 | Э.Хатанболд | ҮТС | ИД-3 | B160220245 | Захирлын нэрэмжит хуудас 2 удаа | 2кр |
| 500 | М.Хосбаяр | ҮТС | ИД-3 | B160220205 | Захирлын нэрэмжит хуудас 2 удаа | 2кр |
| 501 | Б.Батбаясгалан | ҮТС | ИД-3 | B160220207 | Захирлын нэрэмжит хуудас 2 удаа | 2кр |
| 502 | Б.Нарнаа | ҮТС | ХЧЭБ-3 | B161180100 | Захирлын нэрэмжит хуудас 2 удаа | 2кр |
| 503 | Э.Нямцэцэг | ҮТС | ХД-2 | B170190029 | Захирлын нэрэмжит хуудас 2 удаа | 2кр |
| 504 | Д.Шижирцэцэг | ҮТС | ХД-2 | B170190006 | Захирлын нэрэмжит хуудас 2 удаа | 2кр |
| 505 | Э.Наранжаргал | ҮТС | ХД-2 | B170190007 | Захирлын нэрэмжит хуудас 2 удаа | 2кр |
| 506 | А.Энхзул | ҮТС | ХД-2 | B170190041 | Захирлын нэрэмжит хуудас 2 удаа | 2кр |
| 507 | Э.Хулан | ҮТС | ГД-2 | B170200060 | Захирлын нэрэмжит хуудас 2 удаа | 2кр |
| 508 | З.Одончимэг | ҮТС | ГД-2 | B170200037 | Захирлын нэрэмжит хуудас 2 удаа | 2кр |
| 509 | Б.Урангоо | ҮТС | ГД-2 | B170210006 | Захирлын нэрэмжит хуудас 2 удаа | 2кр |
| 510 | Ж.Ариунжаргал | ҮТС | ИД-2 | B170220264 | Захирлын нэрэмжит хуудас 2 удаа | 2кр |
| 511 | Г.Энхнамуун | ҮТС | ИД-2 | B170220206 | Захирлын нэрэмжит хуудас 2 удаа | 2кр |
| 512 | Б.Эрдэнэтуул | ҮТС | Хүменежмент-2 | B170590502 | Захирлын нэрэмжит хуудас 2 удаа | 2кр |
| 513 | Б.Долгормаа | ҮТС | Механик И-1 /Япон2+2/ | B181100705 | Захирлын нэрэмжит хуудас 2 удаа | 2кр |
| 514 | Б.Ганбаяр | ҮТС | Механик И-1 /Япон2+2/ | B181100738 | Захирлын нэрэмжит хуудас 2 удаа | 2кр |
| 515 | Б.Мичидмаа | ҮТС | Механик И-1 /Япон2+2/ | B181100709 | Захирлын нэрэмжит хуудас 2 удаа | 2кр |
| 516 | А.Санжаабал | ҮТС | Механик И-1 /Япон2+2/ | B181100721 | Захирлын нэрэмжит хуудас 2 удаа | 2кр |
| 517 | Ц.Номинцэнд | ҮТС | Механик И-1 /Япон2+2/ | B181100703 | Захирлын нэрэмжит хуудас 2 удаа | 2кр |
| 518 | Д.Баяржаргал | ҮТС | Механик И-1 | B181100710 | Захирлын нэрэмжит хуудас 2 удаа | 2кр |

Шилдэг суралцагч

ШУТИС-ийн Захирлын 2019 оны 02-р сарын 20.-ны өдрийн ...тоот тушаалын нэгдүгээр хавсралт

| | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|
| | | | /Япон2+2/ | | | |
| 519 | А.Өлзийбадрах | ҮТС | Механик И-1 /Япон2+2/ | B181100722 | Захирлын нэрэмжит хуудас 2 удаа | 2кр |
| 520 | О.Рэнцэнбат | ҮТС | Механик И-1 /Япон2+2/ | B181100719 | Захирлын нэрэмжит хуудас 2 удаа | 2кр |
| 521 | Б.Баяржавхлан | ҮТС | ХЧЭА-1 | B182030003 | Захирлын нэрэмжит хуудас 2 удаа | 2кр |
| 522 | Б.Ангирмаа | ҮТС | КГД-3 | B160200022 | Захирлын нэрэмжит хуудас 3 удаа | 4кр |
| 523 | О.Хүслэн | ҮТС | КГД-3 | B160200023 | Захирлын нэрэмжит хуудас 3 удаа | 4кр |
| 524 | И.Элбэгжаргал | ҮТС | ХҮМТТ-3 | B161100500 | Захирлын нэрэмжит хуудас 4 удаа | 1кр |
| 525 | Ц.Ану | ҮТС | НҮТ-3 | B161260013 | Захирлын нэрэмжит хуудас 3 удаа | 4кр |
| 526 | Б.Номин | ҮТС | ГД-2 | B170200052 | Захирлын нэрэмжит хуудас 4 удаа | 1кр |
| 527 | С.Амар | ҮТС | ИД-2 | B170220218 | Захирлын нэрэмжит хуудас 4 удаа | 1кр |
| 528 | С.Галмандах | ҮТС | Механик И-2 /Япон2+2/ | B171100725 | Захирлын нэрэмжит хуудас 4 удаа | 1кр |
| 529 | Ч.Өсохбаяр | ҮТС | Механик И-2 /Япон2+2/ | B171100730 | Захирлын нэрэмжит хуудас 4 удаа | 1кр |
| 530 | О.Сүхбат | ҮТС | Механик И-2 /Япон2+2/ | B171100702 | Захирлын нэрэмжит хуудас 3 удаа | 4кр |
| 531 | Э.Болормаа | ҮТС | Механик И-2 /Япон2+2/ | B171100723 | Захирлын нэрэмжит хуудас 4 удаа | 1кр |
| | | | | | | 770кр |
| | НИЙТ | | | | | |

## ХОЁРДУГААР БҮЛЭГ – ГАДААД ҮЙЛ АЖИЛЛАГАА

### 1. Олон улсад мэргэжил суртачилах

**Өвөр Монголын “Үндэсний Үзэсгэлэнгийн танхим”. Урлаг, дизайны хамтарсан үзэсгэлэн.**

2019 оны 5 сард жил бүр уламжлал болон зохион байгуулагддаг “Алтан Хулгана 2019” дизайны наадмыг өргөжүүлэн Өвөр Монголын Их сургуулийн “Үйлс бүтээлийн дээд сургууль”-н багш оюутны бүтээл оролцсон бөгөөд хамтран ажиллах санамж бичигт гарын үсэг зурсан юм.

Хамтран ажиллах хүрээг тэлэн уг үзэсгэлэнд оролцсон бүтээлүүдийн дээж болож 440, “Үйлс бүтээлийн сургууль”-ийн 300-гаад, нийтдээ 740 гаруй дизайны болон урлагийн бүтээлийн үзэсгэлэнг Өвөр Монголын “Үндэсний үзэсгэлэнгийн танхим”-д зохион байгуулагдсан.



**Японы Засгийн газрын “Sakura Science” оюутан солилцоо**

2014 оноос эхлэн Япон улсын засгийн газар Sakura Science хөтөлбөрийг хэрэгжүүлэх болсонтой холбогдуулан ШУТИС-ҮТС ийн WHIZZ клубийн ахлагч Б.Эрдэнэжаргал болон клубийн гишүүн Б.Хүслэн нар нь Японы Ивате их сургуулийг оюутан солилцоогоор зорьсон.

Хөтөлбөрийн хүрээнд Тайланд, Тайван, Монгол улсын 11 оюутны баг бүрэлдэхүүн Япон улсын уламжлал, Ивате их сургууль, сургалтын орчин, систем болон оюутны хийж буй шинжлэх ухаан, технологийн үзэсгэлэнгийн бүтээлүүдтэй танилцсан.

Б.Эрдэнэжаргал, Б.Хүслэн нар Ивате их сургуульд ШУТИС-ийг танилцуулсан илтгэл тавьж, оюутан солилцооны хугацаанд хийсэн Монгол улсын болон Япон улсын сав, баглаа боодлыг харьцуулсан судалгааны илтгэлээ танилцуулсан.

Оролцсон оюутны тоо: 2

2019.07.08 – 2019.07.14



## 2. Мэргэжлийн үйл ажиллагаа

**TALK TALK ENGLISH 3 хэмжээст дүрүүдийн төсөл**

TALK TALK англи хэлний сургалтын төвийн шинэ сурах бичгийн дүрүүдийн шийдэл, концепцийг гаргаж, 3 хэмжээст моделиуд гүйцэтгэх төслийн клубийн 4-р курсийн гишүүд хийж гүйцэтгэж байна.

Оролцсон оюутны тоо: 5




**ШУТИС-ийн хичээлийн шинэ жилийн нээлтийн үйл ажиллагааны урилга**

2019-2020 оны хичээлийн жилийн нээлтийн ёслолын арга хэмжээний урилгын загварыг шинэчилж хийсэн.

Оролцсон оюутны тоо: 2 2019.09.14




**Манлайлал-оролцоо-хөгжлөөр түүчээлсэн 60 жил**

ШУТИС-ийн “Манлайлал-оролцоо-хөгжлөөр түүчээлсэн 60 жил” үйл ажиллагааны оролцогч нарын мандат, урилга, өргөмжлөл, батламжийн загварыг гаргасан.

Оролцсон оюутны тоо: 4 2019.09.23



“Манлайлал-оролцоо-хөгжлөөр түүчээлсэн 60 жил”-д шилдэг клуб болон шилдэг анги, шилдэг манлайлагч оюутан номинацид өөрсдийн материалыг бүрдүүлэн клубийн 3 болон 4-р курсын оюутнууд, анги хамт олон өрсөлдсөн.

Уг арга хэмжээнд шилдэг клуб номинацид WHIZZ клуб, мөн манлайлагч оюутан номинацид клубийн гишүүн 4-р курсын оюутан Б.Ангирмаа тус тус шалгарч ШУТИС-ийн хэмжээнд амжилт гаргасан

Оролцсон оюутны тоо: 26 2019.09.29




**ШУТИС-ийн багш судлаачдын бүтээлийн 2IP уралдааны үзэсгэлэн дэглэлт**

ШУТИС-ийн багш судлаачдын бүтээлийн 2IP уралдааны бүтээлийн үзэсгэлэнгийн зохион байгуулалт, дэглэлт, зураг явалтыг WHIZZ клубийн 3-р курсын оюутнууд хариуцаж ажиллаа: үзэсгэлэнгийн бүтээлүүдийг хэвлэж, гарчиглаж, ангиллаж өрсөн, талбайн зохион байгуулалтыг хариуцаж бүтээлүүдийн байршил, план зургийг тооцоолсон, гэрэл зургийн сурвалжлагыг хийсэн.

Оролцсон оюутны тоо: 23 2019.09.25 – 2019.09.27



**ШУТИС-ийн 60 жилийн хүндэтгэлийн концертийн видео**

ШУТИС-ийн 60 жилийн Хүндэтгэлийн концертийн урлагийн үзүүлбэр тус бүрийн ард байрлах ЛЕД дэлгэц дээр гарах видео контент болон график ажлуудыг Б.Мэндсайхан болон Г.Халиун  О.Гантулга А.Цэрэндулам багш нарын удирдлага дор WHIZZ клубийн 4-р курсын оюутнууд Е-байрны 406 тоот ангид хоножк байрлан гүйцэтгэлээ.

Нийт 5 өдөр ажилласан ба энэ хугацаандаа 26 урлагийн тоглолтын видео, тэдгээрийн титрийн график дүрслэлийн хамт хийж дуусгасан.

Оролцсон оюутны тоо: 16

2019.09.30 – 2019.10.04




ХӨДӨЛМӨРИЙН ГАВЪЯАНЫ УЛААН ТУГИЙН ОДОНТ
ШИНЖЛЭХ УХААН, ТЕХНОЛОГИЙН ИХ СУРГУУЛЬ
ШУТИС
1959
ШУТИС
Хөгжлийг түрүүлсэн 60 жил
Эрдэм номын эрхэм буян энэт дэлгэрэх болтугай!


1959
ШУТИС
1959
ШУТИС

## ГУРАВДУГААР БҮЛЭГ- ҮР ДҮН

### Онцлох үйл явц

Жил бүр уламжлал болон зохион байгуулагддаг “Алтан хулгана” оюутны бүтээлийн наадам өнгөрсөн 2019 онд “Golden Mouse Design Expo 2019” болон өргөжиж дизайны долоо хоногийн үзэсгэлэн болон зохион байгуулагдсан билээ.

Уг үзэсгэлэнгийн үеэр Өвөр Монголын “Үйлс бүтээлийн дээд сургууль”-н багш, оюутны бүтээл оролцсон бөгөөд хамтран ажиллах санамж бичигт гарын үсэг зурсан юм. 2019 оны 7-р сард энэхүү үзэсгэлэнд Алтан хулгана наадамд оролцсон бүтээлүүдийг явуулсан бөгөөд WHIZZ клубийн гишүүдийн “Эрүүлмаа”, “Checkmate”, “Тамын хаалгын сахиул”, “Сүнс тээвэрлэгч” бүтээлүүд шагнал хүртсэн юм.


AWARD CERTIFICATE of
China and Mongolia College Students Design Art Exhibition
中蒙大学生设计艺术展获奖证书
China and Mongolia College Students Design Art Exhibition Award Certificate
0305 Team
您的作品 被评为中蒙大学生设计艺术展优秀作品奖，兹授予获奖证书，以资鼓励。
Your art work " Эрүүлмаа " has been appraised as an Outstanding Work Prize by The China and Mongolia College Students Design Art Exhibition. You are awarded this Honor Certificate for encouragement.
中蒙大学生艺术设计展组委会
内蒙古大学创业学院/蒙古国科技大学
2019年7月

AWARD CERTIFICATE of
China and Mongolia College Students Design Art Exhibition
中蒙大学生设计艺术展获奖证书
China and Mongolia College Students Design Art Exhibition Award Certificate
您的作品 被评为中蒙大学生设计艺术展优秀作品奖，兹授予获奖证书，以资鼓励。
Your art work " Тамын хаалгын сахиул " has been appraised as an Outstanding Work Prize by The China and Mongolia College Students Design Art Exhibition. You are awarded this Honor Certificate for encouragement.
中蒙大学生艺术设计展组委会
内蒙古大学创业学院/蒙古国科技大学
2019年7月

AWARD CERTIFICATE of
China and Mongolia College Students Design Art Exhibition
中蒙大学生设计艺术展获奖证书
China and Mongolia College Students Design Art Exhibition Award Certificate
Vertex Team
您的作品 被评为中蒙大学生设计艺术展优秀作品奖，兹授予获奖证书，以资鼓励。
Your art work " Checkmate " has been appraised as an Outstanding Work Prize by The China and Mongolia College Students Design Art Exhibition. You are awarded this Honor Certificate for encouragement.
中蒙大学生艺术设计展组委会
内蒙古大学创业学院/蒙古国科技大学
2019年7月

Жил бүр зохион байгуулагддаг Японы ART&TOHOKU наадамд бүтээлүүд өрсөлдүүлэхээр явуулсан бөгөөд мөн клубийн гишүүдийн 7 бүтээл шагнал хүртсэн юм.


賞状
Certificate of Contribution
This certificate is presented to
Baasansuren.M
In recognition of his contribution to the Competition Art & Technology Tohoku 2019
あなたは「アート&テクノロジー東北2019」において頭書の通り優秀な成績をおさめられましたのでこれを賞します
In recognition of your excellent work presented at the Competition for Art & Technology Tohoku 2019
2019年7月13日 July 13, 2019
芸術科学会東北支部
「アート&テクノロジー東北2019」実行委員会
Art & Technology Tohoku 2019

賞状
Certificate of Contribution
This certificate is presented to
Bat-Ireedui.E
In recognition of his contribution to the Competition Art & Technology Tohoku 2019
あなたは「アート&テクノロジー東北2019」において頭書の通り優秀な成績をおさめられましたのでこれを賞します
In recognition of your excellent work presented at the Competition for Art & Technology Tohoku 2019
2019年7月13日 July 13, 2019
芸術科学会東北支部
「アート&テクノロジー東北2019」実行委員会
Art & Technology Tohoku 2019

賞状
Certificate of Contribution
This certificate is presented to
Huslen.O Khaliun.Kh Angirmaa.B
In recognition of his contribution to the Competition Art & Technology Tohoku 2019
あなたは「アート&テクノロジー東北2019」において頭書の通り優秀な成績をおさめられましたのでこれを賞します
In recognition of your excellent work presented at the Competition for Art & Technology Tohoku 2019
2019年7月13日 July 13, 2019
芸術科学会東北支部
「アート&テクノロジー東北2019」実行委員会
Art & Technology Tohoku 2019

# “Opportunity” клубийн

# 2019-2020 оны хичээлийн жилийн намрын улирлын тайлан

## 1. Зорилго

- Эрчим хүчний сургуулийн оюутнуудын эрдэм шинжилгээ судалгааны ажилд оролцох идэвх санаачлагыг нэмэгдүүлэх
- Оюутнуудад анхан шатны мэдлэгээс эхлээд судалгааны ажлыг үе шаттайгаар хөгжүүлэх аргад суралцах, шүүмжлэлт сэтгэлгээг хөгжүүлэх;
- Инженер технологийн чиглэлээр салбартаа тулгамдсан асуудлыг шийдвэрлэх, дэвшилтэт технологийг судлах замаар оюутны бүтээлч сэтгэлгээг хөгжүүлэх
- Оюуны өмч бүтээх хамгаалах, чадвар эзэмшүүлэх

## 2. Зорилт

- Оюутнуудыг мэргэжлийн судалгаа шинжилгээний ажлыг хянаж, боловсруулах чадварт суралцуулах
- Сургуулийн судалгаа шинжилгээний ажилд хамтран оролцох
- Оюутнуудын судалгаа хийх орчин нөхцлийг бүрдүүлэх, судалгаа шинжилгээний ажилд дэмжлэг туслалцаа үзүүлэх

## 3. Үйл ажиллагаа

- Оюутнуудын судалгаа шинжилгээний ажлыг дэмжих зорилгоор уралдаан тэмцээнийг үе шаттайгаар зохион байгуулах;
- Хувь хүний хөгжил болон мэргэжлийн ур чадварыг дээшлүүлэх зорилгоор мэргэжлийн байгууллагуудтай хамтран цуврал лекц, семинар, хэлэлцүүлэг тогтмол явуулах;
- Клубийн үйл ажиллагааг сурталчлах, нээлттэй хаалганы өдөрлөгийг зохион байгуулах
- Сургуулиас зохион байгуулж буй тэмцээн уралдааныг хамтран зохион байгуулах, туслалцаа дэмжлэг үзүүлэх;
- Оюутнуудын судалгааны ажлын үр дүнг улсын болон олон улсын сэтгүүлд хэвлүүлэх
- Судалгааны үр дүнг практикт нэвтрүүлэх ажлыг үе шаттайгаар хэрэгжүүлэх
- Олон улсын их дээд сургуулиудын судалгааны шинжилгээний ажлыг үнэлж дүгнэх
- Клубийн үйл ажиллагааг дүгнэж сургуульд тайлан хэлэлцүүлэх

4. **Клубийн гишүүнчлэл**

ШУТИС-ийн ЭХС-ийн “Цахилгаан систем, Цахилгаан системийн автомажуулалт, Цахилгаан хангамж, Электроник, Сэргээгдэх эрчим хүч” чиглэлийн мэргэжлээр 2, 3-р дамжаанд суралцаж буй оюутнууд хамрагдах бөгөөд 2019-2020 оны хичээлийн жилд 21 оюутантай үйл ажиллагаагаа явуулж байна.

Зөвлөх багш: Техникийн ухааны доктор (Ph.D), дэд профессор Ш. Гантөмөр

Клубийн ахлагч: П. Болдсайхан

Клубийн дэд ахлагч: Б. Ононхүү

Үйл ажиллагаа хариуцсан гишүүн: А. Балжинням гэсэн бүрэлдэхүүнтэй 2019-2020 оны намрын улиралд үйл ажиллагаагаа явуулж байна.

5. **Клубийн зохион байгуулсан үйл ажиллагаа**

**2019-2020 оны намрын улирал**

- Клубийн шинэ гишүүдийн элсэлт






2019.09.27

- Гишүүдийн илтгэлийн сэдэв болон удирдагч багш сонголт

- “Ярилцлагын цаг” – 1
  2019.11.22

Клубийн эхний зочноор Харвардын Их Сургуульд Докторын зэрэг хамгаалсан Д. Уянга эгч маань уригдан судалгаа шинжилгээний ажил хэрхэн зөв бичиж эхлэх, нийгмийн идэвхтэй оюутан байх талаар сонирхолтой сэдвийн талаар ярилцсан юм.

- “Ярилцлагын цаг” – 2
  2019.11.28

Энэ удаагийн зочноор Австралийн Queensland их сургуулийг компьютер, цахилгааны инженер мэргэжлээр төгссөн, TEEEducation клубийн үүсгэн

байгуулагч Б. Билгүүн оролцсон. Энэхүү ярилцлагаар мэргэжлээ дээшлүүлэн гадны томоохон их дээд сургуулиудад хэрхэн суралцах мөн хүн бүр яагаад код бичиж сурах ёстой зэрэг сонирхолтой сэдвүүдийн талаар ярилцсан юм.



Улирлын төгсгөлд оюутан бүр илтгэлийн сэдэв, удирдагч багшаа сонгон төлөвлөгөө гаргаж хаврын улиралд болох ЭХС-ийн эрдэм шинжилгээний бага хуралд оролцохоор судалгаа шинжилгээний ажлаа үргэлжлүүлж байна.



## C.C.S клубийн 2019-2020 оны хичээлийн жилийн намрын улирал, танилцуулга

**CSS - Computer&communications security**

**Эрхэм Зорилго :**

Мэдээллийн сүлжээ, аюулгүй байдлын салбарын оюутнуудын мэдээллийн сүлжээ, аюулгүй байдлын шинэ технологийн талаарх мэдлэг чадварыг хөгжүүлэх. Анги хамт олноор хамтран мэдлэг чадвараа хуваалцах, багаар ажиллаж суралцах, оюутнуудын бүтээлч чадварыг нэмэгдүүлэх, мэдээллийн сүлжээ, аюулгүй байдлын мэргэжлийг бүрэн таниулахад оршино.

**Зорилт :**

- Хувь хүний аюулгүй байдлын мэдлэг чадварыг дээшлүүлэх
- Оюутнуудад аюул заналхийллийн менежментийн ерөнхий боловсрол эзэмшүүлэх
- Мэдээллийн аюулгүй байдал, нууцлал хамгаалалтын талаар суурь мэдлэг болон ахисан түвшиний мэдлэгийг олгох
- Сургуулиас жил бүр зохион байгуулдаг оюутны эрдэм шинжилгээ болон бүтээлийн уралдаанд идвэхитэй  оролцох
- Сургуулийн болон салбарын төсөл, гэрээт ажилд оролцон тусалж байх
- Жил бүр MNCERT-ээс зохион байгуулдаг үндэсний CTF Харуул занги (хакенгийн тэмцээн)  тэмцээнд сургуулиа төлөөлөн оролцож, амжилт үзүүлж байх.

**Capture the Flag гэж юу вэ ?**

**Тугийг эзлэх (Capture the flag /CTF/)**

**CTF** Capture The Flagбуюу Тугийг эзлэх/CTF/уралдаан нь дэлхийн улс орнуудад бодиторчинд хэрхэн мэдээллийн технологийг ашиглах талаар заах сурталчилах хийсвэр арга юм. CTF тэмцээнд оролцох нь хувь хүний аюулгүй байдлын мэдлэг чадварыг дээшлүүлж, компьютерийн шинжлэх ухааны хүрээнд шинэ авьяасаа тодорхойлоход тусалдаг.

Энэхүү тэмцээн нь мэдээллийн технологийн чиглэлийн онлайн даалгаврууд өгөгдөх бөгөөд өгөгдсөн даалгавруудын хариултууд буюу тугийг түрүүлж олж оноо авч бусад багуудтайгаа өрсөлдөн аль баг нь их хариуг олсон нь эхний байранд орох журмаар зохиогддог тэмцээн юм.

# “ЗОХИОН БҮТЭЭГЧ ЗАЛУУС КЛУБ”-ийн

# 2019-2020 оны хичээлийн жилийн намрын улирлын тайлан

**Зохион бүтээгч залуус клубийн танилцуулга:**

Манай клуб нь 2013 оноос хойш идэвхтэй үйл ажиллагаа явуулж байгаа мэргэжлийн клуб юм.Бид гишүүдийнхээ идэвхи санаачлага, өөрийгөө хөгжүүлэх , бие дааж шинийг эрэлхийлэх, багаар ажиллах чадварыг нэмэгдүүлж, хичээлдээ идэвхтэй оролцож дүнгийн ахиц гаргахыг зорьж ажиллаж байна.

**“Зохион бүтээх залуус” клубийн зорилго:**
Хичээлийн хоцрогдол арилгаж,хичээлээс олж авсан мэдлэгээ бататгаж практикт туршиж машин механизм зохион бүтээж, бүтээлч сэтгэлгээ хөгжүүлэхэд оршино.

**Гишүүд:**
Хөнгөн үйлдвэрлэлийн машин ашиглалтын инженер мэргэжлээр сурч байгаа оюутанууд “Зохион бүтээх залуус клуб”-д хамрагдаж явдаг. 2019 оны намрын улирлын байдлаар манай клубийн идэвхтэй гишүүдийн тоо 40 байна.




график 1.Зохион бүтээгч залуус клубийн гишүүнчлэл

**Зохион бүтээгч залуус клубийн дотоод үйл ажиллагаа:**

1. Клубийн гишүүд бие биендээ ойлгохгүй байгаа хичээлүүд нь тусалж, багшийн өгсөн үүрэг даалгаварыг цаг хугацаанд хийж дүгнүүлэх
2. Намрын улиралд шинэ гишүүд хоорондоо танилцах үйл ажиллага буюу хамт олноороо аялалд гарах

3. Сургуулиас зохион байгуулж буй 5 төрөлтийн тэмцээнд баг бүрдүүлж оролцох
4. Оюутны эрдэм шинжилгээний хуралууд болон бүтээлээрээ үзэсгэлэнд оролцох
5. Сайн дурын үйл ажиллагаа зохион байгуулж хийх

**2019 оны үйл ажиллагаа**
Манай клуб нь энэ жил гишүүдийнхээ идэвх оролцоог нэмэгдүүлхын тулд сургалт судалгаанд хамруулж тэмцээн уралдаанд хамт олноороо бага бүрдүүлэн оролцох, эрдэм шинжилгээний хурал болон бүтээлийн уралдаан зохион байгуулж, сайн дурын үйл ажиллагаанд идэвхтэй оролцсон.Клубийн нэгдсэн үйл ажиллагаа болон сайн дурын үйл ажиллагаанд хамрагдсан жагсаалтыг Хүснэгт 1,2,3,4,-д хавсаргав.

**Клубийн нэгдсэн үйл ажиллагаа болон сайн дурын үйл ажиллагааны оролцоо идэвхи:**

Клубийн удирдагч багш Д.Пүрэвмагнай болон оюутан И.Элбэгжаргал нар нь 2019 оны 7сарын1-ээс 7сарын30-ны хооронд БНХАУ Шанхай хотын Донгхуа их сургууль дээр текстил судлалын талаар олон улсын оюутнуудтай зуны сургалтанд сууж туршлага судалсан.




Зураг 1. БНХАУ  Шанхай хот Донгхуа их сургууль

Тэмцээн  уралдаанд:

- “Эрдэнэт challenge 2019” автомат роботын тэмцээн (Г.Мөнхчулуун Т.БуяндэлгэрБ.Бат-Очирзураас дагадаг автомат робот )
- “Автомат робот 2019” тэмцээн (намар)(Г.Мөнхчулуун Т.БуяндэлгэрБ.Бат-Очирзураас дагадаг автомат робот, А.Лхагвацэнд Н.Бадамгарав М.Дэлгэрмаа Н.ЖамъяншаравГ.Золбоо Д.Мөнхдорж Т.Гантогтох шоо цуглуулдаг робот)




Зураг 2,“ЗОХИОН БҮТЭЭГЧ ЗАЛУУС” клуб тэмцээн уралдаан

Үзэсгэлэн, чуулга уулзалт:

- Ерөнхий сайд оролцох “Миний ирээдүй-Миний зорилго” уулзалт хэлэлцүүлэг, бүтээлийн үзэсгэлэн (А.Лхагвацэнд Mini CNC машин)
- ШУТИС-ын шилдэг 1000 оюутны чуулга уулзалт, бүтээлын үзэсгэлэн (А.Лхагвацэнд Н.Бадамгарав Mini CNC машин, Г.Мөнхчулуун Т.Буяндэлгэр 3D принтер Б.Бат-Очир автомат робот)
- ШУТИС-ын шилдэг 1000 оюутны чуулга уулзалтын үеэр оюутан И.Элбэгжаргал нь ҮТС-ын захирлын нэрэмжит шагналаар шагнуулсан




Зураг 3. “ЗОХИОН БҮТЭЭГЧ ЗАЛУУС” клуб үзэсгэлэн, чуулга уулзалт

Нийгмийн үйл ажиллагаа:

- Салбарын оюутаны хооронд спортын 4 төрөлт тэмцээн
- “Ирээдүйн үйлдвэрлэлын чиг хандлага” оюутны эрдэм шинжилгээний бага хурал
- Сайн дурын үйл ажиллагаа (Хүн хүндээ, Зүүдны өр хандивын аян явуулсан )




Зураг 4. “ЗОХИОН БҮТЭЭГЧ ЗАЛУУС” клуб нийгмийн үйл ажиллагаа

**Дүгнэлт:**

- Зохион бүтээгч залуус клубийн 2019 оны төлөвлөсөн ажлын дагуу клубийн нэгдсэн үйл ажиллагаа болон сайн дурын үйл ажиллагаанд оролцох гишүүдын тоо нэмэгдсэн бөгөөд хийж байгаа ажилдаа илүү зохион байгуулалттай, хариуцлагатай, мөн багаар ажиллах чадвар нь нэмэгдсэн юм. Үүний зэрэгцээ гишүүдын маань шинэ зүйлсийг судлах, зохион бүтээх, туршилт хийх зэрэг чадварууд нь улам нэмэгдэн өөртөө болон хамт олон, оюун ухаандаа томоохон хөрөнгө оруулалт хийж чадсан нь томоохон үр дүн гарлаа.

## ХАВСРАЛТ

Хүснэгт 1. “Зохион бүтээгч залуус” клубийн гишүүдийн хамрагдсан сургалт, судалгаа

| № | Сургалтын нэр | Хаана болсон | Хамрагдсан гишүүдийн тоо | Огноо |
|---|---|---|---|---|
| 1 | Textile Graduate | БНХАУ-Шанхай хот Донгхуа их сургууль | 1 | 2019.07.01-2019.07.30 |

Хүснэгт2. “Зохион бүтээгч залуус” клубийн гишүүдийн уралдаан тэмцээнд оролцсон үйл ажиллагаа

| № | Уралдаан тэмцээний нэр | Хамрагдах хүрээ | Тайлбар(оролцсон гишүүд) |
|---|---|---|---|
| 1 | Мэдээлэл холбоо технологийн сургууль | Их дээд сургуулийн | Г.Мөнхчулуун Т.Буяндэлгэр Б.Бат-Очир А.Лхагвацэнд |

| | | | |
|---|---|---|---|
| | зохион байгуулсан “Автомат робот 2019” тэмцээн | оюутан | Н.Бадамгарав М.Дэлгэрмаа Н.Жамъяншарав Г.Золбоо Д.Мөнхдорж Т.Гантогтох |
| 2 | “Эрдэнэт challenge 2019” автомат роботын тэмцээн | Их дээд сургуулийн оюутан | Г.Мөнхчулуун Т.Буяндэлгэр Б.Бат-Очир |

Хүснэгт3.“ЗОХИОН БҮТЭЭГЧ ЗАЛУУС клубийн гишүүдийн оролцсон үзэсгэлэн, чуулга уулзалт

| № | Чуулга уулзалтын нэр | Хамрагдах хүрээ | Тайлбар(оролцсон гишүүд) |
|---|---|---|---|
| 1 | “Миний ирээдүй-Миний зорилго” уулзалт хэлэлцүүлэг | Их дээд сургуулийн оюутан | А.Лхагвацэнд |
| 2 | ШУТИС-ын шилдэг 1000 оюутны чуулга уулзалт | ШУТИС-ын оюутнууд | Клубийн бүх гишүүд |

Хүснэгт4. “ЗОХИОН БҮТЭЭГЧ ЗАЛУУС” клубийн зохион байгуулсан нийгмийн үйл ажиллагаа

| № | Үйл ажиллагааны нэр | Хамрагдах хүрээ | Огноо |
|---|---|---|---|
| 1 | Салбарын оюутаны хооронд спортын 4 төрөлт тэмцээн | ШУТИС -ҮТС-ХҮТИС | 2019 оны 10 сарын 26нд |
| 2 | “Ирээдүйн үйлдвэрлэлийн чиг хандлага” оюутны эрдэм шинжилгээний бага хурал | ШУТИС -ҮТС | 2019 оны 10 сарын 25нд |
| 3 | Хүн хүндээ, Зүүдны өр хандивын аян | ШУТИС-ын оюутнууд | 2019 оны 11 сарын 18аас 2019 оны 12 сарын 6-ны хооронд |

# “Цахилгаан шит” клубийн

# 2019-2020 оны хичээлийн жилийн намрын улирлын тайлан

1. **Зорилго**

Цахилгааны инженерийн мэргэжлээр суралцдаг оюутнууд болон уг чиглэлээр үйл ажиллагаа явуулдаг албан байгууллага тэдгээрийн хоорондын харилцаа холбоог сайжруулах, судалгаа шинжилгээний ажлыг дэмжин ажиллах, гишүүдийн мэдлэг боловсролыг дээшлүүлэхэд чиглэсэн ажил гүйцэтгэх, цахилгааны инженерийн салбарын манлайлагч оюутан, залуу үеийг бэлтгэх зорилготой.

2. **Клубийн үйл ажиллагааны чиглэл**

- Оюутнуудыг сургалт, чөлөөт ярилцлага, лекц, мэтгэлцээнд хамруулах
- Орчин үеийн тоног төхөөрөмж, технологийн талаарх уулзалт, семинар зохион байгуулах
- Гишүүдийн мэдлэг боловсрол, ур чадварыг дээшлүүлэх арга хэмжээнүүд зохион байгуулах
- Салбарын аж ахуйн байгууллагуудтай хамтын ажиллагааг хөгжүүлэх

3. **Клубийн бүтэц зохион байгуулалт**

“Цахилгаан шит” клуб нь удирдах зөвлөлийн 6 гишүүн болон идэвхтэн гишүүдээс бүрдэнэ. Үүнд:

- Клубийн зөвлөх багш: О.Цогбаяр
- Клубийн ахлах: А.Мягмарсүрэн

4. **Клубийн гишүүнчлэл**

Клубийн үзэл баримтлал, үйл ажиллагаа, дүрэм журмыг сайн дураар хүлээн зөвшөөрч байгаа, дүрэмд заасан шалгуурыг хангасан залууст гишүүнчлэл нээлттэй байна. Гишүүнчлэл нь хүндэт гишүүн, жинхэнэ гишүүн, дэмжигч гишүүн гэсэн 3 төрөл байна. Үүнд:

- Жинхэнэ гишүүн: Клубийн үйл ажиллагаанд идэвх санаачлагтай оролцдог 2 – 4 дамжааны оюутан байна;
- Дэмжигч гишүүн: Клубийн үйл ажиллагаанд материаллаг болон материаллаг бус дэмжлэг үзүүлэгч иргэн болон албан байгууллага байна;
- Хүндэт гишүүн: Клубийн үйл ажиллагааг дэмжин оролцдог зөвлөх гишүүд, эрдэмтэд байна.

## 5. **Клубийн зохион байгуулсан үйл ажиллагаа**

*(Өмнө жилийн зохион байгуулсан үйл ажиллагаа)*

ШУТИС-ийн ЭХС-ийн Цахилгааны инженерийн салбарын “Цахилгаан шит” мэргэжлийн клуб, Улаанбаатар цахилгаан түгээх сүлжээ ТӨХК-тай хамтран зохион байгуулсан “Цахилгаан шит” мэргэжлийн ур чадварын уралдаан их, дээд сургуулиудын цахилгааны мэргэжлээр суралцаж буй 2, 3-р дамжааны оюутнуудын дунд 2019 оны 5-р сарын 11-ний өдөр амжилттай болж өндөрлөлөө. Тус уралдаанд 10 багийн 50 орчим оюутнууд оролцож мэдлэг, ур чадвараараа өрсөлдлөө.

Уралдаанд ШУТИС-ийн ЭХС-ийн цахилгаан систем, цахилгаан хангамж мэргэжлийн оюутнуудаас гадна төмөр замын дээд сургууль, үндэсний техникийн их сургуулийн цахилгаан инженерийн мэргэжлээр суралцаж буй оюутнууд оролцлоо.

Тэмцээний нээлт:



Уралдааны явц:





"Цахилгаан шит" мэргэжлийн ур чадварын уралдааныг 2 үе шаттай зохион байгуулж, багш нарын бүрэлдэхүүнтэй шүүгчид дараах байруудыг эзлүүлэв.

1-р байр: Д.Гандорж зөвлөх багштай "Цахилгаан шит-1" баг



2-р байр: Д.Гандорж зөвлөх багштай “Цахилгаан шит-2” баг




\3- байр: О.Цогбаяр зөвлөх багштай “Цахилгаан систем 2-р дамжааны 1-р” баг




“Цахилгаан шит” мэргэжлийн клубийн зохион байгуулсан анхны үйл ажиллагаа нь энэхүү арга хэмжээ байсан бөгөөд цаашдаа тус мэргэжлээр суралцаж буй олон оюутан залуусын ур чадварыг дээшлүүлэх арга хэмжээг улирал бүр үйл ажиллагаагаа тогтмол явуулсаар байх болно.

# Энергетик клубийн

# 2019-2020 оны хичээлийн жилийн намрын улирлын тайлан

1. **Клубийн нэр "ЭНЕРГЕТИК"**
2. **Клубийн товч танилцуулга**

Энергетик клуб нь 2018 оны 9-р сарын 5нд анх үүсгэн байгуулагдсан бөгөөд тэргүүнээр ДЦС-4-р курсын оюутан Д.Нанжид, дэд тэргүүнээр ҮХДХ-3-р курсын оюутан Б.Лхавгасүрэн, зөвлөх багшаар ДИ салбарын багш А.Түмэнбаяр нар анх ажиллаж байсан. 2019-2020 оны намрын семистерийн 15-р долоо хоногт буюу 2019.12.07ны өдөр клубийн тэргүүн Д.Нанжид нь өөрийн ажлаа хүлээлгэж өгсөнөөр дэд тэргүүн Б.Лхавгасүрэн нь тэргүүн болов. 2019.12.07-ны клубийн гишүүдийн нэгдсэн хурлаар ДЦС-2-р ангийн оюутан Э.Болдсүх, ДПА-2-р ангийн оюутан Д.Санжаа нар дэд тэргүүний санал асуулгад шалгарч үлдсэн бөгөөд нийт 59 хүний саналаас 33 хүний санал авч Э.Болдсүх энергетик клубийн дэд тэргүүн болсон.

Хамрах хүрээ:

- Гишүүдийн хувь хүний хөгжил, мэдлэг боловсрол, ур чадварыг дээшлүүлэхэд чиглэсэн үйл ажиллагаа явуулах
- Салбарын аж ахуй нэгж байгууллагуудын үйл ажиллагаанд дэмжиж оролцох

### 2.1. Клубийн зорилго

Клуб нь гишүүдийнхээ мэдлэг боловсролыг дээшлүүлэхэд чиглэсэн үйлчилгээ үзүүлэх, дулааны инженерийн салбарын манлайлагч оюутан, залуу үеийг бэлтгэхэд чиглэнэ.

### 2.2. Үйл ажиллагааны чиглэл

- Чадавхжуулах сургалт, мэдээлэл солилцоо
- Чөлөөт ярилцлага-лекц, мэтгэлцээнд хамруулах
- Төрөл бүрийн уулзалт, семинар зохион байгуулах
- Гишүүдийг идэвхижүүлэх арга хэмжээнүүд зохион байгуулах
- Салбарын аж ахуйн байгууллагуудтай хамтын ажиллагааг хөгжүүлэх

### 2.3. Гишүүнчлэл

Клубийн үзэл баримтлал, үйл ажиллагаа, дүрэм, журмыг сайн дураар хүлээн зөвшөөрч байгаа, дүрэмд заасан шалгуурыг хангасан залууст гишүүнчлэл нээлттэй байна. Гишүүнчлэл нь дараах төрөлтэй байна. Үүнд: Хүндэт гишүүн, Жинхэнэ гишүүн, Дэмжигч гишүүн

- Жинхэнэ гишүүн: I-III-р курсын оюутан, клубийн үйл ажиллагаанд идэвхи сонирхолтой оролцох, гишүүнчлэлийн татвараа төлдөг, саналын эрхтэй гишүүд байна.

- Дэмжигч гишүүн: клубийн үйл ажиллагаанд материаллаг болон материаллаг бус дэмжлэг иргэн болон байгууллагыг хэлнэ.
- Хүндэт гишүүн: клубийн үйл ажиллагааг дэмжиж оролцдог зөвлөх гишүүдийг хэлнэ.

Нийт 295 оюутнаас 83 нь эмэгтэй, 212 нь эрэгтэй /Эмэгтэй - 28.13% , Эрэгтэй – 71.87/




## 3. Клубийн зохион байгуулсан дотоод үйл ажиллагаа

### 3.1. Клубийн албан ёсны нээлтийн арга хэмжээ




Энергетик клубийн зөвлөх багш А.Түмэнбаяр клубийн тэргүүлэгчдийн хамт. 2019он.





2019.10.01

Нээлтийн арга хэмжээнд ЭХС-ийн ерөнхий захирал доктор, профессор Ч.Мангалжалав, ШУА-ийн академич, доктор, профессор, Х.Энхжаргал, Монголын ШУА-ийн жинхэнэ гишүүн, академич, доктор, профессор С.Батмөнх, Амгалан дулааны станц ХХК-ийн гүйцэтгэх захирал Ш.Баянмөнх МУ-ын гавъяат багш Д.Мандал агсны гэргий ДИ салбарын эрхлэгч П.Бямбацогт нарын зэрэг эрхэмүүд хүрэлцэн ирсэн байна. Клубийн идэвхитэй 58 оюутан залуус оролцов.

### 3.2. Клубийн номын сан байгуулах




2019.10.15

Номын сан байгуулах үйл ажиллагааг клубийн зөвлөх багш А.Түмэнбаяр, клубийн тэргүүн асан Д.Нанжид, тэргүүн Б.Лхавгасүрэн нар анх санаачлан хэрэгжүүлсэн. Номыг сургуулийн багш нар болон ахмадуудаас хандив цуглуулах замаар авсан бөгөөд нийт 315ш ном сурах бичиг, сэтгүүл бүртгэгдсэн байна. Эдгээр номыг зөөх, ялгах, өрөх зэрэг ажил хийж гүйцэтгэхэд нийт 20 оюутан оролцсон.

### 3.3. “ДТО ба Техникийн Термодинамик-1 ба 2” сэдэвт АХА тэмцээн










2019.11.09

Давхардсан тоогоор нийт 73 оюутан залуус мэдлэг оюунаа сорьсноос шагналт байранд:

**“Дулаан тархалтын онол 1 ба 2” сэдэвт АХА тэмцээн**

1. Тэргүүн байр: Б.Энх-амгалан ДПА-2
2. Дэд байр: М.Цогзолмаа ҮХДХ-2
3. Гутгаар байр: Д.Билгүүн ҮХДХ-2

**“Техникийн термодинамик 1 ба 2” сэдэвт АХА тэмцээн**

1. Тэргүүн байр: А.Сүнжидмаа ДЦС-4
2. Дэд байр: С.Халиун ДЦС-4
3. Гутгаар байр: Б.Энхсайхан ДПА-2

Энэ тэмцээн нь клубийн гишүүдийн мэдлэг чадварыг дээшлүүлэхэд чиглэгдэн зохион байгуулагдсан бөгөөд оюутнууд маш ширүүн өрсөлдөөн гаргаж оролцсон нь бахдууштай хэрэг болсон. Шагналын санг клубийн тэргүүн Б.Лхавгасүрэн нь тус хичээлийг ордог ДИ салбарын багш нартай уулзалт хийж байр эзэлсэн оюутныг 30 онооны шалгалтнаас чөлөөлөх хүртлэх урамшуулал өгсөн.

### 3.4. Богд ууланд хийсэн алхалт



2019 оны 11 сарын 10

Энэ алхалт нь клубийн гишүүдийн хоорондын харилцаа холбоог бэхжүүлэх, гишүүдийг идэвхижүүлэх зорилготойгоор зохион байгуулагдсан бөгөөд нэг өдрийг хөгжөөнт тоглоом тоглож цэвэр агаар байгалийн сайханд өнгөрүүлсэн. Ингэж явахдаа байгальд зүй бусаар ханддаг зарим хачирхалтай хүмүүсийн хаясан хогийг чадах хэмжээгээрээ түүж хогийн цэгт хаясан нь бидий аялалын гол онцлог болсон. Нийт 29 оюутан оролцсон.

### 3.5. эгтэй эмэгтэй холимог воллейболын тэмцээн

**2019.11.27**

Нийт 12 багийн 96 оюутан залуус өрсөлдсөнөөс:

Тэргүүн байр: ДЦС-4 Багийн ахлагч О.Тэмүүжин 100000₮

Дэд байр: ДЦС-4 Багийн ахлагч Б.Тэмүүжин 80000₮

Гутгаар байр: ДИ-1 Багийн ахлагч Н.Эрхэмбаяр 50000₮ тус тус шалгарсан болно. Энэ тэмцээнийг зохион байгуулахад санхүүгийн туслалцаа үзүүлсэн Б.Ганболд захиралтай “Technic Monde LLC” компани нь манай клубтэй хамтарч ажилладаг байгууллагуудын нэг төлөөлөл юм. Тус тэмцээний зорилго нь энергетик клубийн залуусын чөлөөт цагийг зөв боловсон өнгөрүүлэх, гар бөмбөгийн спортыг сурталчлан таниулах, тус спортоор хичээллэх хүсэл сонирхлыг нэмэгдүүлэх, мэргэжил нэгт оюутан залуустай танилцуулах, нөхөрсөг уур амьсгалыг бүрдүүлэхэд оршино.




## 3.6. Энергетик клубийн нэрэмжит эрдэм шинжилгээний бага хурал

Батлав. ШУТИС ЭХС ЭНЕРГЕТИК клубийн тэргүүн.................................. П.Нанжид

**Энергетик клубээс зохион байгуулж буй**

# “АГААРЫН БОХИРДЛЫН ЭСРЭГ ОЮУТАН БИДНИЙ ОРОЛЦОО”

**сэдэвт оюутны эрдэм шинжилгээний бага хурлын удирдамж**

**2019.12.02**

Нэг. Бага хурлын зорилго

Клубын оюутнуудын чөлөөт сэтгэлгээ, өнөөгийн нийгэмд тулгарч буй асуудалд хандах хандлагыг нэмэгдүүлэх, эрдэм шинжилгээ судалгааны ажилд дадлагажуулах, тэдний бүтээлч сэтгэлгээг хөгжүүлэн онол практикийн мэдлэгийг нь гүнзгийрүүлэх, туршлага солилцох, бусдад зерэг хандлага түгээхэд оршино.

Хоёр. Тавигдах илтгэлийн чиглэл

Монгол улсын томоохон хотуудад тулгамдаж буй агаарын бохирдлын асуудлын талаар хийсэн үнэлгээ, ажиглалт судалгаанд тулгуурлан бичсэн илтгэлүүдийг хүлээн авна. Илтгэлүүд нь дараах асуудлыг хөндсөн байх шаардлагатай. Үүнд:

- Агаарын бохирдол хүний эрүүл мэнд ба амьдрах орчинд нөлөөлөх нөлөөлөл
- УБ хотын агаарын чанарын өнөөгийн байдал, агаарын бохирдлыг багасгахад нөлөөлж буй хүчин зүйлс тэдгээрийн хувь нэмэр
- Гэр хорооллын зуух, тэдгээрийн хийц онцлог, угаартах нөхцөл
- Гэр хорооллын агаарын бохирдлыг бууруулах (арилгах) шинэ арга замууд
- Шахмал түлшний онцлог, түүний зөв зохистой хэрэглээ

Гурав. Илтгэлийн бүтэц, бичвэрт тавигдах шаардлага

Бага хуралд тавигдах илтгэл нь бүтцийн хувьд дараах шаардлагыг хангасан байна. Үүнд:

- Илтгэл нь хураангуй, түлхүүр үг, арга зүй, үр дүн, дүгнэлт, ном зүй, хавсралт гэсэн хэсгээс бүрдэнэ.
- Илтгэлийн хэмжээ А-4 цаасны 5-аас доошгүй нүүр, А-4 форматтай нэг баганаид дээрээс 3см, зүүн гар талаас 3см, баруун гар талаас 2.5см, доороос 3см бичнэ.
- Гарчгийг Times New Roman-12 том үсгээр, бичвэрийн төвд тодруулж бичиж, үндсэн бичвэрийн үсгийг фонт Times New Roman, үсгийн хэмжээ нь 11, мөр хоорондын зай нь /single/, бичвэрийн хоёр талыг тэгшилсэн байна.
- Илтгэлд бусдын бүтээлээс авч хэрэглэсэн зүйл, санааг ишлэлд авч, дөрвөлжин хаалт([1])-нд хийх ба томъёог голлон бичиж дугаарыг (1) хаалтанд хийнэ.
- Тоон боловсруулалтыг харуулсан хүснэгт, график зэргийг оруулсан тохиолдолд нэр, тайлбарыг 10pt-ээр бичих ба хэт том хэмжээтэй оруулахгүй.
- Ном зүйд зохиогчийн нэр, овгийн эхний үсэг, хэвлэсэн он, ном огүүлэл, эрх зүйн баримт бичгийн нэр, хэвлэсэн газар буюу хот гэсэн дараалдаар бичнэ.

Дөрөв. Илтгэл хүлээж авах хугацаа, шалгаруулах журам

Илтгэлийг шалгаруулахдаа доорх шаардлагуудыг тавих болно. Үүнд:

1. Илтгэлийг 2019 оны 12 сарын 20-ныг хүртэл ШУТИС-ийн хичээлийн 2-р байрны 313 тоотод цаасаар 19:00 цаг хүртэл хүлээн авч бүртгэнэ.
2. Илтгэл нь урьд өмнө бусад эрдэм шинжилгээний хуралд тавигдаж, хэвлэгдэн нийтлэгдээгүй байна.
3. Бүртгүүлэхдээ илтгэлийг гурван хувь хэвлэж авчрах ба илтгэгчийн нэр хаягийг эх материал дээр бичихгүй (шүүгчид зөвхөн кодолсон материал уншиx шаардлагатай

тул). Илтгэгч өөрийн биеэр ирж бүртгүүлэхдээ код авч, нэр хаягаа бүртгэлийн хуудсанд бичүүлнэ.

4. Илтгэлийн эхийг stenger020@gmail.com хаягаар электрон хэлбэрээр заавал илгээнэ.
5. Зохион байгуулах комисс 2019 оны 12 сарын 22-нд шалгарсан илтгэгчид зөвхөн утсаар хариу мэдэгдэх ба илтгэлийг танилцуулга хийх зөвлөгөө, заавpыг 2019 оны 12 сарын 24-нд авна. Хугацаа хоцорсон, шаардлага хангаагүй, бага хурлын сэдэвт хамаарахгүй сэдэв хөндсөн илтгэлийг хүлээн авахгүй.
6. Шинэ санаа, оновчтой шийдэл, сэдвийн ач холбогдол, логик дэс дараалал, шинжлэх ухааны үндэслэлтэй хандаж буй байдал
7. Асуудлыг шийдвэрлэхэд шаардлагатай мэдээллийн хүрээг зөв тодорхойлсон эсэх
8. Цуглуулсан мэдээлэл нь үнэн зөв эсэх, мэдээллийн эх сурвалжийг үнэн зөв тодорхойлсон эсэх
9. Судалгааны аргыг оновчтой хэрэглэсэн болон сэдвийг өөрийн болгож чадсан байдал
10. Илтгэх ба Мэтгэлцэх, хурдан оновчтой сэтгэх чадвар
11. Цаг ашиглалт
12. Эх бичвэрт тавигдсан шаардлагуудыг хангасан байх

Тав. Эрдэм шинжилгээний хурлын зохион байгуулалт, хамрах хүрээ

Бага хурлын зохион байгуулах үйл ажиллагаа нь дараах байдлаар явах болно. Үүнд:

- Илтгэлийг дээр дурьдсан хугацаанд авч, комисс зөвхөн шалгарсан илтгэгчид утсаар хариу мэдэгдэх ба тэнхимийн багш нарын өгсөн зөвлөгөөний дагуу шалгарсан оюутнууд илтгэлээ сайжруулж бэлтгэнэ.
- Хуралд шалгарсан илтгэлийн бэлтгэсэн танилцуулгыг (PPT) эцсийн байдлаар 2019 оны 12 сарын 25-ны 16:00 цаг хүртэл stenger020@gmail.com хаягаар ирүүлнэ.
- Эрдэм шинжилгээний бага хурал 2019 оны 12 сарын 27-ний өдрийн 16:00 цагт ШУТИС 2-р байрны 419 тоот өрөөнд болно.
- Хуралд тавигдахаар шалгараагүй ч сонирхолтой, ач холбогдол бүхий асуудал хөндсөн 3 оюутны илтгэлийг клубын гишүүдэд фэйсбүүк группээр танилцуулах болно.

ШУТИС ЭХС-ийн дулааны инженерийн салбарын ЭНЕРГЕТИК клубын гишүүд болон 1-4-р курсын оюутнууд ганцаар болон хамтарч оролцож болно.

Зургаа. Шагнал урамшил

| | |
|---|---|
| Тэргүүн байр-1 | Өргөмжлөл, мөнгөн шагнал(150000 төг) |
| Дэд байр-1 | Өргөмжлөл(120000төг) |
| Гутгаар байр-1 | Өргөмжлөл, (100000 төг) |
| Тусгай байр-1 | Өргөмжлөл, (80000 төг) |

**Зохион байгуулагч:**

Шинжлэх ухаан технологийн их сургуулийн
Эрчим хүчний сургуулийн
Дулааны инженерийн салбар
Энергетик клуб

**Ивээн тэтгэгч:**

МУ-ын Гавьяат багш ШУТИС-ийн хүндэт профессор,
Техникийн ухааны доктор Д.Мандалын
гэр бүл, үр хүүхдүүд.




2019.12.25

### 3.7. Клубийн гишүүдийг үнэмлэхжүүлэх




Хатуу картан үнэмлэхний загвар. Энэ карт нь зөвхөн клубийн жинхэнэ гишүүдэд л байх бөгөөд үүгээр клубийн ангид чөлөөт цагаараа суух болон клубийн номын сангаар үйлчлүүлэх эрх нээгдэнэ. Үнэмлэхний хураамж нь 3000₮ болно.

## 4. Клубүүдийн нэгдсэн үйл ажиллагааны болон сайн дурын үйл ажиллагааны оролцоо идэвх

### 4.1. Клубүүдийн нээлттэй өдөрлөг






Хамрагдсан оюутны тоо: 3 2019.09.27

Энэ өдөр шинээр 13 оюутан элсүүлж авсан.

### 4.2. Ерөнхий сайд У.Хүрэлсүх-тэй уулзалт хийсэн ШУТИС-ийн шилдэг 1000 оюутан





2019.11.15

Энергетик клубээс 22 оюутан хамрагдав.

### 4.3. ЭХС-тай хамтран “ДУЛААН ТЕХНИК-2019” олимпиадыг амжилттай зохион байгууллаа.





Оролцсон оюутны тоо: 71
2019.12.07

## 5. Үр дүн , дүгнэлт

2019-2020 оны намрын улирлын семистрын турш манай клуб нь дээрх 7 үйл ажиллагааг зохион байгуулсан бөгөөд 2019.12.11 ны байдлаар ажлын биелэлт 85.7% байна. Учир нь эрдэм шинжилгээний ажил нь цаг хугацаа их шаарддаг учраас 12-р сарын 25нд шалгаруулалтаа явуулахаар төлөвлөсөн. Давхардсан тоогоор нийт 276 оюутан залуусыг хамруулсан. Манай клуб энэ семистерт шинээр 76 гишүүн элсүүлсний 49 нь I-р курсын оюутан байна. Энэ нь I-р курсын оюутнуудын сурлагын чанарт сайнаар нөлөөлж буй хэрэг юм. Учир нь анх оюутан болсон хүүхдүүдийн хувьд олон олон бэрхшээлүүд тулгардаг жишээ нь: ангиа олохгүй төөрөх, ганцаардах, олны өмнө гарахдаа ичих... гэх мэт. Яг энэ үед нь зөвлөгөө өгч чиглүүлснээр дээрх үр дүн гарна. Мөн Энергетик клубийн нэрэмжит эрдэм шинжилгээний бага хурал болон “ДТО ба Техникийн Термодинамик-1 ба 2” сэдэвт АХА тэмцээн зохион байгуулснаар оюутнууд илүү уншигч, хайгч болж зөв системтэйгээр хөгжих үндсэн суурь болж өгнө. Клуб нь өөрийн номын сан, ангитай болсноор оюутнууд заавал номын сангаас ном авалгүйгээр нэг дороос олон төрлийн мэдээллээр хангагдах, дээд курсын ах эгч нараасаа суралцах, чөлөөт цагаа зөв боловсон өнгөрүүлэх боломж нээгдэж байна.

- Клубийн гишүүд хоорондын харилцаа илүү дотно болсон
- Хувь хүний өөрийн мэргэжилээ үнэлэх үнэлэмж дээшилсэн
- Клубийн гишүүд “Би биш бид” гэсэн үзэл бодолтой болсон
- Гишүүдийн чөлөөт цагийг ашиглан өөрийгөө нээн хөгжүүлэх боломжийг олгосон
- Гишүүд хүссэн үедээ ном сурах бичиг авч ашиглах боломжтой болсон
- Өөрт хэрэгтэй мэдээллээ хаанаас харах аа мэддэг болсон

# INSPIRATION

FASHION CLUB

## 2019-2020 оны хичээлийн жилийн намрын улирлын тайлан

Клубийн баг бүрэлдэхүүн

- Клубийн дарга: Ж. Мөнхчимэг
- Нарийн бичиг /санхүүч/: Буянтогтох
- Сургалт судалгаа хариуцсан: Анужин
- Зар сурталчилгаа хариуцсан хэсэг: Маргад-Эрдэнэ
- Загвар үзүүлбэр тайзны урлаг: Наранзул
- Үйлдвэр хариуцсан ахлагч: Эрдэнэханд

**Зорилго**

Хувцасны мэрэгжлээр суралцаж буйоюутнуудад онолын мэдлэгээ дадлага дээрбаталгаажуулах, багаар хамтарч ажиллах, мэрэгжлийнчиг хандлагатай болох, нийгмийн идэвхитэй болохмөн энэ мэрэгжлээр суралцдаггүй боловч сонирхдогоюутнуудад мэрэгжил сурталчлах түгээн дэлгэрүүлэх хамтдаа урлаг дизайны мэдлэг мэдрэмжээ хөгжүүлэх зорилгоор ‘’ INSPIRATION’’ хувцасзагварын клуб ажиллаж байна.

INSPIRATION клубийн үйл ажиллагаа

Өнөөгийн шилдэг дизайнерууд болон үйлдвэрлэл эрхлэгчидтэй уулзалт зохион байгуулж, тэдний  туршлагаас суралцаж олон үнэтэй мэдлэг олж авдаг билээ. Мөн тус мэрэгжилээр суралцаж буй оюутан залуусыг дадлагжуулж практик олгох зорилгоор маш олон уралдаан  тэмцээн зохион байгуулж ялагчийг урамшуулах үйл ажиллагаа явагддаг.




**”INSPIRATION” хувцас загварын клубийн 2019-2020 оны хичээлийн жилийн Намрын улирлын ажлын төлөвлөгөө**

| д/д | Төлөвлөгөөт ажил | Хугацаа | Хамрах хүрээ |
|---|---|---|---|
| 1 | Клуб танилцуулах өдөрлөг | III Долоо хоног | ШУТИС-ийн оюутнууд |
| 2 | Шинэ гишүүн элсүүлэх | III Долоо хоног | ШУТИС-ийн оюутнууд |
| 3 | “Фото зургандаа” зураг авалтын сургалт | IV Долоо хоног | Клубийн шинэ гишүүд |
| 4 | “Өөрсдөө бүтээцгээе” 7.40 брэндийн өдөрлөг | VI Долоо хоног | ШУТИС-ийн оюутнууд |
| 5 | Хувцас загварын мэдрэмжээ хөгжүүлэх “Кино Өдөрлөг” | VIII Долоо хоног | Клубийн шинэ гишүүд |
| 6 | “Монгол бичгээ хөгжүүлцгээе” сургалт | IX Долоо хоног | ШУТИС-ийн оюутнууд |
| 7 | Make up сургалт Nail art сургалт | X Долоо хоног | Клубийн нийт гишүүд |
| 8 | Үйлдвэртэй танилцах өдөрлөг I | X Долоо хоног | Клубийн нийт гишүүд |
| 9 | Үйлдвэртэй танилцах өдөрлөг II | XI Долоо хоног | Клубийн нийт гишүүд, хувцасны |

| | | | |
|---|---|---|---|
| | | | чиглэлийн ангийнхан |
| **10** | Шилдэг гоёлын даашинзны уралдаан | XII Долоо хоног | Клубийн нийт гишүүд, хувцасны чиглэлийн ангийнхан |
| **11** | Хувцас загварын эскизний уралдаан | XIII Долоо хоног | Клубийн гишүүд |
| **12** | 7/40 брэнд хөгжүүлэх | XIV Долоо хоног | Клубийн гишүүд |

**”INSPIRATION” хувцас загварын клубийн 2018-2019 оны хичээлийн жилийн Хаврын улирлын ажлын төлөвлөгөө**

| **д/д** | **Төлөвлөгөөт ажил** | **Хугацаа** | **Хамрах хүрээ** |
|---|---|---|---|
| 1 | “Миний бүтээл фото зурганд” сургалт | II Долоо хоног | Клубийн нийт гишүүд хувцасны ангийн оюутнууд |
| **2** | Хувасны дизайнер үйлдвэрлэл эрхлэгчтэй уулзах өдөрлөг-1 | III Долоо хоног | Клубийн нийт гишүүд |
| **3** | “Model casting” загвар өмсөгчдийг бэлтгэх сургалт | V Долоо хоног | ШУТИС-ийн оюутнууд |
| **4** | “Торгон зам” хувцас загварын тэмцээн зохион байгуулалт | VII Долоо хоног | Клубийн нийт гишүүд, хувцасны чиглэлийн ангийнхан |
| **5** | Хувасны дизайнер үйлдвэрлэл эрхлэгчтэй уулзах өдөрлөг-2 | IX Долоо хоног | Клубийн шинэ гишүүд |
| **6** | “Make up” загварын тэмцээнд зориулсан сургалт | X Долоо хоног | ШУТИС-ийн оюутнууд |
| **7** | Хувасны дизайнер, үйлдвэрлэл эрхлэгчтэй уулзах өдөрлөг-3 | XII Долоо хоног | Клубийн нийт гишүүд |
| **8** | Уран зургийн галерейгаар аялах | X Долоо хоног | Клубийн нийт гишүүд |
| **9** | “Урлахуй ертөнц” хувцас загварын тэмцээн зохион байгуулах | XII Долоо хоног | Клубийн нийт гишүүд, хувцасны чиглэлийн ангийнхан |
| **10** | Музейгээр аялах | XIV Долоо хоног | Клубийн нийт гишүүд, хувцасны чиглэлийн ангийнхан |

Зохиогдсон гол ажилууд









7/40 брендийн хөгжүүлэлт



Үйл ажиллагаанд оролцож буй гишүүдийн зураг

*Танилцуулах өдөрлөг*









*60 жилд зориулсан үйл ажиллагаа*







*Танилцах аялал*









*Тэмцээн уралдаанд оролцсон байдал*














*Сайн дурын ажил*







*Дүгнэлт*

*Энэхүү тайландаа хийсэн үйл ажиллагааны онцлох ажлуудыг орууллаа. Бидний дүгнэж байгаагаар энэ улиралд хангалттай клубийн танилцуулга хийж чадсан гэж үзэж байна. Мөн үйл ажиллагаа бүрт гишүүдийн хамрах хүрээ бусад жилүүдтэй харьцуулахад илүү байлаа. Үүнээс үзэхэд бидний үйл ажиллагаа үр бүтээмжтэй өрнөж олоныг хамарж чадсан бөгөөд гишүүдийг идэвхжүүлж чөлөөт цагийг зөв өнгрөөж хамтдаа хөгжиж чадаж байна.*

# “Эрдмийн индэр” клубийн

# 2019-2020 оны хичээлийн жилийн  намрын улирлын тайлан

Клубийн зорилго

- ШУТИС, БУХС-ийн эрхэм зорилгыг дээдэлж, оюутны хөгжил, төлөвшилд чиглэсэн үйл ажиллагаа явуулж, бие даан суралцах, чадварлаг боловсон хүчин болоход нь оюутан бүрт туслах, нийгмийн сайн сайхан үйлст манлайлан оролцоход манай клубийн эрхэм зорилго оршино.

Үйл ажиллагааны чиглэл

- Эрдэм шинжилгээ, судалгааны хурал, семинар, уралдаанд гишүүдийг хамруулах;
- Харилцаа холбооны менежмент мэргэжлийн онцлог, давуу талыг таниулах;
- Хувь хүний хөгжил болон боловсролд зориулсан төрөл бүрийн сургалт, семинар, лекц зохион байгуулах;
- Залуусын манлайлал, гарааны бизнес, инновацийн санааг хөгжүүлэх, дэмжих ажлуудыг зохион байгуулах;
- Нийгмийн ашиг тусыг эрхэмлэж сайн дурын болон хүмүүнлэгийн үйл ажиллагааг зохион байгуулдаг.

Товч танилцуулга

- Байгуулсан огноо: 2005
- Хамрах хүрээ: ШУТИС-БУХС-ийн харилцаа холбооны менежмент мэргэжлээр суралцаж буй оюутнууд
- Гишүүнчлэл: 68- 29 эрэгтэй, 39 эмэгтэй




Клубийн зохион байгуулсан дотоод үйл ажиллагаа

1. Coffee break25 оюутан 10 сарын 21






2. Ид шидийн орон 19 оюутан 12 сарын 3
3. Мэргэжил танилцуулах өдөрлөг 19 оюутан 10 сарын 21




4. 21-р зууныг тэргүүлэхүй 7-36 оюутан 09 сарын 18-12 сарын 11

5. Амжилттай оюутан 24 оюутан 9 сарын 20





6. Цэвэр орчинд суралцъя 15 оюутан 9 сарын 17





Клубийн нэгдсэн үйл ажиллагааны оролцоо, идэвх

1. Хүрэл тогоот эрдэм шинжилгээний хурал
   10 оюутан 10 сарын 24





2. Сургуулийн орчинг цэвэрлэх



Үр дүн

Манай клубийн хувьд 2019-2020 оны хичээлийн жилийн намрын улиралд 5 үйл ажиллагааг зохион байгуулж тус тус клубийнхээ оюутнуудыг хамруулан оролцуулсан бөгөөд 12 сарын 21нд Эрдмийн Индэр клубийн оюутан болон технологийн менежментийн салбарын багш нарын дунд сагс, волейболын тэмцээн зохион байгуулахаар төлөвлөсөн байна.
2019 оны намрын улиралд төлөвлөсөн ажлаа хийж 100% гүйцэтгэсэн мөн 2020 оны хаврын улиралд клубийн танилцах аялал, оюутнуудыг гадаадад сурч боловсроход нь чиглүүлэх, сэтгэл зүйн зөвөлгөөнд хамруулах гэх мэт төлөвлөсөн ажил хийгдэх болно.

# “Зөв, зохистой хоололт” клуб тайлан

# 2019-2020 оны хичээлийн жилийн

# намрын улирлын тайлан

**Клубийн зорилго**

**Эрүүл амьдралын хэв маягийг хэвшүүлэх, зохистой хооллолтыг бий болгох.**

**Зорилт**

**Мэргэжил сурталчлах болон Хүнсний инженерчлэлийн салбарын оюутнуудыг идэвхжүүлэх.**

Бусад салбар сургуульд зөв зохистой хооллолтын мэдлэгийг дээшлүүлэх, дадал зуршил суулгах.

1. Клубийн танилцуулга
   ШУТИС-ын 2019-2020 оны хичээлийн жилийн нээлтийн үйл ажиллагаан дээр клубийн үйл ажиллагааг танилцуулав.



## 2. Судалгаа

Оюутны байранд амьдарч байгаа оюутнуудаас өглөөний цай ба зөв хоололтын талаар 2018/10/22-29 хүртэлх хугацаанд судалгаа авч сургалт явууллаа.

Тус сургалт судалгаанд ҮТС, БУХС, МХС, МехТС зэрэг 4 оюутны байрны 18-22 насны нийт 159 оюутан хамрагдав.

ҮТС- 45 оюутан оролцов, БУХС- 30 оюутан оролцов, МХС- 34 оюутан оролцов, МехТС- 36 оюутан оролцов.

**ШУТИС-5-Р ОЮУТНЫ БАЙР**





**ШУТИС-3-Р ОЮУТНЫ БАЙР**





**ШУТИС-2-Р ОЮУТНЫ БАЙР**





**ШУТИС-1-Р БАЙР**





Судалгааны дүнг танилцуулахад судалгаанд оюутны байранд амьдарч байгаа 145 оюутнаас судалгааг авсан. Судалгаанаас харахад оюутан зөв хооллолтыг хэрэгтэй гэж боддог боловч түүнийгээ хэрэгжүүлэх боломж боломж бололцоогүй хичээлийн цаг болон өөрсдийн амьдралын хэв маягаас шалтгаалан өглөөний цайг бараг уудаггүй байна.

Мөн өдрийн хоолыг ихэвчлэн цайны газар, болон гадуур хооллох нь буруу бөгөөд байнга шарсан хуурсан хоол иддэг байна.

Оройн хоолыг ихэнх оюутнууд 20:00 цагаас хойш иддэг нь харагдаж байна. Хоол хүнсэндээ төдийлөн олон нэр төрлийн хүнсний бүтээгдэхүүн хэрэглэдэггүй, хоол хүнсний хэрэгцээнд дунджаар 40.000 зарцуулдаг байна.

Иймд оюутнуудад зөв хооллолтын талаар хичээл сургалт оруулж тэдгээр хүмүүсийн амьдралын хэв маягийг сайжруулах хэрэгтэй.

3. **“Cook show”улсын хэмжээний мэргэжлийн уралдаан тэмцээнд Клубийн оюутнууд идэвхтэй оролцож өөрсдөө зохион байгуулав.**

Тэмцээн 2 үе шаттай явагдсан ба

Эхний шалгаруулалт нь Үйлдвэрлэлийн Технологийн сургуулийн ХҮҮТ ба ХЗТУ мэргэжлийн 38 оюутан 4 үндсэн төрөлд 19 баг болж оролцов.Хоёр дахь шат буюу улсын хэмжээний уралдаанд Технологийн Дээд сургуулийн баг, Техник Технололгийн Дээд Сургуулийн баг ШУТИС-ийн Үйлдвэрлэлийн Технологийн Сургуулийн 32 оюутан бүхий 3 баг оролцож

- “Сурагчийн үдийн хоолны иж бүрдэл”
- “Хүнд хөдөлмөр эрхлэгчдийн үдийн хоолны иж бүрдэл”
- “Ур чадвар” өгөгдсөн хүнсний түүхий эдээр хоол хийх

- “Оройн хоолны стандарт ширээ засалт” сэдэвчилсэн ширээ засалт гэсэн төрлөөр оролцлоо.





# “NCN” New Century Nutrition клуб

# 2019-2020 оны хичээлийн жилийн намрын улирлын тайлан

## “NCN” New Century Nutrition клубийн товч танилцуулга

### Клубийн зорилго

- Хоолзүй, шим судлал” мэргэжил сурталчлах
- Зөв хооллолт ба шим тэжээлийн боловсролыг
- дэмжих, сурталчлах
- Оюутнуудад зөв хооллолт, шим тэжээлийн мэдлэг олгох
- Клубийн үйл ажиллагаагаар дамжуулан оюутнууд мэдлэгээ нэмэгдүүлэх, бататгах, хөгжих боломж олгох

### Чиглэл

- Хоол зүй шим тэжээлийн мэргэжлээ сурталчлах
- Мэргэжлийн чиглэлээр клуб, хувь хүн, бусад салбар сургуульд хоол шим тэжээлийн зөвлөгөө өгч сургалт явуулах
- Олон нийтийн хоол, хүнс болон эрүүл мэндийн үйл ажиллагаанд оролцох
- Эргэх холбоо “төгсөгч болон хоол зүйн мэргэжлээр ажиллаж буй мэргэжилтнүүдтэй уулзах” сургалт, зөвлөгөө зохион байгуулах
- Жил болгон зохион байгуулагддаг cook show тэмцээнд амжилттай оролцох
- Хоолны шим тэжээлийг судлах илчлэг ккал-ыг бодох

### Товч танилцуулга

- Байгуулсан огноо: Анх 2005 оны 10 сард анх байгуулагдан 2014 онийг хүртэл үйл ажиллагаагаа идвэхтэй явуулсан. 2018 оноос үйл ажиллагаагаа сэргээж идэвхитэй үйл ажиллагаагаа дахин явуулж эхэлсэн.



- Хамрах хүрээ: Шим тэжээл судлалын мэргэжлээр сурч байгаа мэргэжлийн оюутнууд
- *Багш:* Н.Сугар
- *Гишүүнчлэл: 16-14 эмэгтэй, 2 эрэгтэй*

**Клубийн зохион байгуулсан дотоод үйл ажиллагаа**

1. **“Хүүхэд бүрт шимт хоол” сургалт өдөрлөг оролцон зохион байгуулсан**

10-р сарын 12-ны өдөр Хүүхдийн ордонд

Шим тэжээл судлалын төвөөс хэрэгжүүлсэн “Улаанбаатар хотын цэцэрлэгийн хүүхдийн хоол, шим тэжээл – хоол үйлдвэрлэл, үйлчилгээний менежментийг сайжруулах” төслийн хүрээнд “Хүүхэд бүрт Шимт хоол” сургалт өдөрлөгийг зохион байгуулсан. Өдөрлөгт Улаанбаатар хотын 241 цэцэрлэгийн 700 гаруй эцэг эхийн төлөөлөл хамрагсан.Сургалт өдөрлөгөөр эцэг эхчүүдэд гэр бүлийн өдөр тутмын хүнсний бүтээгдэхүүнээ зөв сонгох талаар үзүүлэх сургалт явуулж, төрөл бүрийн ундаа, жүүсэнд агуулагдах чихрийн хэмжээ болон хүүхдийн хоногийн хоол, хүнсээр авах шимт бодисыг агуулсан жишиг хоолны загвар, хүүхдийн амны хөндийн эрүүл мэнд, гарын ариун цэвэр ба бохир гараар дамжих өвчлөлийн талаар анхан шатны боловсрол олгох багц сургалтын материалаас бүрдсэн үзэсгэлэнг гаргав.







2. **“БИДНИЙ ҮЙЛДЭЛ БИДНИЙ ИРЭЭДҮЙ: ЭРҮҮЛ ХҮНС-ЗӨВ ХООЛЛОЛТ” сэдвийн хүрээнд зохион байгуулагдсан дэлхийн хүнсний өдөрлөгт оролцов.**

Сүхбаатарын талбай дээрНҮБ-ын Хүнс Хөдөө Аж Ахуйн Байгууллага (ХХААБ) үүссэн өдөр буюу жил бүрийн 10-р сарын 16-ныг “Дэлхий хүнсний өдөр” болгон тэмдэглэдэг. Энэхүү өдөрлөгт ШУТИС-ийн Үйлдвэрлэлийн Технологийн сургуулийн шим тэжээлийн салбарын NCN клуб “Шим тэжээл судлалын төв” хамтран оролцсон.Тус өдөрлөгийн үеэр зөв зохистой хооллолт, таргалалтын үеийн хооллолт, зүрх судасны өвчний үеийн хооллолт зэрэг гарын авлагыг 200 гаруй хүмүүст тарааж, зөвлөгөө өгөв.




3. **Хоол зүйчдийн өдөрлөг мэргэжлийн өдөрлөг**

11-р сарын 01-ны өдөр ШУТИС-Номын сандӨдөрлөгт хоол зүй шим судлалын төвийн багшийн мэргэжилтнүүд,бакалавр, магистрын оюутнууд, хоол зүйн мэргэжлээр ажиллаж байгаа хоол зүйчид мөн Япон улсын хоол зүйч ирж оролцсон.Энэхүү өдөрлөгийн хүрээнд хоол зүйн мэргэжлийг оюутнуудад ажлын байрны мэдээ мэдээлэл салбар бүрийн онцлог одоо явагдаж буй судалгаа болон Япон улсын хоол зүй мэргэжлийн онцлог, шинж чанар, хөгжлийн төвшин зэрэг сэдвүүдийн тухай ярилцаж мэдээлэл авч нэгэн өдрийг мэргэжлийн оюутнууд үр бүтээлтэй өнгөрөөсөн.



4. **“Cook show 2020” тэмцээнд амжилттай оролцсон**

11-р сарын 16, 30-ны өдөр ШУТИС-Номын сан MEAL PLUS-д жил бүр уламжлан зохион байгуулагддаг “Cook show” тэмцээнийг энэ жил ШУТИС-ийн ахлах багш, доктор Сэржмядаг багштай ХҮҮТ 4 ангийн хамт олон амжилттай зохион байгуулсан.Хоол зүй мэргэжлийн NCN клубийн гишүүд амжилттай оролцож гэр гэртээ тогооч байгууллагын шагналыг авсан.








5. **Аймаг орон нутгийн цэцэрлэг сургуулиудын хоолны цэсэн дээр ажилсан**

13-15-р 7 хоногийн хугацаанд хичээлийн цагаар болон клубийн үйл ажиллагааны шугамаар тухайн цэцэрлэгүүдийн хоолны цэс технологи картан дээр ажиллаж хоолны түүхий эдийг тулган илчлэг ккал-ыг бодож засаж өгсөн. Үүнийг клубийн зөвлөх багш Н.Сугар хянаж шалгасан.

**Клубүүдийн нэгдсэн үйл ажиллагааны болон сайн дурын үйл ажиллаагааны оролцоо идэвх**

1. ШУТИС-ийн 60 жилийн ойн тоглолтонд оролцсон




2. Клубийн ахлагч нарыг чадваржуулах сургалт






**Үр дүн**

- Клуб хийгээд клубийн гишүүдийн байгаар ажиллах чадвар хамт олны хандлага өөрчлөгдөх
- Нийгмийн эрүүл мэндийг дээшлүүлэх үйл ажиллагааг чанартай зохион байгуулсан
- Клубийн гишүүдийн мэргэжилдээ хандах хандлага болон хүмүүстэй харилцах харилцаа дээшилсэн

# “FLAIR” клубийн 2019-2020 оны хичээлийн жилийн намрын улирлын тайлан

**Flair клубийн тухай**

Flair клуб нь анх 2006оны 1сард тус сургуулийн багш К.Жанбота, П.Энхжаргал нарын удирдлаган доор нийтдээ 10 хүний бүрэлдэхүүнтэй үүсгэн байгуулсан бөгөөд тэр цагаас хойш 3 болон 4-р курсын оюутнуудад уламжлагдан явсаар 13дахь жил болж байна.

**Зорилго:**

Flair клубийн эрхэм зорилго нь оюутан залуусыг бүх талаар дэмжин хөгжүүлж оюутан залуусын чөлөөт цагыг зөв боловсон өнгөрүүлэх, суралгын чанарыг дээшлүүлэх сургуулиа бусдад суртачилан таниулах болон их дээд сургууль, клуб, оюутны байгууллагуудтай хамтран үйл ажиллагаа явуулахад оршино.

**Зорилт:**

- Оюутан залуусын сурах идэвхи сонирхолыг дээшлүүлэх мэргэжлийн уралдаан тэмцээн зохион байгуулах.
- Дээд болон доод курсын оюутнуудыг холбох, харилцан бие биедээ зөвөлгөө өгөх туршлага солилцох бололцоог бий болгох, хамтран ажиллах боломжоор хангах.
- Холбогдох гадаад болон дотоодын байгууллагуудтай туршлага солилцох.
- Монгол улсын хэмжээнд сургуулийн нэр хүндийг өсгөж олон тэмцээн уралдаанд амжилт үзүүлж ШУТИС-д бусдын манлай түүчээ клуб болох.

**Flair клубийн зохион байгуулсан дотоод үйл ажиллагаа**

1. **Өрөөгөө хүлээн авч цэвэрлэгээ болон чимэглэл хийсэн.**

**Flair клубийн зохион байгуулсан дотоод үйл ажиллагаа**





2. Шинэхэн гишүүдийг хооронд нь идэвхижүүлж 7 хоногийн даваа болон бямба гаригуудад хоолны өдрийг бий болгосон.







3. Шинэхэн гишүүдийг хооронд нь танилцуулах зорилготой амралтын нэг өдрийг цэвэр агаарт гарч, Шарга морьт-д байрлах уулруу явган аялал хийж, хөгжилтэй тоглоом тоглож цагийг зугаатай, үр бүтээлтэй өнгөрөөсөн. /бүх гишүүдийн оролцоотой /



4. Өөрсдийн гэсэн өнгө төрхийг бий болгон бомбертэй болсон.



5. 2014 онд байгуулагдсан Карандаш ххк нь интерьер зураг төсөл, гүйцэтгэл, тавилгын дизайн, тавилга үйлдвэрлэл барилгын засал чимэглэлээр үйл ажиллагаа явуулж буй үйлдвэрт очиж нэг өдрийн практик дадлагат гаран туршлага хуримтлуулсан .





6. Art, Design, Archtecture сэдвийн хүрээнд оюутан залуусын бүтээлийн үзэсгэлэн, эрдэм шинжилгээ, воркшоп, сургалтыг ШУТИС-ын Pro Arte clubтэй хамтран зохион байгуулсан бөгөөд. Тэрхүү формынхоо бүтээлийн үзэсгэлэнд судалбар, хуулбар, интерьер зураг болон эрдэм шинжилгээний бүтээлүүдээр амжилттай оролцсон.



7. Өвөр Монголын “Үндэсний Үзэсгэлэнгийн танхим”. Урлаг, дизайны хамтарсан үзэсгэлэн. Алтан хулгана 2019









AWARD CERTIFICATE of
China and Mongolia College Students Design Art Exhibition

中蒙大学生设计艺术展获奖证书

China and Mongolia College Students Design Art Exhibition Award Certificate

Flair club

您的作品 Tuuchee 被评为中蒙大学生设计艺术展优秀作品奖，兹授予获奖证书，以资鼓励。

Your art work " Tuuchee complex project " has been appraised as an Outstanding Work Prize by The China and Mongolia College Students Design Art Exhibition. You are awarded this Honor Certificate for encouragement.

中蒙大学生艺术设计展组委会
内蒙古大学创业学院/蒙古国科技大学
2019年7月



AWARD CERTIFICATE of
China and Mongolia College Students Design Art Exhibition

中蒙大学生设计艺术展获奖证书

China and Mongolia College Students Design Art Exhibition Award Certificate

Flair club

您的作品 Tasun 被评为中蒙大学生设计艺术展优秀作品奖，兹授予获奖证书，以资鼓励。

Your art work " Tasun " has been appraised as an Outstanding Work Prize by The China and Mongolia College Students Design Art Exhibition. You are awarded this Honor Certificate for encouragement.

中蒙大学生艺术设计展组委会
内蒙古大学创业学院/蒙古国科技大学
2019年7月



AWARD CERTIFICATE of
China and Mongolia College Students Design Art Exhibition

中蒙大学生设计艺术展获奖证书

China and Mongolia College Students Design Art Exhibition Award Certificate

Flair Club

您的作品 Tuuchee 被评为中蒙大学生设计艺术展优秀作品奖，兹授予获奖证书，以资鼓励。

Your art work " " has been appraised as an Outstanding Work Prize by The China and Mongolia College Students Design Art Exhibition. You are awarded this Honor Certificate for encouragement.

中蒙大学生艺术设计展组委会
内蒙古大学创业学院/蒙古国科技大学
2019年7月

8. Алтан хулгана 2019



9. Доече вэллэ ххк-аас зохион байгуулсан Хуваалцья төслийн интерьер дизайны уралдаанд клубээ төлөөлөн 2гишүүн оролцож шагналт байр эзэлсэн.







10. Японы IWATE их сургуулийн нэрэмжит ART&TOHOKU наадамд амжилттай оролцсон .


賞状
Certificate of Contribution
This certificate is presented to
Flair club
In recognition of his contribution to the Competition Art & Technology Tohoku 2019
あなたは「アート&テクノロジー東北2019」に於いて頭書の通り優秀な成績をおさめられましたので これを賞します
In recognition of your excellent work presented at the Competition for Art & Technology Tohoku 2019
2019年7月13日 July 13, 2019
「アート&テクノロジー東北2019」実行委員会
Art & Technology Tohoku 2019




11. Дорнын жим карго-ын шинэчлэсэн постерын 30нь скиз санаа гаргасан.







12. Шинэ үеийн манлайлагчид, залуу мэргэжилтнүүдийн хамгийн том цугларалт болох Unplug2019д Unread-ыхантай хамтран цомын ажлыг хариуцаж хийсэн .




13. Хичээлийн 8-р байрны барилгын ажил 2019оны 11р сарын 25ны өдөр ашиглалтанд орсон бөгөөд тухайн барилгын 8 болон 11р давхарын интерьер зураг төслийг гарган хариуцуулан хүлээлгэж өгсөн.





14. Хийгдсэн интерьер төслийн ажлууд.







# “Арга билэг” клубийн 2019-2020 оны хичээлийн жилийн намрын улирлын тайлан

**Клубийн товч танилцуулага**

ШУТИС-ийн ҮТС-ийн “Хүнсний чанар аюулгүй байдал”-ын “Арга билэг” клуб нь эрүүл чанартай хүнсний ач холбогдлыг бусдад сурталчилах, клубийн гишүүдийн мэдлэг чадварыг дээшлүүлэх замаар ирээдүйн шилдэг мэргэжилтэнг бэлтгэхэд дэмжлэг болох үүднээс 2013 оны 4-р сард Хүнс үйлдвэрлэлийн технологи, эрүүл ахуй ангийн 3-р курсын оюутнуудын санаачлагаар, “Аюулгүй хүнс - Амьдралын баталгаа” гэсэн уриатай, нийт 30 хүний бүрэлдэхүүнтэйгээр үүсгэн байгуулагдсан.

2018 оны намрын улиралаас эхлэн эрчимтэй үйл ажиллагаа явуулж эхэлж байгаа бөгөөд “Хүнсний чанар аюулгүй байдал” мэргэжлийн 45 оюутны бүрэлдэхүүнтэй зөвлөх багш Х.Мөнхзаяа-н удирдлаган доор тууштай ажиллаж эхэлж байна.

**Клубийн  зорилго:**

ШУТИС-ийн нийт оюутан залууст хүнсний ач холбогдол аюулгүй байдлын талаарх мэдээллийг хүргэж, мэдлэгийг дээшлүүлж улмаар хүнсний чиглэлээр суралцаж буй оюутан залуусыг нэгтгэн чадварлаг мэргэжилтэн, боловсон хүчин болоход нь тусалж дэмжих, хамтран ажиллахад оршино.

**Клубийн үйл ажиллагааны чиглэл**

- Хүнсний салбарт гарсан шинэ соргог мэдээллээр түргэн шуурхай хангах;
- Ижил төрлийн үйл ажиллагаа явуулдаг холбоод, эвлэлүүдтэй зөвшөөрөгдөх хүрээнд хамтран ажиллах;
- Эрдэм шинжилгээний болон хүнсний үйлдвэр, лабораториудтай очиж танилцах
- Нийт оюутан залуусынхаа эрдэм мэдлэг, эрүүл мэндэд чиглэсэн арга хэмжээнүүдийг зохион байгуулах;
- Лекц, семинар зохион байгуулах;
- Бусад олон төрлийн үйл ажиллагаагаар оюутнуудаа мэдээллээр ханган мэдлэгийг баяжуулан ажиллана.
- Тэмцээн уралдаан болон ЭШХ-д баг хамт олноороо оролцох

- Тэмцээн уралдаан болон ЭШХ-д баг хамт олноороо оролцох

**Клубийн хурал:**

**Арга билэг** клуб нь 2019 оны намрын улиралд долоо хоног бүрийн 1 дахь өдрийн 18:00 цагаас клубийн хурлаа тогтмол хийдэг. Хурал хийх болгондоопротокол хөтөлдөг.Протокол хөтлөгч “Хүнсний чанар аюулгүй байдал” мэргэжлийн IV-р курсийн оюутан А. Мөнхзаяа

**Клубийнхурлаархэлэлцдэгасуудлууд:**

- ❖ Хэргэжүүлэх үйл ажиллагаа, шинэ санаа
- ❖ Ажил хуваарилалт, ажлын зохион байгуулалт
- ❖ Мэргэжлийн хичээлийн давтлага
- ❖ Шинэ мэдээ, мэдээлэл түгээх;

**Арга билэг”** клуб нь 2019 онд дараах бүрэлдэхүүнтэйгээр ажиллаж байна.

•**Удирдагч багш:** ҮТС- Биотехнологи, шим судлалын багш: Х. Мөнхзаяа

•**Клубийн дарга:** Хүнсний чанар аюулгүй байдал 4-р курсын оюутан: Б. Нарнаа

•**Клубийн нарийн бичгийн дарга**: ХЧАБ 4-р курсын оюутан: А. Мөнхзаяа

•**Сургалт хариуцсан албаны дарга:**ХЧАБ 4-р курсын оюутан: О. Сүнжидмаа

•**Олон нийт харицсан албаны дарга**: ХЧАБ 4-р курсын оюутан: Жамьянмядаг

•**Спорт, Урлагын албаны дарга**:ХЧАБ 4-р курсын оюутан: Э. Хандсүмбэрэл

•**Зурагчин:**ХЧАБ мэргэжлийн 4-р курсын оюутан: О. Цэрэн болон идэвхитэн 20 гишүүн, олон нийтийн үйл ажиллагаанд байнгын оролцдог бүртгэлтэй 40 гаруй гишүүн байна.

**Клубийн гишүүдийн задаргаа**

Хүнсний чанар аюулгүй байдал 4-р курсээс: 22

Хүнсний чанар аюулгүй байдал 3-р курсээс: 15

Хүнсний чанар аюулгүй байдал 2-р курсээс:20

Хүнсний чанар аюулгүй байдал 1-р курсээс: 5

Хүнс үйлдвэрлэлийн технологи инженер 3-р курсээс: 3

Хүнс үйлдвэрлэлийн технологи инженер 2-р курсээс: 2

| № | Үйл ажиллагаа | Зорилго | Зохион байгуулагч | Хугацаа |
|---|---|---|---|---|
| 1 | Таньд туслая аян | Шинээр элсэн орсон оюутнуудад сургуульдаа бүртгүүлэх болон бусад асуудлын талаар зөвлөгөө өгөх, туслах | Оюутны хөгжил үйлчилгээний алба болон КНЗ | VIII/20 |
| 2 | “Хамгийн сайхан бэлэг” хандивын аяны балны худалдаа | Төрөлхийн төрсний дараах доод мөчний саажилттай хүүгийн эмчилгээнд зориулах | “Арга билэг” клуб | VIII/26-VIII/30 |
| 3 | Мартагдашгүй намар аян | Анги хамт олноороо чацаргана хураалтанд явж | “Арга билэг” клуб | IX/07-08 |
| 4 | Танилцах аялал | ХЧАБ мэргэжлийн I-IV ангийн оюутнуудын хоорондын холбоог бэхжүүлж найз нөхөрлөлийн хүрээг тэлэх | “Арга билэг” клуб<br>ХЧАБ I-IV | IX/14 |
| 5 | “Цэвэр орчинд суралцая аян” Их цэвэрлэгээ | Лекцийн анги танхимыг цэвэрлэж, эрүүл орчинд суралцах | Арга билэг” клуб<br>“<br>ХЧАБ-IV | IX/21 |

| | | | | |
|---|---|---|---|---|
| 6 | Цаасаа хэмнэж модоо хайрлая аян | Сургууль дээр аягдал цаасыг цуглуулан Дахин боловсруулах үйлдвэрт адвдтушаах | “Арга билэг” клуб | IX/30-XI/26 |
| 7 | Үйлдвэртэй танилцах | Хүнсний үйлдвэрийн үйл ажиллагаа бүтээгдэхүүний үйлдвэрлэлтэй танилцах | “Арга билэг” клуб | X/09 |
| 8 | Баруун гарын дүрэм | Хотын соёл аяны хүрээнд сургуульдаа баруун гарын дүрмийг мөрдүүлэх | “Арга билэг” клуб | |
| 9 | Хүнсний тухай хуулиа мэдэцгээе | Хүнсний Чанар, Аюулгүй байдал мэргэжлийн оюутнуудад Хүнсний тухай хуулийн мэдлэг олгох | “Арга билэг” клуб | X/20-XI/20 |
| 10 | Мэргэжил суртчилах | Ерөнхий боловсролын ахлах ангийн оюутнуудад мэргэжлийн ойлголт өгөх | “Арга билэг” клуб | XI/09 |
| 11 | Төгсөгчтэй уулзах | Клубуудын гишүүдэд ажлын байрны туршлага олгох | “Арга билэг” клуб | XI/16 |
| 12 | Эрдэм шинжилгээний өгүүлэлийн судалгааг хэрхэн бичих хайх талаарх сургалт | Ахлах курсын оюутануудад диплом бичих, эрдэм шинжилгээний өгүүллэг бичихэд зөвлөгөө заавар өгөх | “Арга билэг” клуб | XI/27 |
| 14 | Их цэвэрлэгээ | Суралцах орчноо цэвэр аюулгүй байлгах | “Арга билэг” клуб | XII/03 |
| 16 | Тайлан хамгаалалт | Намрын улиралд хийсэн ажлаа дүгнүүлэх | Клубийн тэргүүлэгчид | XII/11 |

**Төлөвлөгөө ба биелэлт**

1. **Чиглүүлэгч оюутан 2019.08.20**





2. **“Хамгийн сайхан бэлэг” хандивын аян 2019.08.26-08.30**




3. **Мартагдашгүй намар аян 2019.09.07-09.08**





4. Танилцах аялал 2019.09.14



5. “Цэвэр орчинд  суралцая аян”  Их цэвэрлэгээ 2019.09.21





6. Цаасаа хэмнэж модоо хайрлая аян 2019.09.30-11.29





7. **Үйлдвэртэй танилцах 2019.10.09**





8. **Баруун гарын дүрэм**







9. **Төгсөгчтэй уулзах уулзалт 2019.10.16**





10. Мэргэжил сурталчилах аян 2019.11.08






11. Хүнсний тухай хуулиа мэдье  2019.10.20-11.20






12. Хууль сурталчлах хүнсний аюулгүй байдлыг хэрэглэгчдэд түгээх зорилгоор пэйж нээсэн







13. Эрдэм шинжилгээний өгүүлэлийн судалгааг хэрхэн хайх, бичих талаарх сургалт 2019.11.27





14. "Цэвэр орчинд суралцья" их цэвэрлэгээ 2019.12.03




## Дүгнэлт

Манай клуб нь энэ семистрийн хугацаанд клубийн үйл ажиллагаагаа тогтвортой явуулсан ба мэргэжлийн болон салбарын хүрээнд төлөвлөгөөнийхөө дагуу ажлаа тогтмол явуулж ШУТИС-иас зохион байгуулж буй ажилд идэвх санаачлагатай оролцсон.

Клубийн гишүүд семистрийн хугацаанд хичээл сурлага болон илтгэх чадварыг тодорхой хэмжээнд эзэмшиж, мэргэжлийн чиг баримжаатай болсон ба клубийн ажилд суралцан амжилттайгаар ажилалаа.

# “Mind matters” клубийн

# 2019-2020 оны хичээлийн жилийн намрын улирлын тайлан

**Клубийн зорилго:**

Мэргэжлийн хүрээнд нийт оюутнуудын харилцаа холбоог сайжруулан, хамтын үйл ажиллагаа, арга хэмжээг зохион байгуулж, мэргэжилийн болон бусад сургуулиас зохион байгуулж байгаа үйл ажилгаанд идэвхтэй оролцож ажиллах.

**Чиглэл**:

- Уулзалт
- Хэлэлцүүлэг
- Сургалт, зөвлөгөө
- Мэдээллийн үйлчилгээ

**Гишүүнчлэл** 42 - 29 эмэгтэй, 13 эрэгтэй. Одоогоор 60 гишүүнтэй болж үйл ажилгагаа явуулж байна.

**Байгуулсан огноо**: 2019:03:01

**Зохион байгуулсан ажилууд:**

Эхний үйл ажилгаа 2019 оны 9сарын 5нд клубийн хурал хийж ахлагч болон нарийн бичгийг сольж клубийн дотоод алба нарын дарга, гишүүдийг шинээр хувааж, цаашдын үйл ажиллагааг явуулж эхэлсэн.

“ZIP USER” онлайн цагийн ажлын аппликэйшнийг оюутан залууст хүргэх мэдээ мэдээлэлийг сурталчилах үйл ажилгаан дээр “IT Park”-тай хамтран ажиллаж байгаа. Одоогоор энэхүү аппликэйшн нь олон албан ёсоор нийтэд зарлагдаагүй, боловсруулж шинэчлэлт хийгдэж байгаа. Энэхүү апп-д нь дуудлагын жолооч, хүүхэд асрагч, цэвэрлэгээний ажилтан, хүргэлт гэх зэрэг ажилууд багтаж байгаа юм.

2019 оны 10 сарын 10нд “НҮБ”-ийн хүнсний өдрийг тохиолдуулан зохион байгуулсан уулзалтанд оролцсон. Үүнд:

Ц. Рэнцэнноров, Н. Нандин-Эрдэнэ, А. Должинсүрэн, Ч. Цэрэндулам, С. Гүлжар багш Г. Ариунаа нар клубээ төлөөлж оролцсон.




2019оны 10сарын20нд “ҮТС”-ийн намрын тэргүүнд баг бүрдүүлж гар бөмбөгийн тэмцээнд амжилттай оролцож 3-р байр эзэлсэн. Үүнд:

Ц. Рэнцэнноров, О. Хонгорзул, С. Баяржаргал, Б. Болормаа, С. Номинхорол, Б. Шинэцэцэг нар нь оролцсон.



2019 оны 11сарын1нд “Витафит” ХХК үйлдвэртэй танилцсан.





**Клубүүдийн нэгдсэн үйл ажиллагааны болон сайн дурын үйл ажиллаагааны оролцоо идэвх**

“Мах импекс” ХК хашааны навчыг түүж, цэвэрлэсэн.





**Төлөвлөсөн ажлын биелэлт:** 80%тай төлөвлөсөн ажилаа амжилттай зохион явуулсан.

**Дүгнэлт:**

Мэргэжлийн ур чадварыг хөгжүүлэхэд чиглэсэн сургалт, мэдээллийг зохион байгуулан түгээх, мэргэжлийн тэмцээн уралдаан зохион явуулж оюутан залуусыг  оролцуулна. (Хүнсний чиглэлийн)

# ШУТИС-ийн сайн дурын клубүүдийн тайлан

## 2019 оны шилдэг сайн дурын

## “АЙСЭК ШУТИС” клуб

## 2019-2020 оны хичээлийн жилийн намрын улирлын тайлан

powered by AIESEC

1. “Айсек ШУТИС” клубийн товч танилцуулга:

Манай клуб нь анх 2014 оны 11 сарын 22 нд анхны үйл ажиллагаа явуулж өдгөө сургуулийнхаа болон бусад сургуулийн оюутан залууст хүрч ажиллахыг эрмэлзсээр байгаа билээ. Үүсгэн байгуулагдсанаасаа хойш зөвлөх багшгүйгээр үйл ажиллагаа явуулж эхэлсэн бөгөөд жил бүр ахлагч нараа сонгуулийн өрсөлдөөн хэлбэрээр сонгон шалгаруулдаг.

Сүүлийн 3н улирлын гишүүдийн харьцааны график :






Клубийн зорилго :

- ШУТИС-ийн оюутан залуус болон Монголын Их дээд сургуулиудын залуусыг олон улсад солилцоогоор дамжуулж манлайллыг хөгжүүлэх ;
- Хувь хүнд чиглэсэн багаар ажиллах, манлайлах, илтгэх ур чадвар, анхан шатны компютер программ хангамж, санхүү менежмэнт болон гадаад хэл хөгжүүлэх үйл ажиллагааг оюутан залуус бүрт тэгш хүртээх ;
- Нийгэмд тулгамдаж буй асуудлыг шийдвэрлэхэд залуусын оролцоог




нэмэгдүүлэх ;
- НҮБ-ээс гаргаж буй Тогтвортой Хөгжлийн 17-н зорилтын дагуу төсөл хэрэгжүүлэхзэрэг болно.

Клубийн үйл ажиллагааны чиглэл :

- Олон улсын хурал семинарт хамрагдах, зохион байгуулах
- Нийгэмд болон залуучуудад чиглэсэн үйл ажиллагаа /эвэнт/ зохион байгуулах
- Дотоодын манлайлал хөгжүүлэх өвөл, зуны хурал
- Англи болон япон хэлний ярианы клуб /speaking club/
- Гишүүдэд чиглэсэн үйл ажиллагаа
- 7 хоног бүрийн хурлууд
- “Залуусын дуу хоолой” төсөлт хөтөлбөр зэрэг болно.

2. Зохион байгуулсан үйл ажиллагаа

✓ Зуны манлайллыг хөгжүүлэх бага хурал 8.11-8.15 - энэхүү хурал нь гишүүдэд зориулагдан жилд 2 удаа /өвөл болон зун/ зохион байгуулагддаг бөгөөд бид энэхүү хурлаар ирээдүйнхээ төлөвлөгөө бодлого, анхаарч ажиллах зүйлс болон гишүүдийн хувь хүний хөгжил чадваруудын тухай бүтэн 4 шөнө 5 өдрийн илтгэлийн үйл ажиллагаа болгон зохион байгуулдаг.






✓ Клуб танилцуулах гүшүүн элсүүлэх нээлттэй өдөрлөг - ШУТИС-ийн клубууд маань нэгдэн шинэ гишүүн элсүүлэх өдөрлөгт оролцон гишүүдээ бүртгэж авсан.








✓ Сургуулийн нээлтийн үйл ажиллагаа



✓ Шинэ гишүүддээ чиглүүлэх нэгдсэн сургалт 9.21- шинэ гишүүддээ айсэкийн тухай таниулах өдөрлөг



✓ Гишүүдийн дотоодын нэгдсэн уулзалт 3 удаа 10.06 ; 11.18 ; 12.07







✓

✓ Сар бүрийн чадваржуулах сургалт 10.13 - аас хойш- илтгэл болон компютерийн сургалт








✓ Гишүүдэд урам зориг өгөх үйл ажиллагаа “Халловээн 10.27”





- ✓ Гадаад хэлний ярианы клуб - англи болон япон хэлний ярианы өдөрлөг гишүүд болон оюутнуудад зориулсан. -32 оюутан







7 хоног бүрийн байнгын хурлууд - хурлаараа дамжуулан гишүүдийнхээ чадваржилт болон 7 хоног бүрийн ажлын биелэлт явцыг шалгах зорилготой.



- ✓ Солилцооны хөтөлбөр сурталчлах үйл ажиллагаа 11.04 ; 11.09 ; 11.16 -168 оюутан











3. Нэгдсэн болон бусад үйл ажиллагаанд оролцсон байдал

- ✓ Дээр дурьдсанчлан сургуулийн нээлт
- ✓ Клубуудын нээлттэй өдөрлөг
- ✓ Ахлагч нарын хурал
- ✓ ЕБС-иудад зориулсан ШУТИС-ийн мэргэжил танилцуулах өдөрлөг11.25 - энэхүү хөтөлбөрөөр ШУТИС болон ЕБС-ийн хоорондын харилцаа хамаарлыг нэмэгдүүлэх зорилгоор хэрхэн ШУТИС-д элсэх болон ямар мэргэжлүүдээр суралцах боломжтой болон ЭЕШ-танд хэрхэн бэлдэж

амжилттай өндөр оноо авах талаар сургуулиудтай уулзсан. Доорх



| Айсек Шутис клубын ЕБС-иудад зохион байгуулагдах өдөрлөгүүдийн төлөвлөгөө | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| 11 сар | | | | 12 сар | | | |
| 1-р 7 хоног | 2-р 7 хоног | 3-р 7 хоног | 4-р _хоног | 1-р 7 хоног | 2-р 7 хоног | 3-р 7 хоног | 4-р _хоног |
| Айсек Шутис клубын дотоодын үйл ажиллагаа явагдах учраас үүнд бүх гишүүдийг хамруулж ажиллана. Мөн сургуулиуд дээр очих төлөвлөгөө болон илтгэл тавих гишүүдийг сонгоно. | Албан ёсоор ЕБС-ын сургуулиудын удирдлагуудтай уулзаж, үйл ажиллагааны чиглэл болон, хүүхдүүдэд зориулсан өдөрлөгийн чиг баримжаа тусгаж ярилцана | 5-р сургууль | 23-р сургууль | 17-р сургууль | X | X | X |
| | | 50-р сургууль | 24-р сургууль | 57-р сургууль | 72-р сургууль | 49-р сургууль | X |
| | | X | 39-р сургууль | X | 37-р сургууль | X | X |

Чингэлтэй дүүргийн ЕБС-иуд

| | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| 5-р сургууль | 17-р сургууль | 23-р сургууль | 24-р сургууль | 37-р сургууль | 39-р сургууль | 50-р сургууль | 57-р сургууль | 72-р сургууль | 49-р сургу |



төлөвлөгөөгөөр ажиллахын тулд доорх 10н сургуулиудтай уулзсан ч ихэнхи сургуулиуд 2020 оны төлөвлөгөөнд энэхүү хөтөлбөрийг оруулж ажиллахаар болсон. Гэвч 72-р сургуулийн 10 болон 11-р ангийн 2 ангид танилцуулах хөтөлбөрөө амжилттай хийсэн.

- ✓ НҮБ ХҮҮХДИЙН САН- АЙСЭК -УТААНЫ ЭСРЭГ БИДНИЙ ХУВЬ НЭМЭР ӨДӨРЛӨГ 10.29 - Азийн Хөгжлийн Банк болон НҮБ-тай хамтран агаарын бохирдлын эсрэг хэлэлцүүлгийг зохион байгуулан түүн дээрээс үндэслэн гарсан санаачлагыг англи хэл дээр орчуулан Монгол дахь НҮБ-ын удирдах зөвлөлд хүлээлгэн өгсөн. Манай клубээс 9 гишүүн, оюутан залуусаас 13, Монголын Скаутын Холбоо болон НҮБ-ын удирдах зөвлөлийн гишүүд хамрагдсан.







- ✓ Unread "UNPLUG" үйл ажиллагаа 11.30 - энэхүү үйл ажиллагаа нь хамгийн том манлайлагч нарын хурал гэж явагддаг бөгөөд шинэ шинэлэг технологиуд болон иновацийн шилдэг шийдлүүдийг тайлагнадагаараа онцгой үйл ажиллагаа билээ. Энэхүү үйл ажиллагаанд Айсек ШУТИС клуб нь 2 дох жилдээ гишүүдээ хамруулж байгаа бөгөөд энэ



жил 3 гишүүнийг сайн дурын ажилтнаар зохион байгуулах багт, 5 гишүүнийг оролцогчоор оролцуулсан.

✓ Ази номхон далайн бүсийн залуучуудын хурал 11.22-11.26 : Клубийн ахлагч миний бие энэ хугацаанд Камбож улсруу “Олон улсын залуучуудын хурал ” - д амжилттай хамрагдаад ирсэн бөгөөд сургуулиа болон клубээсээ төлөөлөл болон явсандаа сэтгэл хангалуун байгаа. Энэхүү хурлын зорилго нь олон улсын залуучууд бидний хамтын ажиллагаа хаана дутагтаж хэрхэн асуудлыг шийдвэрлэх гарцыг хайх байсан. Миний хамгийн ихээр ойлгосон зүйл нь бидэнд илүү том хэмжээний сэтгэлгээ болон түүн дээр олуулаа хамтран ажиллахыг эрмэлзэх явдал байсан. Тиймээс клубуудын хамтын ажиллагааг сайжруулан сургууль дээрээ клубуудын нэр төрийг илүү нэмэгдүүлэхийг эрмэлзэж байгаа.







4. Үр дүн, дүгнэлт

✓ Монголдоо шинэхэн хамтран ажиллах байгууллагуудтай болсон. Энэ нь бидний солилцооны хөтөлбөрөөр гадаадаас ирсэн оюутан залуус маань монголын төсөл дээр ажиллахад хамтрах байгууллагууд болно.

- Jet school of english
- Open world language center
- Хас Лизинг

- Солилцооны хөтөлбөрийн тайлан - өвлийн улиралд 5 хүн солилцооны хөтөлбөрт хамрагдахаар гэрээ хийсэн.

| 2019 оны зуны улирал |
|---|

| | | |
|---|---|---|
| Мөнхчимэг | Хятад | ШУТИС-ГУУС төгсөгч |
| Анхболор | Хятад | МУБИС |

| | | |
|---|---|---|
| Сарангэрэл | Казакстан | Ажилладаг |
| Энхчимэг | Тайван | Сурдаггүй |

| 2020 оны хаврын улиралд |
|---|

| | | |
|---|---|---|
| А.Тамир | Тайланд | MIU |
| Д. Золжаргал | Тайланд | Ажилладаг |
| И. Энхжин | Тайланд | MIU |
| Г. Мөнхтуяа | Тайланд | ШУТИС-БУХС |
| М. Шинэчимэг | Индонез | ШУТИС төгсөгч |

✓ Нийт оролцсон болон зохион байгуулсан үйл ажиллагааны тайлан
Гадны үйл ажиллагаанд оролцсон - 14

Өөрсдийн зохион байгуулсан - 26

- Гишүүдэд - 14
- Нийгэмд болон оюутнуудад - 5н ерөнхий 7 удаагийн жижиг

Хамрагдсан гишүүдийн тоо : 25-21 гишүүн байнгын идэвхитэй

Хамрагдсан оюутан залуусын тоо : 213

✓ Гишүүдийн амжилт :
✓ 60 : 1000 оюутны их хурал -12 гишүүн
✓ Төслийн уралдаан тэргүүн байр 1 гишүүн - /БУХС - 3-р курс Тэмүүлэн/
✓ ШУТ-гийн англи хэлний олимпиад 1 гишүүн /СЭХ 4-р курс Хүслэн/
✓ ШУТИС 60 жилийн ойн шилдэг оюутан 1 гишүүн /БАС Энхмөрөн/
✓ "Геоэкологичдын холбоо ТББ" нэрэмжит олимпиад тэргүүн байр 1 гишүүн /ГУУС 2-Р КУРС Дамдиндорж/








6. Санал хүсэлт :

- Ахлагч нар болон клубуудын хамтын ажиллагаа - клубууд маань үйл ажиллагаагаар нэгдэн ажиллах

- Клубуудын хоорондын харилцаа холбоогоо сайжруулах үйл ажиллагаа зохион байгуулах ;

- Санхүүгийн дэмжлэг туслалцаа ;

- Бидний үйл ажиллагаа хурлын явцад оролцох ;

- Багш нар болон залуу мэргэжилтэнгүүдтэй хамтрах - залуу багш ажилчдыг солилцооны хөтөлбөрт хамруулах ;

- Маркетинг - сургуулийнхаа вэб хуудсуудаар манай клубийн үйл ажиллагаа болон бусад мэдээллүүдийг түгээх зэрэг санал хүсэлт байгаа болно

# “Meine Zukunft” Герман хэлний клубийн 2019-2020 оны хичээлийн жилийн намрын улирлын тайлан

“Meine Zukunft” Герман хэлний Клуб

Шинжлэх Ухаан Технологийн Их Сургуульд Герман хэл дээр хичээл үздэг болон Германтай хамтарсан хөтөлбөртэй хэд хэдэн мэргэжлийн анги байдаг ба бусад Герман хэлтэй оюутнуудын хүсэлтээр уг хэлний клубыг байгуулахаар шийдвэрлэж байна. Энэхүү клуб нь Герман хэл судлаж байгаа оюутнуудын хэл сурах хүсэл эрмэлзлэлийг нэмэгдүүлж, залуучуудын нийтийн болон хамтын үйл ажиллагаанд оролцох хандлагыг сайжруулах ач холбогдолтой юм.

**Эрхэм зорилго:**

Герман хэл судлаж буй оюутнуудын хэлний мэдлэгийг сайжруулах, уг хэлтэй холбогдолтой бүхийл үйл ажиллагааг зохион байгуулах болон их дээд сургуулиудын дунд хамгийн өргөн хүрээтэй Герман хэлний төв болоход бидний эрхэм зорилго оршино.

**Байнгын үйл ажиллагаа:**
• Герман хэлний түвшинг сайжруулах зорилгоор ярианы цаг, сургалт, тэмцээн уралдаан тогтмол зохиох.
• Монгол дахь бусад их дээд сургууль болон Герман хэлний сургалт, төвүүдтэй хамтарч
ажиллах.
• Гадаадын их дээд сургуульд сурч, ажиллаж, амьдарч байсан нөлөө бүхий хүмүүсийг урьж
клубийн гишүүдийн хамт сургалт, лекцийг зохион байгуулж, гадаадад сурах боломжийн
талаар, түүнд шаардагдах шалгалтуудын талаар тогтмол мэдээлэл хүргэж, бэлтгэх.
• DSH, APS, Test-DAF

**Клубийн нийт гишүүд**

Манай клуб нь нийт 69 гишүүнтэй үүнд:

- Уул уурхайн ашиглалтын технологи германтай хамтарсан 3+2 хөтөлбөрийн 1,2,3-р курсын нийт-31 оюутан.
- Инженерийн бэлтгэл Герман 1,2-р курсын нийт-37оюутан.

**Ярианы цагийг 3дахь өдөр 3-р пар сайн дурын ажлыг 4дахь өдрийн 6-р пар болгосон.**







**2-р семистрийн хөтөлбөр:**

1сарын29нд Гёте институтын багш Одонтуяа тай хийх ярилцлага.

- Герман улсын их сургуулийн талаар
- Герман хэлээ хэрхэн яаж сайжруулах
- Шалгалтанд хэрхэн бэлдэх гэх мэт.

**Meine zukunft sprachclub freizeit**





**Weinachten 2019.12.13**





Хятад хэлний клуб

# Хятад хэлний клубийн 2019-2020 оны хичээлийн жилийн намрын улирлын тайлан

## АГУУЛГА


1. Клубийн танилцуулга
2. Зохион байгуулсан үйл ажиллагаа
3. Нэгдсэн арга хэмжээнд болон сайн дурын үйл ажиллагааны оролцоо
4. Үр дүн, дүгнэлт


**1.Хятад хэлний ярианы клубийн товч танилцуулга**

Хятад хэлний клуб нь 2015 оны 10 сарын 1 нд байгуулагдсан, хамрах хүрээний тухайд ШУТИС-ийн нийт оюутныг хамарч үйл ажиллагаагаа явуулдаг сайн дурын клуб юм. Хятад хэлний болон мэргэжилтэн 6 багш, 167 гишүүнтэй энэ улирал үйл ажиллагаагаа зохион явуулсан.

Клубийн үйл ажиллагаа нь дараах зорилгуудын хүрээнд явуулж байна. Үүнд:

- ШУТИС-ийн *хятад хэл сурч буй болон сонирхож буй оюутнуудыг дэмжих*
- Хятад *хэл, соёлыг түгээн дэлгэрүүлэх*
- *Хэлний бэрхшээлгүй чадварлаг боловсон хүчинг бэлтгэхэд туслах* зорилготой.

2019-2020 оны хичээлийн жилийн клубийн ахлагчаар Гадаад хэлний сургуулийн 3-р курсийн оюутан Т.Одонцэцэг, клубийн зөвлөх багшаар Гадаад хэлний сургуулийн Ази судлалын тэнхимийн хятад хэлний багш Ц.Эрдэнэзаяа (Ph.D) нар ажиллаж байна.

Нийт идэвхитэй 167 гишүүнтэйгээс:

- 1-р курсийн 65 оюутан
- 2-р курсийн 80 оюутан
- 3-р курсийн 16 оюутан
- 4-р курсийн 6 оюутан тус тус бүртгэлтэй байдаг.

**Гишүүнчлэлийн харьцаа**




**2.Зохион байгуулсан үйл ажиллагаа**

Клубийн үйл ажиллагаа нь дараах чиглэлээр зохион байгуулагдсан. Үүнд:

1. Хятад хэлний клубийн“Танилцуулга хичээл”
2. Танд тусалъя
3. Хичээлийн нэмэлт давтлага
4. Хятад хэлний “Орчуулга”
5. Хэлэлцүүлэг “Brain science”
6. Хятад хэлний булан:题目 1：网络学习时代题目 2：音乐，使生活丰富多彩
7. Хятад хэлний булан:题目 1：一起健生题目 2：健康食品与垃圾食品
8. Хятад хэлний булан:题目 1：交友之道题目 2：聊聊考试那件“小事”
9. Хятад хэлний булан:题目 1：夜生活题目 2：聊聊旅游的事
10. Төгсөгчдийн цуврал Лекц 1
11. Төгсөгчдийн цуврал Лекц 2
12. “Монгол бичиг түргэн сурах боломж” лекц

**Танилцуулга хичээл**





50±оюутан

**2.Танд тусалья (чиглүүлэгч оюутан)**

Танд тусалья ажлын хүрээндээ ШУТТНС-ийн “Хятад хэлний танхим”, танхимын ахлах багш Саруул, мэргэжилтэн багштай хамран цаасан болон цахим мэргэжлийн ном гарын авлагыг танилцууллаа. Мөн ном буцаах төхөөрөмж ашиглах, QR код уншуулж онлайнаар ном сурах бичиг үзэж сурах болсон нь бидэнд их хялбар байлаа. 50±оюутан 2019.11.05

**Хятад хэлний “Орчуулга”**



Хөтөлбөрийнхөө хүрээнд клубийн зөвлөх Ц.Эрдэнэзаяа багш маань хятад хэлний орчуулгын хичээлээ орлоо.

40±оюутан 2019.11.08

**“Brain science” хэлэлцүүлэг**



Манай клуб уламжлал хэлэлцүүлгийнхээ хүрээнд XXI-р зууны шинжлэх ухааны шинэ чиглэл болсон тархи судлал буюу brain science сэдвээр анх удаагаа чөлөөт хэлэлцүүлгийг клубийн гишүүддээ ирээдүйн сургалт судалгаа, ажил мэргэжилдээ улам ихийг хийж бүтээх суурийг нь таниулах зорилготойгоор зохион байгууллаа. Тус хэлэлцүүлгээр оюутнууд маань тархины бүтэц, багтаамж, мэдээлэл хүлээн авах чадвар, болзолт болон болзолт бус рефлекс, хиймэл оюун ухаан гэх мэт олон чиглэл агуулгаар хоорондоо

мэдээлэл солилцсон үр өгөөжтэй хэлэлцүүлэг болж өнгөрлөө. 30±оюутан 2019.11.20

### Хятад хэлний ярианы булан



Клубийн маань гишүүнчлэлийн харьцаа хоёр ба түүнээс дээш курсийн оюутан ихтэй , хятад хэлний түвшингийн тухайд анхан дунд болон дундаас дээш түвшинтэй оюутнууд байдаг болохоор тэдний санал дээр тулгуулан шинээр санаачлан “Chinese corner” буюу “Хятад хэлний ярианы булан”-ийн хичээлээ

1. “网络学习时代, 音乐使生活丰富多彩” 2. “一起健生, 健康食品与垃圾食品” 3. “交友之道, 聊聊考试那件“小事” 4. “夜生活, 聊聊旅游的事” зэрэг өдөр тутмын ахуй амьдрал, ажил мэргэжилтэй холбоотой чөлөөт



сэдвээр санал бодлоо чөлөөтэй илэрхийлэх зорилгоор сайн дурын ажилтан Б.Дэмбэрэл, клубийн зөвлөх багш Ц.Эрдэнэзаяа, клубийн ахлагч Т.Одонцэцэг нар амжилттай зохион байгууллаа.

Оролт бүр 40 гаруй оюутан ирж хоёр хоёроороо эсвэл тав тавaараа баг болон сэдвийн хүрээнд хятад хэлээр хоорондоо санал бодлоо солилцож, асуулт хариулт бэлтгэн, харилцан суралцсан хятад хэлний түвшингээ дээшлүүлсэн оюутан залуус биднийг бүтээлчээр сурах сэдлийг төрүүлсэн үр дүнтэй хэлэцүүллэг болж өндөрлөсөн юм аа.

### Төгсөгчдийн цуврал лекц 1: “Safety share”



Клубийн санаачилсан төгсөгчдийн цуврал лекц нэгийг “Safety share” сэдвээр сургуулийн чиглэл, зорилгыг дэмжин ШУТИС-ийн хөтөлбөрийн болон ТТО-хятад хэлний ангийн оюутнуудад мэргэжлийн болон ажлын байрны аюулгүй байдал, бодитт хэрэглээг таниулах зорилгоор “MSC эрчим сүлжээ” цахилгааны инженер П.Төгсмандал, “MSC property” цахилгааны инженер Э.Мөнх-Эрдэнэ нарыг урин энэхүү лекцээ явууллаа. Зочин илтгэлч маань уламжлалт зан заншилтай холбон ажлын байрны аюулгүй байдлыг тайлбарласан. Жишээ нь: биднийг жоохон байхад уурга дээр нь гишгэж болохгүй гэсэн аюулгүй байдлыг хангахын тулд зан заншилтай холбон тайлбарлаж, том болоод учрыг мэдээд ирэхэд хамгийн гол багаж зэвсэгийн олдоц ховор гэх мэтээр тайлбарласан.

80±оюутан 2019.10.30





**Төгсөгчдийн цуврал лекц 2: “Ухаалаг орчуулагч”**

Төгсөгчдийн цуврал лекц хоёрыг “Ухаалаг орчуулагч” сэдвээр сургуулийн чиглэл, зорилгыг дэмжин 2+2 хөтөлбөрийн болон ТТО-хятад хэлний ангийн оюутнуудад мэргэжлийн хийгээд ажлын байрны орчуулгын хэрэгцээ, ухаалаг хэрэглээг таниулах зорилгоор ГХС-ийн төгсөгч ШУТИС-ийн хятад хэлний гэрээт багш Т.Баярзаяа, “Монос Фарм Трейд” ХХК-ийн гадаад харилцааны менежер, “Платформ бизнес” ХХК-ийн үйл ажиллагаа хариуцсан захирал М.Долгоржав нарыг урин лекцээ явууллаа. Уг лекцээр ухаалаг орчуулагч гэж юуг хэлэх вэ, орчуулга гэж юу вэ, хэрхэн орчуулга хийх, юу юу шаардлагатай гэх мэт олон сэдвээр мэдээллээ танилцууллаа. Лекцэнд суусан оюутнууд хятад, англи, орос хэлээр өөрсдөдөө тулгамдаж байгаа асуудлын талаар сониучлан асуусан үр өгөөжтэй лекж болж өндөрлөсөн билээ. 60±оюутан 2019.11.07





**“Зочин профессор, багшийн лекц” Монгол бичиг түргэн сурах боломж**




Клубийн уламжлалт “Зочин профессор, багшийн лекц”-ээр “Монгол бичиг түргэн сурах боломж” сэдэвт лекуийг ШУТИС-ийн “суралцахуйд суралцахуй” оюутан залуусын эх хэлний боловсрол, ирээдүйн ажлын байрны шаардлагыг дэмжих зорилгоор клубийн зөвлөх Ц.Эрдэнэзаяа багшаа урин энэхүү лекцээ явууллаа. Энэхүү лекцээр монгол бичгээ түргэн сурах аргазүйг жишээгээр тайлбарлаж өгсөн оюутан бидэнд цаг үеэ олсон үр дүнтэй лекц болсон юм.

40±оюутан 2019.11.20

## 3.Нэгдсэн арга хэмжээнд болон сайн дурын үйл ажиллагааны оролцоо

### “ABU ROBOKON” 2019 ULAANBAATAR хөгжөөн дэмжигчид



Энэ хичээлийн шинэ жил эхлэхэд МУ-д “ABU ROBOKON” 2019 ULAANBAATAR”-д олон улсын тэмцээн боллоо. Энэ тэмцээнд ШУТИС-ээс 2 баг оролцсоноос Mongolia-I баг маань 1-р байранд орсон маш том амжилт гаргасан. Уг тэмцээнээр манай клубийн гишүүд маань хөгжөөн дэмжлээ. 2019.08.25

### Зуны олон улсын сургалт




Мөн клубийн гишүүд маань олон улсын сургалтад хамрагдаад ирлээ. Клубийн 20 гаруй гишүүд маань БНХАУ-ын Чиндао хотын Шаньдун ШУТИС-д 21 хоногийн хугацаагаар явсан бол ТТО-хятад хэлний 2-р куосийн 3 оюутан шалгалт өгч тэнцэн Харбин ТИС-д 1 сарын хугацаатайгаар сургалтандаа хамрагдаад ирсэн. Тус сургалтаар зөвхөн хичээл орох биш орон орны олон оюутантай хамт зугаалж үзэсгэлэн үзэх зэрэг хичээлээс гадуурх үйл ажиллагаанд оролцоод ирсэн билээ.

### 2019-2020 оны шинэ хичээлийн жилийн нээлттэй өдөрлөг



2019-2020 оны шинэ хичээлийн жилийн нээлттэй өдөрлөгөөр салбарын яамны сайд хийгээд ШУТИС-ийн удирдлагууд нийт клубүүдийн үйл ажиллагаатай танилцлаа. 2019.08.28

### Монгол-хятадын 70 жилийн ойг тэмдэглэх соёлын цуврал арга хэмжээ

“Найрамдлын солонго тоглолт”, “Түмэн газрын цайны зам”, “Хятад кино өдрүүд”,“Аялал жуулчлалын танилцуулга” ,“Хийн дасгал сургалт” ,“Номын нээлт, үзэсгэлэн”,“Гэрэл зургийн үзэсгэлэн” зэрэг арга хэмжээнүүдэд клубийн багш, гишүүд идэвхтэй оролцлоо .

2019.08.30-09.05

### 4. Клубүүдийн нээлттэй өдөрлөг



2019.09.27-ны өдрийн клубүүдийн нээлттэй өдөрлөгөөр манай клуб үйл ажиллагаагаа танилцуулж, гишүүнчлэлээ бүртгэлээ.



**Хятад хэл, соёлын өдөрлөг**

2019-2020 оны хичээлийн жилийн намрын улирлын арга хэмжээний хүрээнд ГХС-ийн АСТ-ээс “Хятад хэл, соёлын өдөрлөг”-ийг 9 дэх жилдээ амжилттай зохион явууллаа. Тус үйл ажиллагаанд манай клубийн идэвхтэн гишүүд дуу, бүжиг, шүлэг, түргэн хэллэг, танин мэдэхүйн асуулт хариулт, хийн дасгалын үзүүлбэр, уламжлалт уран зургийг зурж үзүүлэхээс гадна хятадын уламжлалт цайны соёл, хайчилбар, зангилаа, шатар зэргийг бэлтгэж сонирхууллаа. 2019.10.01





**Хятад банкны тэтгэлэг,Мицубиши корпорацийн тэтгэлэг**



